



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 11 он 11
сарын 21 өдөр

Дугаар 31-1
143

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224003379



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он... дугаар
сарын...-ны өдөр

Дугаар ХТТ/2782

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ¹²³... хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН


000225014177

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэлд:

“II.ХЭЛЭЛЦСЭН нь: Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусгасны үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР




**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.11.14 № 1/5812
танай 2022.11.11-ны № 248/24/2

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151605547

A5 Файл.2022



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn


2022. 11. 11 № 01/7748
танай 2022. 11. 11 -ны № ХЭГ/2713 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,


Б.ЖАВХЛАН

9762005706



**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д
НИЙЦҮҮЛЭН ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ
ЗОРИЛГООР БОЛОВСРУУЛСАН СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН
ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН БУСАД ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийн зохицуулна” гэж, Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж, Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлаас төрөөс иргэдийнхээ аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийн баталгааг хангах зорилгоор 2001 онд баталсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим, хүний эрхийн баталгаанд нийцүүлэн бүхэлд нь шинэчлэн найруулж, 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 35 дугаар тогтоолоор зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсад зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж заасан.

Ийнхүү тодорхой салбарт хамаарах зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлээгүй нөхцөлд тус чиглэлд хэрэгжүүлж байгаа эрх зүйн шинэчлэлийн зорилго болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийн суурь зарчим хангагдах боломжгүй юм.

Иймд холбогдох хууль тогтоомжийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хуулийн төслийг нэгдсэн байдлаар боловсруулах шаардлагатай байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд өөрчлөлт оруулж байгаа хууль тус бүрд үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагагүй” гэж заасны дагуу 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

1.2.Практик шаардлага:

Зөвшөөрлийн тухай хуулиар хүн, хуулийн этгээдийн “хуулиар хориглосон болон хуульд зөвшөөрөлтэй эрхлэхээр зааснаас бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхлэх” эрхийг баталгаажуулж, төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглосон бөгөөд 14 чиглэлээр 249 тусгай зөвшөөрөл, 12 чиглэлээр 114 энгийн зөвшөөрөл тус тус олгохоор заасан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт “Зөвшөөрөл эзэмшиж байгаатай нь холбогдуулан зөвшөөрөл эзэмшигчийн эрхийн хязгаарлалтыг хуулиар тогтооно” гэж, мөн зүйлийн 17 дахь хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээний акт гаргахыг хориглоно” гэж заасан.

Түүнчлэн зөвшөөрөл эзэмшигчид тавигдах тусгай нөхцөл, шаардлагыг холбогдох хуулиар тогтоохоос гадна зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын болон үндэсний стандартыг дагаж мөрдөх үүрэгтэй байхаар хуульчилсан.

Өнөөдөр Монгол Улсад зөвшөөрлийн харилцааг тодорхой хэмжээгээр зохицуулж байгаа салбарын 160 гаруй хууль, үүнээс 40 гаруй хууль нь тухайн салбарын зөвшөөрлийн харилцааг нарийвчлан зохицуулсан хуулиуд байна.

Мөн судалгаанаас үзэхэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг шинэчлэх болсон нэг гол шалтгаан нь тус хуулиар нийт 19 чиглэлд 200 гаруй зөвшөөрөл олгохоор заасан хэдий ч бодит байдалд зөвшөөрлийн тоо 1600 орчим болон нэмэгдэж, иргэдийг ихээр чирэгдүүлэх болсонтой холбоотой байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын тогтоол, сайд, агентлагийн даргын тушаал, орон нутгийн Засаг даргын захирамж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор тухайн зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох болон зөвшөөрөл олгох, сунгах, цуцлахтай холбоотой журмыг салбарын онцлог нэрийн доор харилцан адилгүй байдлаар тогтоох боломжийг хуулиар олгосон нь дээрх хийдлийг үүсгэхэд хүргэжээ.

Түүнчлэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд стандартыг заавал мөрдөх биш сонгон хэрэглэх боломжтой байдлаар зохицуулсан нь бэрхшээл үүсгэж байна.

Иймд салбарын хууль тогтоомжид заасан зөвшөөрлийн төрөл, ангиллыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэхээс гадна зөвшөөрөлтэй холбоотой харилцааг захиргааны хэм хэмжээний акт буюу дүрэм, журмаар зохицуулдаг байдлыг өөрчлөх, зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд заавал мөрдөх стандартыг тогтоон хуульчлах, хэмжил зүйн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2.2-т “хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох” гэж, 2.3-т “зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах,...магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцыг зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байлгах” гэж, 2.4-т “зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох тухай шийдвэрийг хуульд заасан хугацаанд гаргах” гэж, мөн хуулийн 5.2 дугаар зүйлийн 1-д “зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авахаас үндэслэлгүй татгалзах эрхгүй бөгөөд өргөдлийг хүлээн авсан тухай зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэж, энэ тухай бүртгэлд тусгана.” гэж эрх бүхий этгээдийн үүргийг тодорхой болгох, эрх хэмжээг хязгаарлан хуульчилсан.

Мөн зөвшөөрлийн зорилго, эрсдэлийн түвшин болон тавигдах нөхцөл, шаардлага зэргийг нь харгалзан энгийн болон тусгай зөвшөөрлийг олгох журмыг ялгамжтай байдлаар зохицуулахаас гадна онцлогийг харгалзан зөвшөөрөлд тавигдах нэмэлт нөхцөл, шаардлага болон тодорхой зохицуулалтыг салбарын хуулиар тогтоохоор заасан.

Иймд тухайлсан хуульд заасан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуулийн зарчим, нийтлэг зохицуулалтад нийцүүлэхийн зэрэгцээ төрийн бүтээмж, цахим шилжилтийн бодлого болон тухайн салбарын шинэчлэл, онцлогийг харгалзан шинэчлэх шаардлагатай байна.

Түүнчлэн Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх чиглэлээр холбогдох хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу нэгдсэн журмаар хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.24-т заасны дагуу энэхүү хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан үнэлгээг тусгайлан хийх шаардлагагүй болно.

Хуулийн төслийг боловсруулахад холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, түүнчлэн зөвшөөрөл олгох бусад эрх бүхий этгээд буюу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт Засгийн газрын бус байгууллагын оролцоог хангаж, Засаг дарга, орон нутгийн хурал болон холбогдох нийтийн эрх зүйн хуулийн этгээд, мэргэжлийн холбоодоос санал авна.

Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Хэмжил зүйн тухай хууль болон зөвшөөрөл олгох харилцааг салбарын хүрээнд зохицуулж байгаа 86 хуулийн холбогдох зохицуулалт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

1.Зөвшөөрлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 2.2-т “тухайн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах”, 2.7-т “үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын болон үндэсний стандартыг дагаж мөрдөх” гэж заасанд нийцүүлэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Зөвшөөрлийн зорилго, эрсдэлийн түвшин зэргийг харгалзан тавигдах нөхцөл, шаардлагыг стандартаар тогтоож, заавал мөрдүүлэх нөхцөлийг хангах зорилгоор тодорхой төрлийн зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааны стандартыг тусгайлан баталж мөрдүүлэх зохицуулалтыг хуульчилна.

Мөн зөвшөөрөлд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо Монгол Улсын стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг тухайлсан хууль тус бүрд нэмж тусгахад анхаарна.

2.Хэмжил зүйн тухай хуульд хэмжил зүйн хяналт шалгалтын үр дүнг сайжруулах, хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтийг тусгана.

3.Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа холбогдох бусад хуульд Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1-д заасан зарчим болон дараах зохицуулалтад нийцүүлсэн нэмэлт, өөрчлөлтийг тусгана:

- Салбарын хуульд заасан зөвшөөрөл олгох, сунгахад тавигдах нэмэлт нөхцөл, шаардлагыг Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн төрөл, ангилал, мөн хуулийн 2.2, 4.1 дүгээр зүйлд заасан зөвшөөрлийн хугацаа, зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага болон салбарын онцлогийг харгалзан нягталж, зохистой байдлаар тогтооно;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 1.5 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, 4.1, 4.2 дугаар зүйлд нийцүүлэн зөвшөөрөл хүсэгч болон зөвшөөрөл эзэмшигчийн эрхийг баталгаажуулж, хууль зөрчиж хүн, хуулийн этгээдийн эрхийг хязгаарладаг байдлыг арилгана;
- Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн эрх хэмжээг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 3, 4, 6, 19 дэх хэсэг, 3.1, 3.2, 3.3 дугаар зүйлд нийцүүлэн тодорхойлж, хүнд суртал, чирэгдэл үүсгэдэг байдлыг өөрчилж, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлнэ;

- Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх болон сэргээх, хүчингүй болгох нөхцөл, журмын зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр зүйлд заасантай нийцүүлэн журамлах бөгөөд зөвшөөрөл олгох, хүчингүй болгох харилцааг хууль дагасан журмаар зохицуулдаг байдлыг өөрчилнө. Энэ хүрээнд зөвшөөрөл олгохтой холбоотой журам батлах эрх хэмжээ олгосон зохицуулалтыг хүчингүй болсонд тооцож, улмаар холбогдох зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 12, 17 дахь хэсэгт нийцүүлэн хуульд тусгана;
- Зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг нягталж, зөвшөөрлийн ангилал, хугацааны шинэчлэлтэй уялдуулж, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна;
- Зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх хариуцлагыг оновчтой тогтоож, хууль хоорондын давхардал хийдлийг арилгах зорилгоор зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг нягталж, шаардлагатай тохиолдолд Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа салбарын хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгаснаар зөвшөөрлийн харилцаатай холбоотой эрх зүйн шинэчлэл цогц байдлаар хэрэгжих боломж бүрдэнэ.

Түүнчлэн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд дэвшүүлсэн “Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоон, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулах” зорилтыг хэрэгжүүлэх бодит нөхцөл хангагдана.

Эрх бүхий этгээдийн хариуцлага сайжирч, авлига, албан тушаалын хэрэг, зөрчил буурч, бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, иргэдийн эрхийн баталгаа сайжирна.

Дөрөв.Хуулийн төслийн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж, бусад хуультай уялдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 31, 32 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу боловсруулна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу зөвшөөрлийн харилцааг зохицуулсан 89 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Авто замын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг:

“17.6.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 4.1-д заасан зөвшөөрлийг олон улс, улсын чанартай замыг сэтлэх, орц гаргах тохиолдолд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замыг сэтлэх, орц гаргах тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.”

2/33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг:

“33.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

2 дугаар зүйл.Авто замын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:

“10.2.Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага авто замын арчлалт, урсгал засварын ажлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т заасан тусгай зөвшөөрөл бүхий этгээдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.”

2/19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг:

“19.1.Авто зам, замын байгууламжийн зураг төслийг захиалагчийн баталсан зургийн даалгаврын дагуу Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.”

3/20 дугаар зүйлийн 20.1, 20.6 дахь хэсэг:

“20.1.Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд холбогдох хууль, журмын дагуу захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

20.6.Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэхэд төмөр зам, харилцаа холбоо болон цахилгааны шугам, цэвэр бохир усны хоолой, бусад барилга байгууламжийн үйл ажиллагааг түр зогсоох зайлшгүй шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээ авч ажиллана.”

4/22 дугаар зүйлийн 22.5, 22.6 дахь хэсэг:

“22.5.Авто зам, замын байгууламжийн их засварын ажлыг авто замын барилгын ажил гүйцэтгэх Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

22.6.Авто зам, замын байгууламжийн их засварын ажлын техник, технологийн хяналтыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т тусгай зөвшөөрөл бүхий этгээдүүдээс сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.”

5/23 дугаар зүйлийн 23.3.7 дахь заалт:

“23.3.7.авто замаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү овор, даацтай болон тусгай хамгаалалтгүй гинжит дугуйтай тээврийн хэрэгсэл зорчихоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 4.5-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт хариуцсан байгууллагаас зөвшөөрөл авна.”

6/33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг:

“33.2.Авто зам, замын байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан шаардлагаас гадна стандартад тусгасан мэргэжилтэй хүний нөөц, тоног төхөөрөмжийн хүчин чадал, техникийн шаардлагыг хангасан байна.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Зөвшөөрлийн тухай хуульд бусад хууль тогтоомжийг нийцүүлэн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан хуулийн тогтоомжийн төслийн талаар

Нэг.Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаар

Улсын Их Хурлаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсан бөгөөд уг хууль 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

Зөвшөөрлийн тухай хуулийг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 35 дугаар тогтоолын 1 дэх заалтаар “Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт даалгасан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсад зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна” гэж, мөн зүйлийн 3-т “Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж заасан.

Түүнчлэн тус хуулиар хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон болон зөвшөөрөлтэй эрхлэхээр зааснаас бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхлэх эрхийг баталгаажуулж, улмаар төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглосон.

Иймд зөвшөөрөл олгох харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж хоорондын зөрчил, давхардал, хийдлийг арилгах хүрээнд Стандартчлал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Хэмжил зүйн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нийт 89 хуулийн төсөл, 1 Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсрууллаа. /Хавсралтаар жагсаалтыг оруулав/

Түүнчлэн эрх зүйн шинэчлэл, төрийн захиргааны байгууллагын бүтцийг өөрчлөлттэй уялдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно” гэж заасны дагуу хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулахад холбогдох яам, төрийн захиргааны байгууллага, түүнчлэн зөвшөөрөл олгох бусад эрх бүхий этгээд буюу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт Засгийн газрын бус байгууллагын оролцоог хангаж, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага болон холбогдох нийтийн эрх зүйн хуулийн этгээд, мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан болно.

Хоёр.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар:

Зөвшөөрлийн зорилго, эрсдэлийн түвшин зэргийг харгалзан тавигдах нөхцөл, шаардлагыг стандартаар тогтоож, заавал мөрдүүлэх нөхцөлийг хангах зорилгоор 91 төрлийн тусгай зөвшөөрөл, 8 төрлийн энгийн зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны стандартыг тусгайлан баталж мөрдүүлэхээр хуульд нэмэлт оруулсан.

Мөн зөвшөөрөлд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо Монгол Улсын стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг тухайлсан хууль тус бүрд нэмж тусгахад анхаарсан болно.

Гурав.Зөвшөөрлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар:

Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, зохицуулалтын давхардал, хийдлийг арилгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4.1, 13.6-д заасан 2 тусгай зөвшөөрөл, 8.2 дугаар зүйлийн 5.2, 7.2, 10.6-д заасан 3 энгийн зөвшөөрлийг хасч, мөн 2 тусгай зөвшөөрлийг энгийн зөвшөөрлийн ангилалд шилжүүлсэн.

Эрх зүйн шинэчлэл болон салбарын үйл ажиллагааны эрсдэлийн онцлогийг харгалзан харилцаа холбооны болон байгаль орчны чиглэлээр тус бүр 2, уул уурхай болон эрүүл мэндийн чиглэлээр тус бүр 1 үйл ажиллагааг зөвшөөрөлтэй эрхлэхээр хуулийн төсөлд нэмэлт оруулсан.

Мөн төрийн бүтээмж, цахим шилжилтийн бодлогод нийцүүлэн зөвшөөрөл олгох, сунгах болон цуцлах шийдвэр төдийгүй ажиллагааны үе шат, явцын талаарх мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжид цахим хэлбэрээр ил тод, нээлттэй хүргэх, мэдээллийг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх талаар эрх бүхий этгээдийн үүргийг тодруулж, зарим төрлийн зөвшөөрөлд тавигдах шаардлага, зөвшөөрөл олгох нөхцөлтэй холбоотой нэмэлт зохицуулалтыг тусгасан болно.

Дөрөв.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар:

Хуульд заасан зөвшөөрөл олгохтой холбоотой улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг зөвшөөрлийн ангилал, хяналтын нөхцөлтэй уялдуулан шинэчилсэн.

Түүнчлэн зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой хураах улсын тэмдэгтийн хураамжийн зорилгыг харгалзан улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлсөн байхыг шаарддаг, зөвшөөрөл олгоогүй тохиолдолд хураамжийг буцаан олгодоггүй зэрэг хийдлийг өөрчлөх зохицуулалтыг тусгасан.

Өөрөөр хэлбэл, эрх бүхий байгууллага зөвшөөрөлтэй холбоотой хүсэлт, өргөдлийг хүлээн авахдаа улсын тэмдэгтийн хураамж төлөхийг шаардахгүй бөгөөд зөвхөн зөвшөөрөл олгосон, эсхүл сунгасан тохиолдолд хураамж төлөх хязгаарлалтыг хуульчилж, зарим төрлийн зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоосон.

Тав.Бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар:

Салбарын бусад хуулиар зохицуулж байгаа зөвшөөрлийн төрөл, ангиллыг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд нийцүүлж, жагсаалтад багтаагүй боловч тухайлсан хуульд заасан зөвшөөрөл болон эрх олгох зохицуулалтыг хүчингүй болгон зохицуулсан.

Зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл, шаардлагыг хэт ерөнхий, эсхүл оновчгүй байдлаар тогтоосон, түүнчлэн байгууллагын хүрээний дүрэм, журмаар зөвшөөрөл олгох харилцааг зохицуулж, хуулиас гадуур хүний эрхийг хязгаарладаг зөрчлийг арилгахад анхаарсан.

Өөрөөр хэлбэл, салбарын хуульд зөвшөөрөл олгох харилцаатай холбоотой захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтыг хүчингүй болгож, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн хариуцлагыг нэмэгдүүлж, ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор зөвшөөрөл олгох процесс ажиллагааны журам болон хугацаатай холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлд заасан зарчимд нийцүүлсэн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хуульд тусгасан.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.24-т заасны дагуу давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулагдсан тул мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан үнэлгээ, тооцооллыг тусгайлан хийх, мөн хуулийн 38.8-д заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байхыг шаардахгүй болно.

Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хууль тогтоомжийн төсөл

Д/д	Хууль тогтоомжийн төслийн нэр
1	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
2	Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
3	Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
4	Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
5	Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
6	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
7	Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
8	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
9	Аудитын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай
10	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
11	Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
12	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай
13	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
14	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
15	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
16	Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
17	Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
18	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
19	Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
20	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай
21	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
22	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
23	Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
24	Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
25	Галын аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
26	Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
27	Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
28	Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
29	Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
30	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
31	Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
32	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
33	Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
34	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

35	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай
36	Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
37	Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай
38	Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
39	Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
40	Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
41	Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай
42	Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
43	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
44	Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
45	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай
46	Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
47	Музейн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
48	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
49	Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
50	Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
51	Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
52	Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
53	Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
54	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
55	Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
56	Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
57	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
58	Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
59	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
60	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
61	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
62	Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
63	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
64	Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
65	Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
66	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
67	Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
68	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
69	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
70	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
71	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

72	Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
73	Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
74	Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
75	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
76	Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай
77	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
78	Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
79	Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
80	Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
81	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай
82	Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
83	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
84	Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
85	Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
86	Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
87	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
88	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
89	Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
90	"Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Авто замын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг:

“17.6.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 4.1-д заасан зөвшөөрлийг олон улс, улсын чанартай замыг сэтлэх, орц гаргах тохиолдолд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замыг сэтлэх, орц гаргах тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.”

2/33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг:

“33.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

2 дугаар зүйл.Авто замын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:

“10.2.Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага авто замын арчлалт, урсгал засварын ажлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т заасан тусгай зөвшөөрөл бүхий этгээдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.”

2/19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг:

“19.1.Авто зам, замын байгууламжийн зураг төслийг захиалагчийн баталсан зургийн даалгаврын дагуу Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.”

3/20 дугаар зүйлийн 20.1, 20.6 дахь хэсэг:

“20.1.Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд холбогдох хууль, журмын дагуу захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

20.6.Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэхэд төмөр зам, харилцаа холбоо болон цахилгааны шугам, цэвэр бохир усны хоолой, бусад

барилга байгууламжийн үйл ажиллагааг түр зогсоох зайлшгүй шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээ авч ажиллана.”

4/22 дугаар зүйлийн 22.5, 22.6 дахь хэсэг:

“22.5.Авто зам, замын байгууламжийн их засварын ажлыг авто замын барилгын ажил гүйцэтгэх Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

22.6.Авто зам, замын байгууламжийн их засварын ажлын техник, технологийн хяналтыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т тусгай зөвшөөрөл бүхий этгээдүүдээс сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.”

5/23 дугаар зүйлийн 23.3.7 дахь заалт:

“23.3.7.авто замаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү овор, даацтай болон тусгай хамгаалалтгүй гинжит дугуйтай тээврийн хэрэгсэл зорчихоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 4..5-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт хариуцсан байгууллагаас зөвшөөрөл авна.”

6/33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг:

“33.2.Авто зам, замын байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан шаардлагаас гадна стандартад тусгасан мэргэжилтэй хүний нөөц, тоног төхөөрөмжийн хүчин чадал, техникийн шаардлагыг хангасан байна.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.1.Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх болон автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.3, 5.5-д заасан тусгай зөвшөөрөлтэй хүн, хуулийн этгээд эрхэлнэ.

15.2.Энэ зүйлийн 15.1-д заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.4 дэх хэсэг нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг:

“18.4.Энэ хуулийн 18.1-д заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.”

2 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “6.1.1” гэсний дараа “, 6.1.2” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.6 дахь заалтын “байшин,” гэсний дараа “стандартын шаардлага хангасан дулаалгатай гэр,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.10-т заасан агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөлийг тухайн сум, дүүргийн Засаг дарга олгоно.”

4 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтын “нийслэлийн Засаг даргын” гэснийг “бүх шатны Засаг даргын” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “ажлын алба” гэснийг “Засгийн газраас томилсон эрх бүхий байгууллага” гэж, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “нэгдмэл стандартын хэрэгжилтэд мэргэжлийн” гэснийг “хяналтын стандартын хэрэгжилтэд холбогдох” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг ашиглах зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, цуцлах, хүчингүй болгох,” гэснийг, 7.1.4 дэх заалтын “алба болон энэ хуулийн 24.1-д заасан Уур амьсгалын өөрчлөлтийн ажлын” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “мэргэжлийн албатай хамтран” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.2.6 дахь заалт:

“5.2.6.хуульд заасан бусад бүрэн эрх.”

2/7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг:

“7.7.Төрийн захиргааны төв байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.7-д заасан эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор амьтныг агнах, барих зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.

3/29¹ дүгээр зүйл:

“29¹ дүгээр зүйл. Дуудлага худалдаа зохион байгуулах

29¹.1.Энэ хуулийн 20.2, 25.1, 29.1, 36.1-д заасан зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу дуудлага худалдааны журмаар олгоно.

29¹.2.Энэ хуулийн 29.1-д заасан зөвшөөрлийн дуудлага худалдааг мөн хуулийн 26.3-т заасны дагуу Засгийн газраас тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталсанаас хойш 14 хоногийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлж, 30 хоногийн дотор цахим хэлбэрээр зохион байгуулна.

29¹.3.Дэнчин төлж бүртгүүлсэн этгээд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дуудлага худалдаанд оролцоно.

29¹.4.Анхны болон хоёр дахь дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаа эхлэх босго үнийн 10 хувьтай тэнцэх хэмжээний дэнчинг дуудлага худалдаа эхлэхээс 24 цагийн өмнө холбогдох дансанд байршуулна.

29¹.5.Дуудлага худалдаа зохион байгуулагч нь дуудлага худалдаа явуулах тухай шийдвэр, төлбөрийн хэмжээг танилцуулна.

29¹.6.Анхны үнийн санал гарснаар дуудлага худалдааг эхэлсэнд тооцох ба хамгийн өндөр үнийн саналаар ялагч тодорсноор дуудлага худалдааг хаана.

Дуудлага худалдаанд оролцогчид үнийн санал гаргаагүй тохиолдолд 7 хоногийн дотор хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулна.

29¹.7. Дуудлага худалдаа зохион байгуулагч нь сүүлийн үнэ хэлэхийг зарлаж, сүүлийн үнэ тодорхой болсны дараа дуудлага худалдааг дуусгавар болгож ялагчийг зарлана. Дуудлага худалдааны ялагч нь дуудлага худалдаанд ялсан үнийг 24 цагийн дотор холбогдох дансанд бүрэн төлсний дараа зохион байгуулагч ялагчийг баталгаажуулсан шийдвэр гаргана.

29¹.8. Хэрвээ ялсан этгээд тогтоосон хугацаанд энэ хуулийн 29¹.7-д заасан төлбөрийг бүрэн төлөөгүй бол дэнчинг улсын орлого болгож, дуудлага худалдааны үед дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээдэд санал тавина.

29¹.9. Дуудлага худалдааг зохион байгуулагч дуудлага худалдааны явцад тэмдэглэл үйлдэж, дүрс бичлэгээр баталгаажуулна. Тэмдэглэлд оролцогчид болон зохион байгуулагч талын төлөөлөл гарын үсэг зурна.

29¹.10. Дуудлага худалдааны ялагч нь тэмдэглэл болон гэрээнд гарын үсэг зурахаас зайлсхийсэн тохиолдолд дэнчингээ алдана.

29¹.11. Энэ хуулийн 29¹.7-д заасан төлбөрийг төлөхөд дуудлага худалдаанд оролцохдоо урьдчилж төлсөн дэнчинг үнийн дүнд оруулж тооцно.

29¹.12. Дараах тохиолдолд хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулна:

29¹.12.1. дуудлага худалдаанд нэг оролцогч ирсэн;

29¹.12.2. дуудлага худалдаанд оролцогчид үнийн санал гаргаагүй;

29¹.12.3. дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан зөвшөөрлийн үнийг заасан хугацаанд бүрэн төлөөгүй бөгөөд дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээдэд санал болгож татгалзсан тохиолдол.

29¹.13. Дуудлага худалдаанаас олсон нийт орлогын 50 хувийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.1-д заасан Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлнэ.

29¹.14. Энэ хуулийн 29.1-д заасан зөвшөөрлийн дуудлага худалдааны эхлэх босго үнийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

4/36 дугаар зүйлийн 36.7, 36.8 дахь хэсэг:

36.7. Энэ хуулийн 36.1-д заасан зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч, магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлж, шийдвэр гаргуулахаар магадлан шалгах ажиллагаа дууссанаас хойш ажлын хоёр өдөрт Засгийн газарт хүргүүлнэ.

36.8. Засгийн газар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох саналыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэр гаргана.”

2 дугаар зүйл. Амьтны тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалт:

“5.2.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 5-д заасны дагуу сүргийн бүтцийн төлөв байдал, тархац, нөөцийг харгалзан тухайн агнуурын бүс нутагт ан хийх, эсхүл зарим зүйл агнуурын амьтныг агнах, барихыг тодорхой хугацаагаар хязгаарлах;”

2/5 дугаар зүйлийн 5.7.2 дахь заалт:

“5.7.2.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.11-д заасан зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу иргэн, хуулийн этгээдэд олгох;”

3/7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:

“7.6.Ховор амьтны жагсаалтыг Засгийн газар батална.”

4/25 дугаар зүйлийн 25.1, 25.5 дахь хэсэг:

“25.1.Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл тус тус авч, гэрээ байгуулна.

25.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.23, 1.24, 8.2 дугаар зүйлийн 1.12-т заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 26.2, 26.3-т заасан агнуурын амьтны тоо хэмжээнд багтаан харьяалах нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгож болно.”

5/36 дугаар зүйлийн 36.1, 36.2, 36.3, 36.4, 36.5 дахь хэсэг:

“36.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.1-д заасны дагуу нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар олгоно.

36.2.Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 36.1-д заасан амьтнаас бусад амьтныг амьдаар нь, мөн амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг улсын хилээр нэвтрүүлэх хүсэлтийг төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

36.3.Энэ хуулийн 36.2-т заасан улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг Генетик нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

36.4.Харь амьтныг нутагшуулах, өсгөж үржүүлэх зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.13-т заасан төрийн захиргааны төв байгууллага олгоно.

36.5.Нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг Засгийн газар, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.”

3 дугаар зүйл.Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Нэн” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.5-д заасны дагуу нэн” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “ашиглахыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ” гэснийг “ашиглахын тулд төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулна” гэж, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “Иргэн, хуулийн этгээдэд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.15-д заасан” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “энэ хуулийн 25.5-д заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга” гэж, 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсгийн “36.1, 36.2-т” гэснийг “36.1-д” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалт, 19 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.6 дахь хэсэг нэмсүгэй:

“5.6.Энэ хуулийн 5.2.5-д заасан зөвшөөрөл олгох асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Соёлын өвийг хамгаалах тухай хууль,” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хууль,” гэж нэмсүгэй:

3 дугаар зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“26.2.Архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд архивын баримтыг хадгалуулах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулна.”

4 дүгээр зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4, 26.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.29, 4.1.30, 4.1.31 дэх заалт:

“4.1.29. “сонгон шалгаруулалтын талбайн тодорхойлолт” гэж сонгон шалгаруулалтын талбайн дугаар, байрших аймаг, сум, нэр, хэмжээ, солбицол, байршлын зургийг;

4.1.30. “сонгон шалгаруулалтын босго үнэ” гэж ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласан талбайн нэг гектар тутамд тооцож нийт талбайн хэмжээд тогтоосон мөнгөн дүнг;

4.1.31. “сонгон шалгаруулалтын комисс” гэж геологи, хууль эрх зүй, уул уурхайн салбарын мэргэжил эзэмшсэн, геологийн судалгаа, хайгуулын төлөвлөгөө, тайланг үнэлэх мэргэжлийн чадвар, туршлагатай энэ хуулийн 10.4-т заасан бүрэлдэхүүнийг.”

2/6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт:

“6.1.4. үүсмэл орд.”

3/7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг:

“7.7. Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 7.1-д зааснаас гадна ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй үүсмэл орд ашиглах зорилгоор гэрээ байгуулсан хуулийн этгээдэд олгоно.”

4/10 дугаар зүйлийн 10.1.19, 10.1.20 дахь заалт, 10.2, 10.3, 10.4 дэх хэсэг:

“10.1.19. энэ хуулийн 11¹.1.5-т заасан талбайг хянаж, сонгон шалгаруулалт зарлах талбайг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

10.1.20. стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох асуудлаар санал, дүгнэлт гаргах;”

10.2.Энэ хуулийн 18.1.4-т заасан нэгтгэсэн техникийн саналыг үнэлэх маягт, техникийн болон үнийн саналыг үнэлэх аргачлалыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.3.Энэ хуулийн 18.1.7-д заасан босго үнийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.4.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах үүрэг бүхий сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

5/11 дүгээр зүйлийн 11.1.26, 11.1.27, 11.1.28 дахь заалт:

“11.1.26.энэ хуулийн 9.1.11-д заасан талбайд сонгон шалгаруулалт явуулахыг хориглосон талбай давхцаж байгаа эсэхийг шалгаж, давхацсан тохиолдолд тухай хэсгийг хасаж, мэдээллийг Үндэсний геологийн албанд хүргүүлнэ.

11.1.27.сонгон шалгаруулалтын урилгын маягт, загварыг батална.

11.1.28.ашигт малтмалын хайгуул, ашиглалтын болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийн хөдөлгөөнтэй холбогдсон загвар, маягыг батална.”

6/11¹ дүгээр зүйлийн 11¹.1.5, 11¹.1.6 дахь заалт:

“11¹.1.5.энэ хуулийн 11.1.26-д заасан талбайн мэдээллийг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны үр дүнд тогтоосон ашигт малтмалын нөөц, баялаг, эрдсийн хуримтлалтай эсэхийг нягталж, талбайн геологийн мэдээллийг бэлтгэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

11¹.1.6.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад талбайн мэдээллийг хүргүүлэхдээ энэ хуулийн 17.5.1, 17.7-д заасан шаардлагыг хангасан байна.”

7/18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалт:

“18.1.8.энэ хуулийн 18.1.1-18.1.7-д заасан баримт бичгийг цахим хэлбэрээр хүсэлт хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээнэ.”

8/20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг:

“20.5.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход дараах зарчмыг баримтална.

20.5.1.сонгон шалгаруулалтын комисс нь энэ хуулийн 20.2.3-т заасан дүгнэлтийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад ажлын нэг өдөрт багтаан хүргүүлнэ.

20.5.2.геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдөрт багтаан холбогдох шийдвэрийг гаргана.

20.5.3.шалгарсан оролцогчид тусгай зөвшөөрөл олгох боломжтой тухай ажлын хоёр өдөрт багтаан мэдэгдэж, сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүүг ажлын 10 өдрийн дотор төлөх тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

20.5.4.сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүүг төлсөн оролцогчид тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг мөн хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай мэдэгдлийг хоёр өдөрт хүргүүлнэ.

20.5.5.энэ хуулийн 20.5.3, 20.5.4-т заасны дагуу мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш заасан хугацаанд сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, эхний жилийн төлбөрийг төлөөгүй бол төрийн захиргааны байгууллага мэдэгдлийг хүчингүй болгож энэ тухай бичгээр ажлын хоёр өдөрт мэдэгдэнэ.

20.5.6.энэ хуулийн 20.5.3, 20.5.4-т заасан төлбөрийг мэдэгдэлд заасан хугацаанд төлөөгүй оролцогчид босго үнийг буцаан олгохгүй.”

9/24¹ дүгээр зүйл:

“24¹ дүгээр зүйл.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлага

24¹.1.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд уг тусгай зөвшөөрлийг эзэмшигч, эсхүл тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй үүсмэл орд ашиглах тухай гэрээ байгуулсан гуравдагч этгээд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргана.

24¹.2.Үүсмэл орд ашиглах тухай гэрээнд дараах асуудлыг тусгасан байна:

24¹.2.1.орд ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтэц;

24¹.2.2.газар, ус ашиглах болон тусгай зөвшөөрлийн төлбөр, бусад төлбөр, хураамж;

24¹.2.3.эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй ажиллагаа;

24¹.2.4.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ордын хаалт.

24¹.3.Үүсмэл орд дахь ашигт малтмалын нөөц, агуулгын хэмжээг эрх бүхий байгууллагаар тодорхойлуулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

24¹.4.Үүсмэл орд ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулсан байна.

24¹.5.Энэ хуулийн 24¹.1-д заасан өргөдөлд үүсмэл ордын талбайн булангийн цэгийг төрийн захиргааны байгууллагаас баталсан нэг загварын газрын зураг дээр тэмдэглэж, солбицлуудыг градус, минут, секундээр тодорхойлж хавсаргана.

24¹.6.Үүсмэл ордын талбай нь орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлээр тодорхойлогдсон байх ба тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглосон, хязгаарласан талбайтай давхцалгүй байна.”

10/25¹ дугаар зүйл:

“25¹ дугаар зүйл.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам

25¹.1.Энэ хуулийн 24¹.1-д заасан үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

25¹.1.1.хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, факсны дугаар, цахим шуудангийн хаяг, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны нэрийг тусгасан тодорхойлолт;

25¹.1.2.ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үүсмэл орд ашиглах тухай гэрээ байгуулсан гуравдагч этгээдэд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахыг зөвшөөрсөн албан ёсны зөвшөөрөл;

25¹.1.3.энэ хуулийн 24¹.1-д заасан шаардлагыг хангаж байгааг нотлох баримт;

25¹.1.4.энэ хуулийн 24¹.5-д заасны дагуу хийгдсэн талбайн зураг ба ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар;

25¹.1.5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5-д заасан үйлчилгээний хөлс төлсөн баримт;

25¹.1.6.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

25¹.1.7.үүсмэл ордын нөөц, агуулгын хэмжээ, орд ашиглах болон боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцсэн дүгнэлт, шийдвэр;

25¹.1.8.энэ хуулийн 10.1.19-т заасан санал, дүгнэлт.”

11/26¹ дугаар зүйл:

“26¹ дугаар зүйл.Өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа

26¹.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 24¹.1-д заасан өргөдлийг хүлээн авмагц доор дурдсан ажиллагаа явуулна:

26¹.1.1.өргөдлийг өргөдөл бүртгэх дэвтэрт бүртгэж өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудас тус бүрт бүртгэлийн огноо, хугацаа, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх;

26¹.1.2.үүсмэл ордын талбай нь ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хилийн дотор багтаж байгаа эсэх;

26¹.1.3.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 24¹ дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих.

26¹.2.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26¹.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш 30 хоногт багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

26¹.2.1.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 24¹ дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй болон 25¹ дугаар зүйлд заасан баримт бичгийн бүрдэл дутуу бол хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж шалтгаан, үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, энэ тухай өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэх;

26¹.2.2.хүсэлтэд дурдсан талбай нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн гадна талд, эсхүл хил дамнасан бол үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, шалтгаан үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, энэ тухай өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэх;

26¹.2.3.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн шаардлагыг хангасан бол хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн тухай хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

26¹.3.Өргөдөл гаргасан этгээдэд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг 3 /гурав/ жилийн хугацаагаар олгож, тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

26¹.4.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигч этгээдийн нэр, хаяг болон үүсмэл ордын талбайн булангийн цэгийн солбицлуудыг тэмдэглэх бөгөөд уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тэмдэглэх зориулалт бүхий хавсралттай байна.

26¹.5.Төрийн захиргааны байгууллага татгалзсан шийдвэр гаргасан бол өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг өргөдөл гаргасан этгээдэд буцааж өгнө.

12/27 дугаар зүйлийн 27.1.15 дахь заалт:

“27.1.15.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 4.1.27-д заасан үүсмэл ордыг бусад этгээдэд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн гэрээгээр ашиглуулж болно.”

13/28¹ дугаар зүйл:

“28¹ дугаар зүйл.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл сунгах

28¹.1.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 25¹.1-д заасны дагуу өргөдөл гаргана.

28¹.2.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл сунгуулах тухай өргөдлийг энэ хуулийн 26¹ дахь зүйлд заасны дагуу бүртгэж, хянан шийдвэрлэнэ.

14/66 дугаар зүйлийн 66.5 дахь хэсэг:

“66.5.Үүсмэл орд ашиглах тухай гэрээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан зарим үүргээ үүсмэл ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлсэн нь түүнийг Ашигт малтмалын тухай хууль болон бусад хуульд заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль” гэсний дараа “, Зөвшөөрлийн тухай хууль” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтын “бусад үйл ажиллагааг” гэсний дараа “гэрээний үндсэн дээр гүйцэтгэх” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалтын “сонгон шалгаруулалтад оролцох” гэсний дараа “, үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийн” гэж, 17 дугаар зүйлийн гарчигийн “олгох” гэсний дараа “сонгон” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалтын “эзэмшигч” гэсний дараа “, үүсмэл орд гэрээгээр ашиглагч хуулийн этгээд;” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт:

“10.1.2.сонгон шалгаруулалтын журмыг батлах;”

2/11 дүгээр зүйлийн 11.1.19 дэх заалт:

“11.1.19.түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох;”

3/17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг:

“17.4.Энэ хуулийн 10.1.19-т заасан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайд сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй өдрийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.”

4/18 дугаар зүйлийн 18.1.7 дахь заалт, 18.2 дахь хэсэг:

“18.1.7.сонгон шалгаруулалтын талбайн хэмжээнд ногдох босго үнэ төлсөн баримт;

18.2.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 18.1-д заасан хүсэлтийг хүлээн авч, бүртгэл хаагдсаны дараа ирүүлсэн хугацаагаар эрэмбэлж, жагсаалт гаргана.”

5/20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг:

“20.1.Сонгон шалгаруулалтын үнийн саналыг үнэлэхэд дараах зарчмыг баримтална.

20.1.1.сонгон шалгаруулалтын үнийн саналыг үнэлэхдээ бүртгэл хаагдсан өдрийн дараагийн ажлын өдрөөс эхлэн үнэлгээг нээлттэйгээр нийтэд мэдээлнэ;

20.1.2.үнийн саналын оноо нь энэ хуулийн 10.1.20-т заасан аргачлалаар тогтоосон босго оноонд хүрээгүй тохиолдолд техникийн саналд үнэлгээ хийхгүй бөгөөд нийтэд нээлттэй мэдээлнэ.

20.2.Сонгон шалгаруулалтын техникийн саналыг үнэлэхэд дараах зарчмыг баримтална.

20.2.1.сонгон шалгаруулалтын комисс нь үнийн саналыг нээснээс хойш ажлын 5 өдрийн дотор энэ хуулийн 10.2-т заасан маягтын дагуу техникийн саналыг үнэлнэ.

20.2.2.сонгон шалгаруулалтын комисс нь энэ хуулийн 18.1-д заасан шаардлага хангаагүй хүсэлтийн техникийн саналыг үнэлэхгүй бөгөөд үндэслэл, шалтгааныг хүсэлт гаргасан хуулийн этгээдэд мэдэгдэнэ.

20.2.3.сонгон шалгаруулалтын комиссын гишүүдийн баталгаажуулсан техникийн саналын оноог үнэлгээ хийж дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор оролцогчдод мэдэгдэж, нэгтгэсэн дүнг нээлттэй мэдээлнэ.

20.3.Үнийн болон техникийн саналын оноог нэгтгэж шалгаруулахад дараах зарчмыг баримтална.

20.3.1.сонгон шалгаруулалтын комисс нь оролцогчдоос ирүүлсэн үнийн болон техникийн саналын үнэлгээний оноог нэгтгэж, хуралдааны тэмдэглэл үйлдэн, дүгнэлт гаргана.

20.3.2.сонгон шалгаруулалтад хоёр болон түүнээс дээш оролцогч нь адил үнэлгээ авсан бол үнийн саналаар илүү оноотой оролцогчид тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлтийг гаргана.

20.4.Энэ хуулийн 20.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт зарласан боловч хүсэлт ирээгүй эсхүл ирүүлсэн хүсэлт нь шаардлага хангаагүй бол сонгон шалгаруулалтыг дахин зарлаж болно.”

6/53 дугаар зүйлийн 53.6 дахь хэсэг:

“53.6.Тусгай зөвшөөрөл дуусгавар болсон талбайд үүсмэл ордыг гэрээгээр ашиглуулахыг хориглоно.”

7/64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.3 дахь хэсэг:

“64.1.Сонгон шалгаруулалтад оролцогч нь сонгон шалгаруулалтын үнэлгээтэй холбоотой гомдлоо энэ хуулийн 20.2.4-т заасан нэгтгэсэн дүнг танилцуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

64.2.Энэ хуулийн 64.1-д заасан гомдлыг хүлээн авч ажлын 5 өдрийн дотор дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

64.2.1.гомдлыг хангаж, дахин үнэлгээ хийлгэх;

64.2.2.үндэслэлгүй гэж үзвэл гомдлыг хангахаас татгалзах.

64.3.Энэ хуулийн 64.2-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж болно.”

4 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “11.1.23-т” гэснийг “11.1.26-д” гэж, 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагад” гэснийг “Засаг даргад” гэж, мөн зүйлийн “20.5” гэсэн хэсгийн дугаарыг “20.6” гэж, “20.6” гэсэн хэсгийн дугаарыг “20.7” гэж, “20.7” гэсэн хэсгийн дугаарыг “20.8” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Хайгуулын болон ашиглалтын” гэснийг “Хайгуул, ашиглалтын болон үүсмэл орд ашиглах” гэж, 64 дүгээр зүйлийн “64.1” гэсэн хэсгийн дугаарыг “64.4” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын журмаар” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “нотариатаар баталгаажуулсан” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.11 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“8.Энэ зүйлийн 6-д заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2/10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

“2.Харь ургамлыг байгальд тарималжуулах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу олгоно.

3.Судалгаа, шинжилгээний зориулалтаар олгох нэг удаагийн зөвшөөрлийн хэмжээ нойтон жингээр нэн ховор ургамал 0,2 кг, ховор ургамал 0,5 кг, элбэг ургамал 1,5 кг-аас илүүгүй байна.”

3/13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.16-д заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 2¹.8 дахь хэсэгт заасан хэмжээгээр мөн хуулийн 7¹.4-т нийцүүлэн олгоно.

4/15 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг:

“6.Ургамлыг ашиглах зөвшөөрлийг 30 хоногийн хугацаатай олгож, нэг удаа анх олгосон хугацаагаар сунгана.

7.Энэ зүйлийн 3-т заасан зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан журмын дагуу хүчингүй болгоно.”

5/20 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг:

“4.Иргэн, түүнчлэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарихыг хориглоно.

5.Энэ зүйлийн 2-т заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.

6.Энэ зүйлийн 2-т заасан мэргэжлийн байгууллага зөвшөөрөл хүсэгчийн өргөдөл, түүнд хавсргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох дүгнэлтийг гаргаж зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.”

2 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Генетик нөөцийн тухай хууль,” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хууль,” гэж, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрлийг” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.4-т заасны дагуу” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “олгох” гэсний дараа “, хүчингүй болгох” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.3-т заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр харь ургамлыг байгальд тарималжуулна.”

2/7¹ дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн хэмжээ, хугацаа, газрыг орон нутгийн санал, мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүр тогтооно.”

3/12 дугаар зүйл:

12 дугаар зүйл. Ургамлыг ахуйн зориулалтаар ашиглах

1.Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.13-т заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно.

2.Ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор ашиглах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу олгоно.

3.Ахуйн зориулалтаар олгох зүйл ургамлын нэг удаагийн зөвшөөрлийн хэмжээ нойтон жингээр ховор ургамал 2 килограммаас илүүгүй байна.”

4/13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.25-д заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 2¹.8 дахь хэсэгт заасан хэмжээгээр энэ хуулийн 7¹.4 дэх хэсэгт нийцүүлэн олгоно.”

5/15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу иргэн, аж ахуйн нэгжийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэнэ.”

6/17 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

“1.Ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.19-д заасан төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2.Энэ зүйлийн 1-д заасан зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу олгож, хүчингүй болгоно.”

7/20 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

“2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.6-д заасан мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн олгож, зөвшөөрлийг тусгай бүртгэлд бүртгэнэ.

3.Энэ зүйлийн 2-т заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.

4 дүгээр зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хийлгэж, тухайн ургамлын нөөцийн хэмжээг тогтоолгож, ашиглахыг хүсч буй ургамлын зүйлийн нэр, эрхтэн, ашиглах зориулалт, хэмжээ, хугацаа, нөхөн сэргээх арга хэмжээг тусгасан төсөл боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага буюу албан тушаалтанд өгнө.” гэснийг “хийлгэнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “иргэн,” гэснийг, 17 дугаар зүйлийн гарчгийн “гадаадын иргэн түүж бэлтгэх” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.9 дэх хэсэг нэмсүгэй:

“12.9.Энэ хуулийн 12.1-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “өргөдөлд” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгоно:”

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус” гэснийг “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ хийх эрхийг тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ” гэснийг “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.1.Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо хугацаагүйгээр олгоно:”

2 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:

“6.5.Энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагааны зөвшөөрөл олгох нөхцөл, шаардлага болон 6.3-т заасан баримт бичгийн жагсаалт, агуулга, загварыг Монголбанк батална.”

2/23 дугаар зүйлийн 23.5, 23.6, 23.7, 23.8 дахь хэсэг:

“23.5.Энэ хуулийн 6.1-д заасан зөвшөөрөл хүссэн өргөдлийг Монголбанк энэ хуулийн 23.2-т заасан журмын дагуу хянаж, 23.3-т заасан хугацаанд шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ.

23.6.Банк байгуулах, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан банкны эрхлэх үйл ажиллагааны зөвшөөрлийг хугацаагүй олгоно.

23.7.Монголбанк зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2.2.1-2.2.3-д заасан арга хэмжээг авна.

23.8.Зөвшөөрөл хүссэн өргөдлийг Монголбанк 30 хоногийн дотор магадлан шалгана.”

3/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:

“24.2.Монголбанк дараах үндэслэлээр банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзана:

24.2.1.энэ хууль, Монголбанкнаас тогтоосон шаардлагыг хангаагүй, Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн банкинд урьдчилан сэргийлэх албадлагын арга хэмжээг авч байгаа;

24.2.2.тухайн үйл ажиллагааг эрхэлснээр үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөөлөх эрсдэлтэй болохыг Монголбанк тодорхойлсон;

24.2.3.Монголбанкнаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээлэл, түүнийг нотлох баримтыг ирүүлээгүй, нотлох баримтын үндэслэл, тайлбар нь тодорхойгүй, тэдгээрийг тодорхойлох боломжгүй;

4/26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэг:

“26.5.Банкны нэр, байршлыг өөрчлөхөд тавих шаардлагыг Монголбанк тогтооно.”

5/36 дугаар зүйлийн 36.20 дахь хэсэг:

“36.20.Монголбанк нь дараах үндэслэлээр банк шинээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгохоос татгалзана:

36.20.1.энэ хуулийн 24.1-д үндэслэл бүрдсэн;

36.20.2.энэ хууль болон санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаагүй;

36.20.3.банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг энэхүү журмын шаардлагыг хангаагүй, хувьцаа эзэмшигчийн хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого болох нь нотлогдоогүй;

36.20.4.Монголбанкнаас шаардсан мэдээлэл болон тухайн мэдээллийг нотлох баримтыг ирүүлээгүй, нотлох баримтын үндэслэл, тайлбар нь тодорхойгүй, тэдгээрийг тодорхойлох боломжгүй;

36.20.5.үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөөлөх эрсдэлтэй болохыг Монголбанк тодорхойлсон;”

2 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсгийн “өөрчлөлт орох,” гэсний дараа “банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх,” гэж, 48 дугаар зүйлийн 48.1.10 дахь заалтын “түдгэлзүүлэх,” гэсний дараа “, зөвшөөрлийг хүчингүй болгох” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Банкны тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг:

“20.4.Банк үүсгэн байгуулах, банкныг өөрчлөн байгуулах, татан буулгах, банкны хувьцааг эзэмших хязгаарлалтыг тооцох, тогтоох харилцаанд баримтлах нөхцөл, шаардлагыг энэ хуульд нийцүүлэн Монголбанк тогтооно.”

2/22 дугаар зүйл:

“22 дугаар зүйл.Банкны нэгж байгуулах, үйл ажиллагаанд тавих шаардлага

22.1.Банкны нэгжийг байгуулах, бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг Монголбанк тогтооно.

22.2.Банкны салбар байгуулах зөвшөөрөл хүссэн өргөдөл нь энэ хуулийн 22.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн жагсаалтыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасантай нийцүүлэн Монголбанк батална.

22.3.Гадаадын банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах хуулийн этгээд энэ хуулийн 19 дүгээр зүйл, 22.1-д заасан шаардлагыг хангаж, 20 дугаар зүйлд заасан баримт бичгээс гадна дараах баримт бичгийг бүрдүүлж Монголбанканд хүргүүлнэ:

22.3.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай гадаадын банк, санхүүгийн байгууллагын гаргасан шийдвэр;

22.3.2.харьяалах улсын эрх бүхий төрийн байгууллагын Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн шийдвэр;

22.3.3.хууль заасан бусад.

22.4.Хуульд заасны дагуу байгуулагдсан гадаадын банк, банкны салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкны журмаар тогтооно.”

3/23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг:

“23.4.Энэ хуулийн 6.1-д заасан зөвшөөрлийг банк байгуулах тусгай зөвшөөрөлтэй хамт олгож болно.”

4 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн гарчгийн “Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох” гэснийг “Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох” гэж, 24 дүгээр зүйлийн гарчгийн “Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах” гэснийг “Банк байгуулах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзах” гэж, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийн “нөхцөлд” гэснийг “үндэслэлээр” гэж, 36 дугаар зүйлийн 36.11 дахь хэсгийн “журмыг” гэснийг “нөхцөл, шаардлагыг” гэж, 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийн “цуцлана” гэснийг “хүчингүй болгоно” гэж, 68 дугаар зүйлийн 68.1.1 дэх заалтын “цуцалсан” гэснийг “хүчингүй болгосон” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “, банкны хувьцааг эзэмших зөвшөөрөл” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 16 дугаар зүйл, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/16 дугаар зүйл:

“16 дугаар зүйл. Сургалт-дасгалжуулалтыг удирдан зохион байгуулах

16.1. Спортын дасгалжуулагчид мэргэжлийн зэрэг олгох журмыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.2. Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн сургалт-дасгалжуулалтыг удирдах дасгалжуулагч нь энэ хуулийн 16.1-д заасан журмын дагуу мэргэжлийн зэргийг авсан байна.

16.3. Биеийн тамир, спортын боловсрол олгох их, дээд сургуулийг дасгалжуулагчийн мэргэжлээр төгсөөгүй иргэн спортын сургалт-дасгалжуулалтыг энэ хуулийн 16.1-д заасан журмын дагуу мэргэжлийн зэрэг авсны үндсэн дээр эрхэлж болно.”

2/22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг:

“22.4. Тамирчин, спортын шүүгчид олгох спортын зэргийг тухайн спортын холбоо тогтоож, олгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:

“19.3.Тусгай зөвшөөрлийг барилга байгууламжийн төвөгшил болон тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны төрөл, тогтвортой байдлыг харгалзан хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу дараах зарчмаар шатлан ахиулж олгоно:

19.3.1.энэ хуулийн 33.1.15-д заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдэд бага төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламжийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг;

19.3.2.бага төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй, тухайн чиглэлээр нэгээс доошгүй жил үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэсэн ажлаа тогтоосон хугацаанд тайлагнадаг хуулийн этгээдэд дунд төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламжийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг;

19.3.3.дунд төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй, тухайн чиглэлээр гураваас доошгүй жил үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэсэн ажлаа тогтоосон хугацаанд тайлагнадаг хуулийн этгээдэд өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламжийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг;

19.3.4.өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламжийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг;

19.3.5.хуулийн этгээдийн барилгын материалын үйлдвэрийн бага, дунд, өндөр хүчин чадлыг нь харгалзан энэ хуулийн 19.3-т заасан зарчмын дагуу барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг;

19.3.6.энэ хуулийн 33.1.15-д заасан нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээдэд энэ хуулийн 19.3.1, 19.3.2, 19.3.3, 19.3.4-т зааснаас бусад ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг.”

2/20 дугаар зүйлийн 20.3.5 дахь заалт, 20.11, 20.12, 20.13 дахь хэсэг:

“20.3.5.барилгын материал үйлдвэрлэгч хуулийн этгээдийн тухайд тохирлын гэрчилгээ.

20.11.Энэ хуулийн 4.1.24-т заасан ажлыг тухайн барилгын ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд гүйцэтгэнэ.

20.12.Энэ хуулийн 10.1.5, 20.2-т заасан тусгай зөвшөөрлийн өргөдөлд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна доорх баримт бичгийг нэмэлтээр хавсаргана:

20.12.1.энэ хуулийн 10.1.5, 20.2-т заасан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг хянан баталгаажуулсан холбогдох мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт;

20.12.2.энэ хуулийн 10.1.5, 20.2-т заасан барилга байгууламжийн ажлын зураг төсөлд хийсэн магадлалын дүгнэлт;

20.12.3.өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл.

20.13.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээхтэй холбогдсон харилцааг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасан журмаар зохицуулна.”

3/28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэг:

“28.7.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 28.5-д зааснаас гадна нийтийн болон гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндсөн эсэхийг тогтоох ажиллагаа явуулж болно.”

4/30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг:

“30.5.Энэ хуулийн 27.1.2-т заасан байгууллага барилга байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэжлжүүлэх зөвшөөрөл олгох явцад мөн хуулийн 27.3-т заасан үндэслэл тогтоогдсон бол холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төслийн магадлалын дүгнэлт, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.”

2 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “шийдвэрлэж,” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаагаар” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.1, 20.6, 20.8 дахь хэсэг:

“20.1.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн өргөдлийг цахимаар хүлээн авч, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан журмаар хянан шийдвэрлэнэ.

20.6.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг сунгах харилцааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмаар зохицуулна.

20.8.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд зааснаас гадна дараах тохиолдолд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, олон нийтэд мэдээлнэ:

20.8.1.энэ хуулийн 12, 13, 14 дүгээр зүйлд заасан тавьсан шаардлагыг зөрчсөнийг барилгын улсын хяналт хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны дүгнэлтээр тогтоосон;

20.8.2.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хоёр жил дараалан эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон.”

2/27 дугаар зүйл.Барилгын ажлын зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

“27.1.Барилгын ажлын зөвшөөрлийг дараах эрх бүхий этгээд олгоно:

27.1.1.энэ хуулийн 32.1.5-д заасан зөвшөөрлийг Засгийн газар;

27.1.2.энэ хуулийн 10.1.5, 20.2-т заасан зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

27.1.3.энэ зүйлийн 27.1.1, 27.1.2-т зааснаас бусад зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга.

27.2.Барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгийг үндэслэн Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаагаар олгоно.

27.3.Дараах үндэслэлээр барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзана:

27.3.1.хот байгуулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй;

27.3.2.зураг, төсөлд магадлал хийгдээгүй;

27.3.3.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан олон нийтийн болон гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хангаагүй болохыг эрх бүхий байгууллага тогтоосон.

27.4.Энэ хуулийн хуулийн 32.1.5-д заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд магадлан шалгаж, холбогдох материалыг магадлан шалгах ажиллагаа дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

27.5.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 20¹.1-д заасан хүсэлтийг ажлын таван өдрийн дотор хянаж, холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

27.6.Засгийн газар барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн зөвшөөрөл олгох болон хүчингүй болгох саналыг ажлын 15 өдрийн дотор хэлэлцэж шийдвэрлэнэ.

27.7.Энэ хуулийн хуулийн 32.1.5-д заасан зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх эрх хэмжээг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

27.8.Энэ хуулийн 27.1.2, 27.1.3-т заасан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

4 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “олгоно.” гэснийг “олгох бөгөөд барилгын ажил гүйцэтгэж дуусах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна” гэж, мөн зүйлийн 20.9 дэх хэсгийн “байгууллагад” гэснийг “байгууллага болон чиг үүргийг нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдэд” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Энэ” гэснийг “Барилгын ажлын зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох бөгөөд энэ” гэж, мөн зүйлийн 28.6 дахь хэсгийн “35.1” гэснийг 27.1” гэж, 33.1.15 дахь заалтын “тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тоогтоох, тэдгээрт хяналт тавих журам батлах” гэснийг “тавих нөхцөл шаардлага болон үйлчилгээний хөлс тогтоох, хяналт тавих журмыг батлах” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.3, 20.4, 20.5 дахь хэсэг:

“20.3.Энэ хуулийн 20.1-д заасан эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг холбогдох хууль, нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, бусад төрийн байгууллагад шилжүүлж болно.

20.4.Энэ хуулийн 20.3-т заасан үндэслэлээр эрх хүлээн авагч нь тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

20.5.Боловсролын магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дэх хэсгийн 7.9-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.”

2/21 дүгээр зүйлийн 21.1.9, 21.1.10, 21.1.11, 21.1.12, 21.1.13, 21.1.14, 21.1.15, 21.1.16, 21.1.17, 21.1.18, 21.1.19, 21.1.20 дахь заалт:

“21.1.9.мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрт заасан дадлагын газар, сургалтын орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт;

21.1.10.хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа;

21.1.11.сургалтын хөтөлбөр;

21.1.12.нэг суралцагчид ногдох зардал, мэргэжлийн өртгийн тооцоолол;

21.1.13.сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага нь нийт багш нарын 90-ээс доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар бүрдүүлсэн байх;

21.1.14.мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол болон дээд боловсролын сургалтын байгууллага нь нийт багш нарын 80-аас доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар бүрдүүлсэн байх;

21.1.15.цэрэг цагдаа, төмөр замын чиглэлээр мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол болон дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх,

шинэ мэргэжлээр сургалт явуулах тохиолдолд холбогдох байгууллагын санал, дүгнэлт;

21.1.16.ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхийг батламжилсан баримт бичиг;

21.1.17.сургалтын байгууллагад гадаадын харьяат багш, удирдах ажилтан ажиллах тохиолдолд багшийн мэргэжлийн дипломтой байх бөгөөд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй буюу зөрчил гаргаж байгаагүй талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

21.1.18.татвар, нийгмийн даатгалын байгууллагад аливаа өр, төлбөргүй, авлагагүй, үл хөдлөх хөрөнгийн барьцаагүй байх;

21.1.19.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

21.1.20.сургалт эрхлэх зөвшөөрөлтэй тохиолдолд түүний хуулбар.”

3/21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсэг:

“21.8.Тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тохиолдолд шинэ мэргэжил нээх хүсэлтийг шийдвэрлэхдээ энэ хуулийн 21.2-т заасан хугацаа харгалзахгүй хүлээн авч шийдвэрлэж болно.”

4/22 дугаар зүйлийн 22.2.7 дахь заалт:

“22.2.7.энэ хуулийн 22.2.2-т заасан хугацаанд санал болгосон нөхцөлийг бүрэн хангасан тохиолдолд эрх бүхий этгээд ажлын 3 өдрийн дотор зөвшөөрлийг олгоно.”

5/24 дүгээр зүйлийн 24.1.6 дахь заалт:

“24.1.6.Эрх бүхий этгээдийн шалгалтаар тухайн дээд боловсролын сургалтын байгууллага хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангахгүй нь тогтоогдсон тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тухайн сургуулийн ангиллыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр зөвшөөрлийг хүчингүй болгож болно. Энэ тохиолдолд тухайн дээд боловсролын сургалтын байгууллагыг зохих ангилалд нийцүүлэн өөрчлөн байгуулж болно.”

6/28 дугаар зүйлийн 28.1.29 дэх заалт:

“28.1.29.боловсролын сургалтын байгууллагад олгох зөвшөөрлийн гэрчилгээний стандартыг боловсруулах.”

2 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2, 5.3, 5.4-т зааснаас гадна” гэж, мөн зүйлийн 22.2.2 дахь заалтын “ажлыг” гэсний дараа “30 хоногийн дотор” гэж, мөн зүйлийн 22.2.6 дахь заалтын “байгууллага” гэсний дараа “хуульд заасан хугацаанд” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“20.1.Боловсролын сургалтын үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг дараах эрх бүхий этгээд олгоно:

20.1.1.гадаадын хөрөнгө оруулалтай цэцэрлэг, сургууль байгуулах, их сургууль, дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх, олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль байгуулах, төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4-т заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

20.1.2.ерөнхий боловсролын сургууль байгуулах, цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.6, 7.7-д заасны дагуу аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга;

20.1.3.дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хамтарсан сургууль байгуулах, их, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль байгуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх энгийн зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4, 6.5-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

20.1.4.гадаадын хуулийн этгээд Монгол Улсад боловсролын байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл.”

4 дүгээр зүйл.Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “21.1.3-21.1.7-д” гэснийг “21.1.3-21.1.12, 21.1.14, 21.1.15, 21.1.20-д” гэж, 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтын “ажлын 21 өдрийн дотор боловсролын сургалтын байгууллага байгуулах” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 5-д заасан хугацаанд” гэж, мөн зүйлийн 22.2.4 дэх заалтын “15 өдрийн дотор” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2-т заасан хугацаанд” гэж, мөн зүйлийн 22.2.4 дэх хэсгийн “шинжилгээ хийлгэх” гэснийг “шалгах” гэж, мөн заалтын “шинжилгээ хийлгэхтэй гэснийг” “шалгахтай” гэж, мөн зүйлийн 22.2.5 дахь заалтын “хойш 30 хоногт багтаан” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 5-д заасан хугацаанд” гэж, мөн заалтын “шинжилгээ” гэснийг “шалгах ажиллагаа” гэж, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “14 хоногийн дотор” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацааны дотор” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/139 дүгээр зүйлийн 139.1.7, 139.1.8, 139.1.9, 139.1.10, 139.1.11, 139.1.12, 139.1.13, 139.1.14, 139.1.15, 139.1.16, 139.1.17, 139.1.18 дахь заалт:

“139.1.7.хугацаа хэтэрсэн татварын өргүй тухай татварын байгууллагын тодорхойлолт;

139.1.8.хугацаа хэтэрсэн нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай нийгмийн даатгалын байгууллын тодорхойлолт;

139.1.9.цахим төлбөрийн баримтын системд холбогдсоныг нотлох бичиг баримт;

139.1.10.хариуцлагын даатгалын гэрээ;

139.1.11.барилга байгууламж өмчлөх, газар эзэмших, өмчлөх гэрчилгээ, эсхүл газар, барилга байгууламж өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан түрээсийн гэрээ, газар өмчлөгчийн зөвшөөрөл;

139.1.12.задгай талбайд үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлт;

139.1.13.тухайн аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагч болон гүйцэтгэх удирдлага нь сүүлийн 3 жилийн хугацаанд ял шийтгүүлж байсан эсэх талаарх лавлагаа, Монгол Улсын гаалийн тухай хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжийг зөрчөөгүй болохыг нотолсон цагдаа, гаалийн байгууллагын тодорхойлолт;

139.1.14.гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд Монгол Улсын Засгийн газраас баталсан тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт;

139.1.15.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд байршуулах бараа нь шинэлэг, дэвшилтэд техник технологи болохыг тухайн салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлсон албан бичиг;

139.1.16.гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тухайн талбайд барих байгууламж нь Монгол Улсын эдийн засагт

стратегийн чухал ач холбогдол бүхий барилга байгууламж болохыг тогтоосон, барилга байгууламжийг байгуулах, газар олгох тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

139.1.17.татваргүй барааны дэлгүүрийн сонгон шалгаруулалтад оролцох тохиолдолд:

139.1.17.1.өөрийн хөрөнгийн хэмжээ нь 1 сая ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөс доошгүй болохыг аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

139.1.17.2.хилийн чанад дахь бараа нийлүүлэгчтэй бараа тогтмол нийлүүлэх талаар байгуулсан гэрээ;

139.1.17.3.татваргүй барааны дэлгүүрт нийлүүлэгдэх барааны загвар, гэрэл зургийг харуулсан католог, альбом;

139.1.17.4.татваргүй барааны дэлгүүрт орсон барааг гаалийн байгууллагын хяналтгүй худалдаалахгүй байх талаар гаргасан баталгаа;

139.1.17.5.олон улсын нисэх буудалд татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тохиолдолд татваргүй барааны дэлгүүрийн зориулалтаар үйл ажиллагаа явуулах талбай олгох талаарх нисэх буудлын захиргааны тодорхойлолт;

139.1.17.6.хилийн боомтод татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тохиолдолд татваргүй барааны дэлгүүрийн зориулалтаар үйл ажиллагаа явуулах боломжтой талаар улсын хил хамгаалах байгууллагаас тодорхойлолт авсан байх;

139.1.17.7.татваргүй барааны дэлгүүрийг гаалийн нутаг дэвсгэрийн гүнд ажиллуулах тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар.”

2/171 дүгээр зүйлийн 171.1.9, 171.1.10 дахь заалт:

“171.1.9.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 38.1-д заасан мэдээллийн цахим сан, цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байх;

171.1.10.хилийн боомт, олон улсын нисэх буудалд ажиллаж байгаа татваргүй барааны дэлгүүр согтууруулах ундаа, тамхины борлуулалт хийх тухай бүр зорчигчийн гадаадад зорчих тийз, гадаад паспорт болон худалдан авсан барааны мэдээллийг цахим төлбөрийн баримтын системд бүртгэж, цахим төлбөрийн баримт олгох;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд дараах агуулгатай 7.6, 7.7, 7.8, 7.9,7.10, 7.11, 7.12 дахь хэсэг нэмсүгэй:

“7.6.Зөвшөөрөл хүсэгч нь улсын онц чухал объектод гадаадын иргэнийг ажиллуулах зөвшөөрөл хүссэн өргөдлийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

7.7.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 7.6-д заасан өргөдлийг хүлээн авч Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу магадлан шалгах ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.8.Магадлан шалгах ажиллагаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Засгийн газарт хүргүүлнэ.

7.9.Засгийн газар зөвшөөрлийг олгох эсэхийг ажлын 15 өдрийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

7.10.Зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар Засгийн газраас шийдвэрлэх хүртэлх хугацаанд зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг гадаадын иргэний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр түдгэлзүүлж болно.

7.11.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг энэ хуулийн 7.7, 7.8, 7.9-т заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

7.12.Зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлагыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.8, 4.1.9, 4.1.10 дахь заалт:

“4.1.7. “бүх төрлийн шатахуун” гэж боловсруулах үйлдвэрт технологийн дагуу боловсруулагдсан эцсийн бүтээгдэхүүн буюу автобензин, дизель түлш, онгоцны түлш, шатдаг хий болон керосин, дайвар бүтээгдэхүүн;

4.1.8. “бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа” гэж энэ хуулийн 4.1.7-д заасан бүтээгдэхүүнийг түгээх станц, зориулалтын цэгээс борлуулахыг;

4.1.9. “газрын тосны боловсруулах үйлдвэр” гэж газрын тос, нүүрс, нүүрс-устөрөгчийн нэгдлүүдийг энгийн болон гүн боловсруулалтын аргаар энэ хуулийн 4.1.1-д заасан бүтээгдэхүүн гаргаж авах зориулалт бүхий байгууламжийн цогцолборыг;

4.1.10. “дайвар бүтээгдэхүүн” гэж газрын тосыг боловсруулах үйлдвэрлэлийн нэрлэгийн явцад гарсан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, эсхүл дараагийн шатны боловсруулалтад орох нүүрсустөрөгчийн химийн нэгдлүүдийг;

2/7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.5 дахь хэсэг:

“7.3. Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

7.3.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

7.3.2. нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, орчуулгын хамт;

7.3.3. бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, орчуулгын хамт.

7.4. Энэ хуулийн 7.3-д заасан тусгай зөвшөөрлийг бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд олгоно.

7.5. Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа энэ хуулийн 7.3-т зааснаас гадна Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг хавсаргана.”

3/8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг:

“8.5.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа энэ хуулийн 8.3-т зааснаас гадна Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг хавсаргана.”

4/9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг:

“9.4.Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа энэ хуулийн 9.2-т зааснаас гадна Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг хавсаргана.

9.5.Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

9.5.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

9.5.2.жижиглэнгийн худалдаа эрхлэх үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээ;

9.5.3.мэргэжлийн байгууллагын дүгнэлт.

9.6.Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа энэ хуулийн 9.5-д зааснаас гадна Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг хавсаргана.”

5/12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсэг:

“12.2.Бүх төрлийн шатахууныг импортлох, бүх төрлийн шатахууны бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь доорх нийтлэг үүргийг хүлээнэ:

12.2.1.энэ хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.10-т заасан байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн цогцолбор нь холбогдох норм, дүрэм, стандартын шаардлага хангасан эсэх талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас техник, технологийн дүгнэлт гаргуулах;

12.2.2.бүх төрлийн шатахууны импорт, үлдэгдэл, нөөц, борлуулалтын тайлан, мэдээг төрийн байгууллагын тогтоосон хугацаанд болон шаардлагатай тохиолдолд гаргаж өгөх;

12.3.Энэ хуулийн 12.2.1-д заасан дүгнэлтийг гаргуулахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

12.3.1.улсын бүртгэлийн гэрчилгээ;

12.3.2.үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ;

12.3.3.газар эзэмших эрхийн гэрчилгээ;

12.3.4.улсын комиссын акт;

12.3.5.эрх бүхий байгууллагаар боловсруулж, баталгаажуулсан зураг төсөл;

12.3.6.үйлдвэрлэх бүтээгдэхүүн дэх түүхий эдийн орц, найрлага, хувь хэмжээ, боловсруулалтын аргыг тусгасан үйлдвэрлэгчийн сертификат, эрх бүхий байгууллагаар батлуулсан технологийн стандарт.”

2 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт:

“4.1.6.”бүх төрлийн шатахууны бөөний худалдаа” гэж энэ хуулийн 4.1.7-д заасан бүтээгдэхүүнийг 4.1.3-т заасан агуулахаас борлуулахыг;”

2/5 дугаар зүйлийн 5.2.2, 5.2.5 дахь заалт:

“5.2.2.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох.

5.2.5.бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэх зөвшөөрөл олгох эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу төрийн холбогдох байгууллагад шилжүүлж болно.”

3/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:

“8.3.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

8.3.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

8.3.2.үйлдвэрлэлийн төсөл буюу техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байх;

8.3.3.мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

8.3.4.түүхий эд нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, орчуулгын хамт;

8.3.5.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.”

4/9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг:

“9.2.Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

9.2.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

9.2.2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

9.2.3.агуулахын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл эдгээрийн түрээсийн гэрээ;

9.2.4.мэргэжлийн байгууллагын дүгнэлт.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/24¹ дүгээр зүйл:

“24¹ дүгээр зүйл. Газар зохион байгуулалтын болон газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх

24¹.1. Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.6, 3.7-д заасан эрхийг хуулийн этгээдэд таван жилийн хугацаатай олгоно.

24¹.2. Энэ хуулийн 24¹.1-д заасан эрх эзэмшигч Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан нийтлэг нөхцөл, шаардлагаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

24¹.2.1. газар зохион байгуулагч инженер, газрын кадастрын инженер, газар зүйн мэдээллийн систем эсхүл зайнаас тандан судлалын мэргэжилтэн, архитектор, хот төлөвлөгч, хөрс судлаач, ургамал судлаач, геодезийн инженер зэрэг инженер техникийн ажилтнаас бүрдсэн туршлагатай мэргэжлийн багтай байх;

24¹.2.2. энэ хуулийн 24¹.2.1-д заасан мэргэжлийн багийн инженер, техникийн ажилтнууд хуулийн этгээдийн үндсэн ажилтан байх;

24¹.2.3. хиймэл дагуулын зураг боловсруулах програм, электрон тахеометр эсвэл GNSS-ийн 2 долгионы багаж, газар зүйн мэдээллийн системийн програм, ургамлын бичиглэлийн тор, хөрсний дээж авах хэрэгсэл зэрэг мэргэжлийн багаж, тоног төхөөрөмжтэй байх;

24¹.2.4. энэ хуулийн 24¹.2.1-д заасан мэргэжлийн баг мэргэжлийн байгууллагын эрхээс хамааран 1-2 мэргэшсэн инженертэй байх;

24¹.2.5. хэмжилтийн болон боловсруулалтын багажийг итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулсан байх.

24¹.3. Хуулийн этгээд энэ хуулийн 24¹.1-д заасан эрх авах, эрхийн хугацааг сунгах тухай хүсэлтээ Зөвшөөрлийн тухай хуулийн тавдугаар бүлэгт заасан журмын дагуу газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цахимаар гаргана.

24¹.4.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2, 5.5 дугаар зүйлд заасан журмын дагуу газар зохион байгуулалтын болон газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх авах, сунгах тухай хуулийн этгээдийн хүсэлтийг хянаж, энэ хуулийн 24¹.2-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг нягтлан шалгаж, дүгнэлт гаргана.

24¹.5.Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 24¹.4, 24¹.6-д заасан дүгнэлтийг үндэслэн мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай шийдвэр гаргана.

24¹.6.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 24¹.1-д заасан эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд түдгэлзүүлэх, 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд хүчингүй болгох дүгнэлт гаргана.

24¹.7.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 24¹.1-д заасан эрх эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дараах байдлаар хяналт тавина:

24¹.7.1.хяналтыг хяналт-шинжилгээ үнэлгээний хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус байдлаар хийх;

24¹.7.2.үнэлгээ, тайланг ажлын хэсгийн хуралд танилцуулж, газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны төв байгууллагад мэдээлэх;

24¹.7.3.мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигч хуулийн этгээд нь суурь нөхцөл, шаардлагыг хангаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь эрхийн хугацааг сунгах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх тухай асуудлыг шийдвэрлүүлэх.

24¹.8.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн долдугаар бүлэгт заасны дагуу мэдээллийн санг эрхэлж, мэдээллийн сангийн програм хангамж, сервер, сүлжээний аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хариуцна.”

2/33¹ дүгээр зүйл:

“33¹ дүгээр зүйл.Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам

“33¹.1.Энэ хуулийн 33.1.2, 44.4-т заасны дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газар ашиглуулах болон Чөлөөт бүсийн тухай хуулийн 22.4-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чөлөөт бүсэд газар эзэмших, ашиглах эрх олгоходоо аймаг, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын болон чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн тухайн шатны Засаг дарга, газрын бирж, чөлөөт бүсийн захирагч (цаашид “дуудлага худалдааг зохион байгуулагч” гэх) газрын биржийн цахим системээр зохион байгуулна.”

33¹.2.Эрх бүхий байгууллага болон газар өмчлөх, эзэмших эрхтэй этгээдийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар худалдах, шилжүүлэх хүсэлтийн дагуу дараах тохиолдолд дуудлага худалдааг зохион байгуулж болно:

33¹.2.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гаргасан албадан дуудлага худалдаа явуулах хүсэлт;

33¹.2.2.төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

33¹.2.3.банк, банк бус санхүүгийн байгууллагаас гаргасан дуудлага худалдаа явуулах хүсэлт;

33¹.2.4.газар өмчлөх, эзэмших эрхтэй этгээд.

33¹.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Иргэний хуулийн 84.3-т заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар хувьчилж байгаа тохиолдолд түүний дуудлага худалдааны анхны үнэд газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг оролцуулан тооцож, дуудлага худалдааг зохион байгуулна.

33¹.4.Дуудлага худалдаа явуулахад дараах зарчмыг баримтална:

33¹.4.1.дуудлага худалдаанд оруулах газрыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн болон чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахаар заасан байх;

33¹.4.2.ил тод байх;

33¹.4.3.тэгш, шударга оролцоог хангасан байх.

33¹.5.Дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулах бөгөөд дараах дарааллын дагуу явуулна:

33¹.5.1.дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах;

33¹.5.2.дуудлага худалдааг зарлан мэдээлэх болон дуудлага худалдааны эхлэх, дуусах цагийг товлох;

33¹.5.3.дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх;

33¹.5.4.дуудлага худалдааг явуулах;

33¹.5.5.дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах.

33¹.6.Дуудлага худалдааг нээлттэй эсхүл, хаалттай хэлбэрээр газрын биржийн цахим системээр дамжуулан цахимаар зохион байгуулна.

33¹.7.Дуудлага худалдааны нээлттэй хэлбэрт ямарч этгээд оролцож болно.

33¹.8.Дуудлага худалдааны хаалттай хэлбэрт тухайн газар ашиглалтын зориулалтыг хэрэгжүүлэхэд тавигдсан шаардлагыг хангасан зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд урилгаар оролцоно.

33¹.9.Дуудлага худалдааг аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал болон чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, газрын бирж дуудлага худалдаа зохион байгуулах бөгөөд доор дурдсан бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэнэ:

33¹.9.1.дуудлага худалдаагаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах тухайн нэгж талбарын эргэлтийн цэгүүдийг тодорхойлон газар дээр нь тэмдэгжүүлэх;

33¹.9.2.дуудлага худалдааны тов, тухайн нэгж талбарын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дуудлага худалдааны хэлбэр, хугацаа, дэнчингийн хэмжээг тогтоосон шийдвэрийн төслийг бэлтгэж, тухайн шатны Засаг дарга, чөлөөт бүсийн захирагчаар гаргуулах;

33¹.9.3.шаардлагатай тохиолдолд тухайн нэгж талбар дээр барих барилга байгууламжийн техникийн нөхцөл, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах;

33¹.9.4.Энэ хуулийн 33¹.2.1-33¹.2.4-т заасан этгээдтэй гэрээ байгуулах.

33¹.10.Дуудлага худалдааны бэлтгэл ажлын зардлыг дуудлага худалдааны орлогоос, энэ хуулийн 33¹.2.1-33¹.2.4-т заасан дуудлага худалдаа явуулах зардлыг хүсэлт гаргасан этгээд хариуцна.

33¹.11.Дуудлага худалдааг зохион байгуулагч дуудлага худалдааны зар (цаашид “зар” гэх)-ыг уг дуудлага худалдаа явуулахаар товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө газрын биржийн цахим хуудас болон аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, чөлөөт бүсийн захирагчийн албаны болон сумын нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

33¹.12.Энэ хуулийн 33¹.11-д заасан зард дараах мэдээллийг тусгана:

33¹.12.1.дуудлага худалдаагаар газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

33¹.12.2.дуудлага худалдааны хэлбэр;

33¹.12.3.газрын байршил, хил заагийг харуулсан зураг;

33¹.12.4.газрын талбайн хэмжээ;

33¹.12.5.дуудлага худалдааны анхны үнэ;

33¹.12.6.дэнчингийн хэмжээ, дэнчин тушаах дансны дугаар;

33¹.12.7.гэрээний зүйл;

33¹.12.8.дуудлага худалдаа явуулах газрын хаяг, харилцах утасны дугаар;

33¹.12.9.дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа;

33¹.12.10.дуудлага худалдаа эхлэх, дуусах он, сар, өдөр, цаг;

33¹.12.11.газар эзэмших, ашиглах зориулалт, хугацаа;

33¹.12.12.энэ хуулийн 33¹.9.3.-т заасан тохиолдолд тухайн нэгж талбар дээр барих барилга байгууламжийн техникийн нөхцөлүүд болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийн талаарх ерөнхий мэдээлэл.

33¹.13.Дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд газрын биржийн цахим системээр дамжуулан хүсэлтээ гаргах бөгөөд дараах материалыг хавсаргана:

33¹.13.1.дэнчин төлсөн баримт;

33¹.13.2.дуудлага худалдаанд иргэнийг төлөөлж оролцох тохиолдолд тухайн иргэний олгосон нотариатчаар гэрчлүүлсэн итгэмжлэл;

33¹.13.3.дуудлага худалдаанд аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж оролцох тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын олгосон итгэмжлэл.

33¹.14.Дуудлага худалдааг зохион байгуулагч дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээдийн цахимаар илгээсэн материалыг шалгана.

33¹.15.Дуудлага худалдаанд оролцогчдын бүртгэл, мэдээллийг дуудлага худалдааг нээх хүртэлх хугацаанд нууцалж, бусдад энэ талаар мэдээлэл өгөхийг хориглоно.

33¹.16.Дуудлага худалдаанд оролцогч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хураамжийг төлсөн байна.

33¹.17.Дуудлага худалдааг дуудлага худалдаа эхлэх өдөр, цаг, минутад дараах дарааллаар явуулна:

33¹.17.1.цахим дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд дуудлага худалдааны зарлан мэдээлэлд товлосон хугацаанд энэ хуулийн 33¹.13-т заасан материалыг шалгаж, хүсэлтийг хүлээн авч, дуудлага худалдааны оролцогч болсныг цахим дуудлага худалдаа явуулах газрын биржийн цахим системд нэвтрэх нэр, нууц үгээр баталгаажуулж оролцогчид мэдэгдэнэ;

33¹.17.2.дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг цахим дуудлага худалдаа явагдаж эхлэхээс өмнөх ажлын таван өдрийн өмнөөс хүлээн авч, дуудлага худалдаа явагдах өдрийн өмнөх өдрийн тогтоосон цагт зогсоож, бүртгэлийг хаана;

33¹.17.3.дуудлага худалдааг товлосон өдрийн тогтоосон цагт эхлүүлж, мөн өдрийн тогтоосон цаг хүртэл явуулна;

33¹.17.4.дуудлага худалдааны эхлэх, дуусах цагийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын цагаар тооцож эхлүүлэх бөгөөд дуудлага худалдааны үнийн хэмжээг доор дурдсанаар өсгөнө:

Өсгөн хэлэх үнийн хэмжээ

№	Дуудлага худалдааны анхны үнэ (төгрөг)	Өсгөн хэлэх үнэ (төгрөг)
1.	1 000 000 хүртэл	50 мянга-100 мянга
2.	1 000 001-5 000 000	100 мянга-500 мянга
3.	5 000 001-10 000 000	500 мянга-1 сая
4.	10 000 001-50 000 000	1 сая-5 сая
5.	50 000 001-100 000 000	5 сая- 10 сая
6.	100 000 001-500 000 000	10 сая-50 сая
7.	500 000 001-1 000 000 000	50 сая-100 сая
8.	1 000 000 001-түүнээс дээш	100 сая-500 сая

33¹.17.5.дуудлага худалдаанд оролцогч бусад оролцогчдоос ирүүлсэн үнийн саналтай танилцах эрхтэй;

33¹.17.6.дуудлага худалдаа нь энэ хуулийн 33¹.5.2-т заасан хугацаанд үнийн саналыг хүлээн авч, үнэ хаялцуулах өрсөлдөөнийг эхлүүлж, дуусгана. Үнэ хаялцуулах өрсөлдөөнийг 60 секундээр тооцож явуулах бөгөөд уг хугацаанд оролцогчид үнийн саналаа өсгөх байдлаар өрсөлдөнө;

33¹.17.7.үнэ хаялцуулах өрсөлдөөний 60 секундийн хүлээлтийн горимд шилжих бөгөөд хүлээлтийн хугацаанд үнийн санал ирүүлээгүй бол хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчийг ялагчаар тодруулан цахим дуудлага худалдаа дууссан болохыг бүх оролцогчдод мэдэгдэнэ.

33¹.18.Энэ хуулийн 33¹.17.7-д заасан хугацаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчийг дуудлага худалдаа явуулах газрын биржийн цахим систем ашиглан ялагчаар тодруулж, энэ тухай оролцогч тус бүрт мэдэгдэнэ.

33¹.19.Дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш долоо хоногийн дотор Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд хэрэв гэрээнд заасан хугацаанд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний үнийг бүрэн төлөөгүй, татгалзсан бол хамгийн өндөр үнэ хаясан ялагчийн хоёрдахь оролцогчид түүнийг хэлсэн үнээр санал болгоно. Хоёрдахь оролцогч санал болгосон өдрөөс долоо хоногийн дотор гэрээ байгуулсан бол дуудлага худалдааны ялагчаар тооцоно. Заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл татгалзсан бол дуудлага худалдааг хүчингүйд тооцоно.

33¹.20.Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг энэ хуульд заасан хугацаанд буцаан шилжүүлэх бөгөөд шилжүүлэх данс тодорхойгүй тохиолдолд цахим бүртгэл дэх утас, хаягаар оролцогчтой холбогдож шилжүүлнэ.

33¹.21.Дуудлага худалдааны үр дүнгийн талаарх мэдээллийг уг дуудлага худалдааг зохион байгуулснаас хойш хуанлийн гурван хоногийн дотор интернэтээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

33¹.22.Байгалийн давагдашгүй хүчин зүйл гарсан, эсхүл програм хангамж, техникийн саатал, цахилгаан эрчим хүч, сүлжээ тасарч доголдсоноос цахим дуудлага худалдаа хэвийн явагдах боломжгүй болсон тохиолдолд тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцож, ажлын таван өдрийн дотор давтан зохион байгуулна.

33¹.23.Дуудлага худалдаа явуулахтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Иргэний хуулийн 197 дугаар зүйл болон Газрын тухай хуулийн 18.1.4-т заасан газрын биржийн журамд заасны дагуу зохицуулна.

33¹.24.Дуудлага худалдааны анхны үнээс дээш үнийн санал гаргаагүй бол дуудлага худалдаа явагдаагүй гэж үзэх бөгөөд дуудлага худалдаанд нэг оролцогч оролцох хүсэлт гаргасан тохиолдолд дуудлага худалдааны анхны үнэ дээр өсгөн хэлэх үнийн доод хэмжээг нэмж, дуудлага худалдаагаар худалдан авах үнийг тогтоох бөгөөд тухайн оролцогч зөвшөөрвөл түүнийг дуудлага худалдааны ялагч гэж үзнэ.

33¹.25.Дараах тохиолдолд дуудлага худалдааг дахин явуулна:

33¹.25.1.дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан газрын болон газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний үнийг гэрээ байгуулсанаас хойш 14 хоногийн дотор бүрэн төлөөгүй, эсхүл төлөхийг зөвшөөрөөгүй тохиолдолд;

33¹.25.2.дуудлага худалдаа явагдаагүй болон явуулах нөхцөл бүрдээгүй;

33¹.25.3.хууль зөрчин явуулсныг шүүхийн шийдвэрээр тогтоосон;

33¹.25.4.дуудлага худалдааны ялагч энэ хуулийн 33¹.26.2-т заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд;

33¹.25.5.хуульд заасан бусад тохиолдолд.

33¹.26.Дуудлага худалдааг дахин явуулах шийдвэрийг тухайн шатны Засаг дарга буюу чөлөөт бүсийн захирагч гаргах бөгөөд дуудлага худалдааны зарыг дахин дуудлага худалдаа явуулах өдрөөс хуанлийн 14-өөс доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлж, дуудлага худалдааг дахин явуулна.

33¹.27.Дуудлага худалдаанд оролцогчдоос хамгийн өндөр үнийн санал хэлсэн оролцогч тухайн дуудлага худалдааны ялагч болох бөгөөд дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор дуудлага худалдааны тэмдэглэлийг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал болон чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба дуудлага худалдааны ялагчтай Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулна. Гэрээнд доор дурдсан зүйлийг тусгана:

33¹.27.1.дуудлага худалдаагаар худалдан авсан газрын байршил, зориулалт;

33¹.27.2.талбайн хэмжээ;

33¹.27.3.дуудлага худалдаанд оролцоход тавьсан дэнчингийн хэмжээ;

33¹.27.4.дуудлага худалдаагаар худалдан авсан үнэ болон газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний үнэ, түүнийг төлөх хэлбэр, хугацаа.

33¹.28.Дуудлага худалдааны ялагч гэрээ байгуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор дуудлага худалдааны үнийг бүрэн төлөх бөгөөд заасан хугацаанд дуудлага худалдааны үнийг бүрэн төлснөөр тухайн шатны Засаг дарга газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, Чөлөөт бүсийн захирагч газар ашиглуулах тухай шийдвэрийг ажлын 15 өдрийн дотор гаргана.

33¹.29.Дуудлага худалдааны ялагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл дуудлага худалдааны үнийг бүрэн төлөөгүй тохиолдолд тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцно.

33¹.30.Дуудлага худалдааны ялагчид хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд энэ хуулийн 33¹.19, 33¹.28-т тус тус заасан хугацааг ажлын таван өдрөөр тус бүр сунгаж болно. Энэ тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгааныг Татварын ерөнхий хуулийн 6.1.41-д зааснаар ойлгоно.

33¹.31.Дуудлага худалдааны ялагч хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал болон чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, газрын биржид мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүй тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаан үүссэнд тооцохгүй.

33¹.32. Дуудлага худалдааны анхны үнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн шатны Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч тогтоох бөгөөд дэнчингийн хэмжээ нь дуудлага худалдааны анхны үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү байна.

33¹.33. Газрын биржийн цахим системд тусгай данстай байх бөгөөд уг дансанд дуудлага худалдааны орлого, дэнчинг төвлөрүүлж дуудлага худалдааны орлогыг доор дурдсанаар хуваарилна:

33¹.33.1. газрын дуудлага худалдаа зохион байгуулсан сум, дүүргийн төсөвт 50 хувь;

33¹.33.2. аймаг, нийслэлийн төсөвт 30 хувь;

33¹.33.3. аймаг, нийслэлийн газрын албанд 20 хувь.

33¹.34. Дуудлага худалдааны орлогын энэ хуулийн “33¹.33-т заасан хувийн дагуу сар бүрийн 25-ны өдрийн дотор шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

33¹.35. Дуудлага худалдаанаас орсон орлогыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж доор дурдсан үйл ажиллагаанд зарцуулна.

33¹.35.1. дуудлага худалдааны бэлтгэл ажил хангах, зохион байгуулах, сурталчлах;

33¹.35.2. нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах;

33¹.35.3. тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах;

33¹.35.4. бэлчээр менежментийн төлөвлөгөө боловсруулах, бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх;

33¹.35.5. геодезийн цэг тэмдэгтийн тооллого хийх, хамгаалах, нөхөн сэргээх;

33¹.35.6. хаягжуулалтын ажлыг зохион байгуулах;

33¹.35.7. хилийн цэсийн тодруулалтын ажил хийх;

33¹.35.8. газрыг хамгаалах, нөхөн сэргээх болон бусад газар зохион байгуулалтын арга хэмжээнд;

33¹.35.9. дуудлага худалдаа явуулах, програм хангамжийг хөгжүүлэх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сүлжээний тоног төхөөрөмж, сүлжээний урсгал, интернет, албан хаагчдыг чадавхжуулах.

33¹.36. Дуудлага худалдаанаас орсон орлогыг аймаг, нийслэлийн газрын алба доор дурдсан үйл ажиллагаанд зарцуулна:

33¹.36.1. дуудлага худалдааны бэлтгэл ажил хангах, зохион байгуулах, сурталчлах;

33¹.36.2.дуудлага худалдаа явуулах, програм хангамжийг хөгжүүлэх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх;

33¹.36.3.албан хаагчдийг чадавхжуулах сургалтад хамруулах;

33¹.36.4.албан хаагчдийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд;

33¹.36.5.бүсийн сургалт зохион байгуулах, аймгуудтай туршлага солилцох;

33¹.36.6.бичиг хэргийн зардал, принтерийн хор, тоног төхөөрөмжийн засвар;

33¹.36.7.томилолтын зардал, шатахууны зардал;

33¹.36.8.дуудлага худалдаа явуулах, програм хангамжийг хөгжүүлэх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сүлжээний тоног төхөөрөмж, сүлжээний урсгал, интернет.

33¹.37.Дуудлага худалдааны орлогоос газар зохион байгуулалтын болон бэлчээрийн менежмент хийх, газрыг хамгаалах, нөхөн сэргээх, дуудлага худалдаа явуулах, програм хангамжийг хөгжүүлэх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, албан хаагчдыг чадавхжуулах арга хэмжээнд зарцуулна.

33¹.38.Аймаг, нийслэлийн Газрын алба болон чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь тухайн жилд явуулсан дуудлага худалдааны тайланг сум, дүүрэг тус бүрээр нэгтгэн хагас жилийн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны эхний сарын 15-ны өдрийн дотор тус тус газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

33¹.39.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дуудлага худалдаатай холбогдсон гомдлоо тухайн шатны Засаг дарга болон чөлөөт бүсийн захирагч, шүүхэд тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

3/33² дугаар зүйл:

“33² дугаар зүйл.Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам

33².1.Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон холбогдох төлөвлөгөөг үндэслэн тухайн шатны Засаг дарга, газрын бирж, чөлөөт бүсийн захирагч, тусгай хамгаалалттай газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулагч” гэх) газрын биржийн цахим системээр зохион байгуулна.

33².2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж газрыг төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлж, ашиглуулна.

33².3.Гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр нь Олон улсын гэрээний тухай хуульд заасны

дагуу Улсын Их Хурлаас соёрхон баталсан, эсхүл Засгийн газрын байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажсан байна.

33².4.Төсөл сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлсэн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

33².4.1.хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай байх;

33².4.2.мэргэжлийн ажиллах хүчний болон техник технологи, тоног төхөөрөмжийн чадавх, нөөцтэй байх;

33².4.3.төсөл нь зарласан нөхцөл шаардлага, стандартыг хангасан байх;

33².4.4.төслийг зарласан хугацаанд ирүүлсэн байх;

33².4.5.шаардлагатай тохиолдолд холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байх.

33².5.Төсөл сонгон шалгаруулалтыг дараах дарааллын дагуу явуулна:

33².5.1.төсөл сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах;

33².5.2.төсөл сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлэх;

33².5.3.төслийг хүлээн авах;

33².5.4.төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

33².5.5.шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах.

33².6.Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал, чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, тусгай хамгаалалттай газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдуулан дараах бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэнэ.

33².6.1.төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын эргэлтийн цэгүүдийн солбицлыг газар дээр нь тодорхойлж тэмдэгжүүлэх;

33².6.2.тухайн газар дээр барилга байгууламж барих болон үйл ажиллагаа явуулахад шаардагдах мэргэжлийн байгууллагын дүгнэлт, техникийн нөхцөлүүдийг гаргуулах;

33².6.3.газрыг төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах тухай Засаг даргын болон чөлөөт бүсийн захирагчийн шийдвэр гарсан байх.

33².7.Төсөл сонгон шалгаруулалтын зар (цаашид “зар” гэх)-ыг уг ажиллагааг явуулахаар товлосон өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дараах байдлаар нийтэд мэдээлнэ:

33².7.1.аймаг, нийслэл, дүүргийн газрын алба болон чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, тусгай хамгаалалттай газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон сумын нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар;

33².7.2.газрын биржийн цахим системээр.

33².8.Энэ хуулийн 33².7-д заасан зард дараах мэдээллийг тусгана:

33².8.1.төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

33².8.2.төслийг ирүүлэх болон нээх хугацаа;

33².8.3.газар ашиглалтын зориулалт;

33².8.4.газрын талбайн хэмжээ;

33².8.5.газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа;

33².8.6.газрын байршил, хилийн заагийг харуулсан зураг;

33².8.7.хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ажлын эхлэх, дуусах хугацаа;

33².8.8.хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө.

33².9.Тухайн газрын онцлог, шинж чанараас шалтгаалан нэмэлт шаардлага тавьж болох бөгөөд түүнийг төсөл сонгон шалгаруулалтын зард тусгана.

33².10.Тухайн газар дээр Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу энгийн болон тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа эрхлэх бол энэ тухай зар мэдээнд тусгайлан заасан байна.

33².11.Оролцогч нь төслөө зард заасан хугацаанд газрын биржийн цахим системээр илгээнэ.

33².12.Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал, чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба болон тусгай хамгаалалттай газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийг зард заасан хугацаанд нээж ирүүлсэн төслийн жагсаалтыг гаргаж, тусгай тэмдэглэл үйлдэн архивын нэгж үүсгэн хадгална.

33².13.Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хураамжийг төлнө.

33².14.Төсөл сонгон шалгаруулалтын зохион байгуулагч нь сонгон шалгаруулалттай холбогдсон нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

33².15.Төсөл сонгон шалгаруулах өдрөөс ажлын таван өдрийн өмнөх өдрийн 09 цаг 00 минутаас бүртгэж эхлэх бөгөөд төсөл сонгон шалгаруулах өдрийн өмнөх ажлын өдрийн 15 цаг 00 минут хүртэл бүртгэнэ.

33².16.Төсөл сонгон шалгаруулалтын зохион байгуулагч нь төсөл хүлээн авах сүүлийн өдөр төслийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг томилж, төсөл шалгаруулах үйл ажиллагааг эхлүүлнэ.

33².17.Ажлын хэсгийн гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

33².17.1.газар зохион байгуулалт, газрын кадастр, архитектор, эдийн засаг, хөдөө аж ахуй, эрх зүйн болон дэд бүтцийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэжлээрээ хоёроос доошгүй жил ажилласан;

33².17.2.төсөл сонгон шалгаруулалтад оролцогчтой хувийн ашиг сонирхолгүй байх;

33².17.3.төсөл сонгон шалгаруулалтад оролцогчтой сүүлийн нэг жилийн хугацаанд аливаа хэлбэрээр хамтран ажиллаагүй байх.

33².18.Энэ хуулийн 33².17-т заасан шаардлагыг хангаагүй этгээд ажлын хэсгийн гишүүнээр томилогдсон тохиолдолд төсөл сонгон шалгаруулалтад оролцогч түүнээс татгалзаж, өөрчлүүлэх эрхтэй.

33².19.Ажлын хэсэг нь төсөл сонгон шалгаруулалтад ирүүлсэн төслийг төсөл нээх хугацаанд газрын бирж цахим системээс татан авч, тэмдэглэл үйлдэж, гишүүд гарын үсэг зурна.

33².20.Ажлын хэсэг төсөл тус бүр холбогдох зард заасан бүрдлийг хангасан эсэхийг шалгана. Зард заасан баримт бичиг бүрдэл дутуу тохиолдолд ажлын хэсэг энэ тухай оролцогчид мэдээлж, тухайн үзүүлэлтээр үнэлгээ өгөхгүй байх, эсхүл төслийг сонгон шалгаруулалтаас хасах шийдвэр гаргана.

33².21.Ажлын хэсэг төсөл сонгон шалгаруулалтын зохион байгуулагчаас урьдчилан тогтоосон доор дурдсан үндсэн шалгуур үзүүлэлтээр төслийг сонгон шалгаруулж харгалзах оноог тавина.

33².21.1.төсөл нь зард тусгасан шаардлага болон бүрдлийг хангасан эсэх;
33².21.2.барилга, хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагад нийцсэн эсэх;

33².21.3.төслийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500 стандартын дагуу боловсруулсан эсэх;

33².21.4.төсөл нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулагдсан бизнес төлөвлөгөөтэй эсэх;

33².21.5.төсөл нь холбогдох төлөвлөгөөнд тусгагдаж түүнд нийцсэн эсэх;
33².21.6.төсөл хэрэгжсэнээр шинээр бий болох ажлын байрны тоо, хэмжээ;

33².21.7.тухайн хот, тосгон, суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжилд ач холбогдолтой эсэх;

33².21.8.улс, орон нутгийн төсөвт оруулах орлогын хэмжээ;
33².21.9.тухайн газарт явуулах үйл ажиллагаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх.

33².22.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад ирүүлсэн төслийн талаар нэмэлт мэдээлэл шаардан авах эрхтэй бөгөөд эдгээр мэдээлэлтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нууцыг нийтэд задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

33².23.Оролцогчдоос ирүүлсэн төсөл энэ хуулийн 33².21-д заасан шалгуур үзүүлэлтийг ойролцоо буюу адил хангасан нөхцөлд тухайн газарт явуулах үйл ажиллагаа, орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлэх ач холбогдол, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэргийг харьцуулан үзэж шалгаруулна.

33².24.Ажлын хэсэг төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдөрт багтаан төсөл тус бүрээр дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтэд дараах зүйлийг тусгана:

33².24.1.төслийн шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлсэн үнэлгээний оноо;
33².24.2.төсөл тус бүрийг бүхэлд нь үнэлсэн товч тодорхойлолт;

33².24.3.ажлын хэсгийн гишүүдийн тусгай санал;
33².24.4.нийлбэр оноо.

33².25.Ажлын хэсэг хуралдаж, төсөл сонгон шалгаруулалтын дүгнэлтийг гаргана. ажлын хэсгийн дүгнэлтийг бичгээр үйлдэж, он, сар, өдрийг тодорхой тэмдэглэж, гишүүн тус бүр гарын үсэг зурсан байна.

33².26.Эсрэг саналтай ажлын хэсгийн гишүүн дүгнэлтэд өөрийн саналыг тайлбар хэлбэрээр тусгуулж, гарын үсэг зурсан байна.

33².27.Төсөл сонгон шалгаруулалтад нэг төсөл (санал) ирсэн тохиолдолд ажлын хэсэг энэ хуульд заасны дагуу төслийг шалгаруулж, дүгнэлт гаргана.

33².28.Хэрэв төсөл сонгон шалгаруулалтаар энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй, зарласан хугацаанд нэг ч төсөл ирээгүй тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон чөлөөт бүсийн захирагч төсөл сонгон шалгаруулалтыг дахин явуулах шийдвэр гаргах бөгөөд төсөл сонгон шалгаруулалт явуулахаас 30 хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

33².29.Ажлын хэсэг төсөл сонгон шалгаруулалтын дүгнэлтийг ажлын гурван өдөрт багтаан төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулагчид танилцуулан дүнг нийтэд зарлана.

33².30.Байгалийн давагдашгүй хүчин зүйл гарсан, эсхүл програм хангамж, техникийн саатал, цахилгаан эрчим хүч, сүлжээ тасарч доголдсоноос газрын биржийн системээр зохион байгуулж байгаа төсөл сонгон шалгаруулалт хэвийн явагдах боломжгүй болсон тохиолдолд тухайн төсөл сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцож, ажлын таван өдрийн дотор давтан зохион байгуулна.

33².31.Төсөл сонгон шалгаруулалтын дүнг нийтэд зарласан өдрөөс хойш ажлын гурван өдөрт багтаан ялагчтай гэрээ байгуулна. Гэрээнд доор дурдсан зүйлийг тусгана:

33².34.1.газрын байршил, эзэмших зориулалт;
33².34.2.газрын хэмжээ.

33².32.Тухайн шатны Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч энэ хуулийн 33².31-д заасан гэрээ байгуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай захирамж гаргана.

33².33.Энэ журмын 33².32-т заасан захирамжийг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал, чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ байгуулж, гэрчилгээ олгох бөгөөд ажлын 15 өдөрт багтаан тухайн газрын эзэмшигч, ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгнө.

33².34.Төсөл сонгон шалгаруулалтаар чөлөөт бүсэд газар эзэмших, ашиглах хуулийн этгээд Чөлөөт бүсийн тухай хууль болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан төлбөрийг төлөх үүрэгтэй.

33².35.Төсөл сонгон шалгаруулалтын ялагч энэ хуулийн 33².33-д заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд тухайн төсөл сонгон шалгаруулалтыг хүчингүй болсонд тооцно.

33².36.Энэ хуулийн 33².33-д заасан гэрээний загварыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

33².37.Төсөл сонгон шалгаруулалтын ялагчид хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд энэ хуулийн 33².33-д заасан хугацааг ажлын таван өдрөөр сунгаж болно. Энэ тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгааныг Татварын ерөнхий хуулийн 6.1.41-д зааснаар ойлгоно.

33².38.Төсөл сонгон шалгаруулалтын ялагч хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэгт мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүй тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаан үүссэнд тооцохгүй.

33².39.Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь ажлын хэсгийн дүгнэлт болон тухайн шатны Засаг дарга, чөлөөт бүсийн захирагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргаж болно.

4/2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг:

“2.3.“Зөвшөөрлийн тухай хуульд газар эзэмшүүлэх, ашиглуулах харилцааг энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол Газрын тухай хуулийг баримтална.”

5/23 дугаар зүйлийн 23.2.24, 23.2.25 дахь заалт:

“23.2.24.Газрын тухай хууль тогтоомж, газар зохион байгуулалт, газрын кадастр, төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаанд газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, улсын байцаагч хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

23.2.25.“Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг эрхлэх бөгөөд цахим систем нь төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай дундын мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.”

6/24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг:

“24.6.Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын нөхөн сэргээлтийг газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.”

7/28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг:

“28.2.Энэ хуулийн 28.1.1-д заасан газар эзэмших эрх нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.9-д заасан энгийн зөвшөөрөлд, мөн хуулийн 28.1.3-т заасан газар эзэмших, 44.4, 44.5 дахь хэсэгт заасан газар ашиглах эрх нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.21-д заасан тусгай зөвшөөрөлд хамаарна.”

8/33 дугаар зүйлийн 33.1.3 дахь заалт, 33.8 дахь хэсэг:

“33.1.3.Энэ хуулийн 33.1.1-д заасан шийдвэрийг хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор тухайн шатны Засаг дарга гаргана.

33.8.Эрх бүхий этгээд газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай шийдвэр гарч эд хөрөнгийн эрхийн бүртгэлд бүртгүүлсэн бол шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээс бусад хэлбэрээр түдгэлзүүлж, сэргээхгүй.”

9/44 дүгээр зүйлийн 44.11 дэх хэсэг:

“44.11.Газар ашиглах эрхийг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжид олгож болно.”

2 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дэх хэсгийн “аж ахуйн нэгж” гэсний дараа “Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Газрын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/23 дугаар зүйлийн 23.2.9, 23.2.17, 23.4.6 дахь заалт:

“23.3.9.газар эзэмших, ашиглах эрхийг энэ хуулийн 23.2.25-д заасан газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд оруулж, дундын мэдээлийн сангаар дамжуулан улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан болон зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх.

23.2.17.газрын кадастр эрхлэх мэргэжлийн байгууллагын болон энэ хуулийн 24.6-д заасан газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт өгөх;

23.4.6.газар эзэмших, ашиглах эрхийг энэ хуулийн 23.2.25-д заасан газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд оруулж, дундын мэдээлийн сангаар дамжуулан улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан болон зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх.

2/31 дүгээр зүйл:

“31 дүгээр зүйл.Газар эзэмшүүлэх, ашиглуулахад тавигдах нөхцөл, шаардлага

31.1.Газрыг дараах нөхцөл, шаардлагыг хангасан бол газар эзэмших, ашиглах эрхийн үндсэн дээр газрыг эзэмшүүлж, ашиглуулна:

31.1.1.энэ хуульд заасан тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан байх;

31.1.2.энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 29.3-т зааснаас бусад тохиолдолд газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулагчийн ялагч болсон байх;

31.1.3.нийтийн эдэлбэрийн газар болон бусдын эзэмшил, ашиглалтын газартай давхцалгүй байх;

31.1.4.энх хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.6-д заасныг зөрчөөгүй байх.

31.2.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.”

3/33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, 33.7 дахь хэсэг:

“33.1.1.энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу ажлын 15 өдрийн дотор тухайн шатны Засаг дарга гаргана;

33.7.Эрх бүхий этгээд газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 23.2.25-д заасан газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд оруулж, дундын мэдээлийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан болон зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.”

4/34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг:

“34.1.Энэ хуулийн 33.1-д заасан газар эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай ажлын таван өдрийн дотор газар эзэмших гэрээ, эрхийн гэрчилгээг цахим системээр баталгаажуулан, улсын бүртгэлд бүртгэнэ.”

4 дүгээр зүйл.Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтыг хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгаль орчны Төсөл хяналтын газар” гэснийг “хяналтыг хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон газар, байгаль орчны” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 8, 9, 10, 11, 12, 13 дахь хэсэг:

“8.Энэ зүйлийн 1, 4 дэх хэсэгт заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

9.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөвшөөрөл зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.5-д заасан тусгай зөвшөөрөлтэй этгээдэд олгоно.

10.Энэ зүйлийн 6-д заасан зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг Засгийн газар, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

11.Энэ зүйлийн 6-д заасан зөвшөөрөл авах, хугацаа сунгуулах өргөдлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч, магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлж, шийдвэр гаргуулахаар магадлан шалгах ажиллагаа дууссанаас хойш ажлын хоёр өдөрт Засгийн газарт хүргүүлнэ.

12.Засгийн газар зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгох асуудлаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэр гаргана.

13.Шаардлагатай бол Засгийн газрын шийдвэр гарах хүртэлх хугацаанд зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр зогсоож болно.

14.Энэ зүйлийн 6-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах тусгай болзол, шалгуурыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

2/42 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Энэ зүйлийн 13 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Газрын хэвлийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлий ашиглах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.28-д заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.”

3 дугаар зүйл.Газрын хэвлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “тухай асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ” гэснийг “зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.3-т заасны дагуу Засгийн газар олгоно” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хууль,” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19.3.Энэ хуулийн 19.2-т заасан болон галт зэвсэг ашиглах спортын тэмцээн, сургалтад оролцох зорилгоор галт зэвсгийг улсын хилээр нэвтрүүлэх шийдвэрийг цагдаагийн байгууллага ажлын таван өдрийн дотор гаргана.”

3 дугаар зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 8 дугаар зүйлийн 8.2, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “зөвшөөрөл олгоно.” гэснийг “шийдвэр гаргана.” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Галт зэвсэг ашиглах спортын тэмцээн, сургалтад оролцох, ан агнах зорилгоор” гэснийг “Ан агнах зорилгоор” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.8. Гал түймрийн аюулын үнэлгээг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.3-т заасан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд гүйцэтгэнэ.”

2 дугаар зүйл. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг, 18.8.1, 18.8.2, 18.8.3, 18.8.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.7, 7.8, 7.9 дэх хэсэг нэмсүгэй:

“7.7. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.8-д заасан гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаатай олгох бөгөөд тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмаар зохицуулна.

7.8. Энэ хуулийн 7.3.1-д заасан үнэлгээ хийх бүрэлдэхүүнд тавигдах мэргэшлийн шаардлагыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

7.9. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх зөвшөөрлийг сунгахад Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 15 дахь хэсэг үйлчлэхгүй”

2 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:

“7.3. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.8-д заасны дагуу онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах шаардлагыг хангасан хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоно:”.

2/7 дугаар зүйлийн 7.3.2 дахь заалт:

“7.3.2. гамшгийн эрсдэлийн судалгаа, шинжилгээний зориулалт бүхий стандартын шаардлага хангасан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;”

3 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн 7.3.1 дэх заалтын “шинжээчийн” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Генетик нөөцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль” гэсний өмнө “Зөвшөөрлийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Генетик нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

15.1. Энэ хуулийн 13.1-д заасан этгээд генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны болон ашиг олох зорилгоор ашиглах өргөдлийг төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд түүнд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

15.1.1. энэ хуулийн 16.1.2-т заасан мэдээлэл болон генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн танилцуулга;

15.1.2. хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар;

15.1.3. хуулийн этгээдийн танилцуулга;

15.1.4. гадаадын хуулийн этгээд бол дотоодын хуулийн этгээдтэй хийсэн хамтран ажиллах гэрээ;

15.1.5. энэ хуулийн 10.3.2-т заасан ашиглалтын цахим бүртгэлд бүртгүүлсэн баримт;

15.1.6. энэ хуулийн 14.1-д заасан урьдчилсан зөвшөөрөл;

15.1.7. энэ хуулийн 8.1.2-т заасан газарзүйн гарал үүслийн тодорхойлолт;

15.1.8. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хадгалах, хамгаалах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх арга хэмжээний танилцуулга.

15.2. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсргасан баримт бичгийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

15.3. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлд заасан журмын дагуу зохицуулах бөгөөд мөн хуулийн 2.2 дугаар зүйлийн 1-д заасан хугацаагаар олгоно.

15.4.Тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмаар зохицуулна.

15.5.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасан журмаар зохицуулна.

15.6.Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн тухай Монгол Улсын олон улсын гэрээнд заасан ургамлыг хүнс, тэжээлийн зорилгоор ашиглах тохиолдолд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй.

15.7.Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.3-т заасан суурь судалгааг Монгол Улсын нутаг дэвсгэрт хийхэд энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл шаардахгүй.

15.8.Энэ хуулийн 15.7-д заасан судалгааны ажил эхлэхээс өмнө холбогдох мэдээллийг энэ хуулийн 10.3.2-т заасан ашиглалтын цахим бүртгэлд бүртгүүлэх бөгөөд судалгааны ажлын үр дүнг хагас жил тутамд шинэчлэн энэ хуулийн 10.1-д заасан мэдээллийн санд тайлагнах үүрэгтэй.

15.9.Мэргэжлийн зөвлөл тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт багтаан дүгнэлтээ гаргаж, тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад танилцуулна.

15.10.Ургамал, амьтны биологийн нөөц бэлтгэх зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Байгалийн ургамлын тухай, Ойн тухай, Амьтны тухай хуулиар тус тус зохицуулна.

15.11.Төрийн захиргааны төв байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан журмаас гадна дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

15.11.1.Мэргэжлийн зөвлөл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үр шимийн гэрээний хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэлт гаргасан;

15.11.2.энэ хуулийн 15.1.4-т заасан хамтран ажиллах гэрээг цуцалсан, эсхүл дуусгавар болгосон;

15.11.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

15.11.4.хуулийн этгээд татан буугдсан;

15.11.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч генетик нөөцийг ашиглахаар заасан хувь, хэмжээг хэтрүүлсэн, эсхүл хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй.

15.12.Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг ашиг олох зорилгоор ашиглах тохиолдолд дахин өргөдөл гаргаж тусгай зөвшөөрөл авна.

15.13.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны болон ашиг олох зорилгоор ашиглаж байгаа хуулийн этгээд энэ хуулийн 13.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ 180 хоногийн дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

15.14.Энэ хуулийн 15.13-т заасан хугацаанд төрийн захиргааны төв байгууллагад өргөдлөө гаргаагүй бол тусгай зөвшөөрөлгүйгээр генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласан гэж үзнэ.

15.15.Тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

15.16.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийцлийн гэрчилгээний үндэслэл болох бөгөөд тухайн генетик нөөцийн ашиглалт хуулийн дагуу хэрэгжиж байгааг хянах хэрэгсэл болно.”

3 дугаар зүйл.Генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.8-д заасан” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4 дэх хэсгийн “хүсэлт” гэснийг “өргөдөл” гэж, 14.6 дэх хэсгийн “Хүсэлт” гэснийг “Өргөдөл” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.2, 4.3, 4.4, 4.5, 4.6, 4.7, 4.8, 4.9, 4.10, 4.11, 4.12 дахь хэсэг:

“4.2.Энэ зүйлийн 4.1-д заасан геодези, зураг зүйн үйл ажиллагааг геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд эрхлэнэ.

4.3.Барилга байгууламжийн угсралт, уул уурхайн ашиглалтын өдөр тутмын үйл ажиллагаанд хийх геодезийн хэмжилтийг геодезийн инженер тусгай зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэж болно.

4.4.Гадаадын хуулийн этгээд, иргэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

4.5.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага геодезийн, зураг зүйн гэсэн хоёр төрлөөр таван жилийн хугацаатай олгох бөгөөд энэ зүйлийн 4.9-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд анх олгосон хугацаагаар сунгана.

4.6.Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд дараах суурь нөхцөл, шаардлага хангасан байна:

4.6.1.геодезийн бакалавр зэрэгтэй хоёроос доошгүй инженертэй, нэг нь зөвлөх эсхүл мэргэшсэн зэрэгтэй байх;

4.6.2.таван сантиметрээс ихгүй дундаж квадрат алдаа бүхий геодезийн хэмжилтийн электрон тахеометр, хиймэл дагуулаас байрлал тодорхойлох хоёроос доошгүй давтамжтай долгионы багаж, таван миллиметрээс ихгүй хэмжилтийн нарийвчлалтай нивелиртэй байх;

4.6.3.татварын өргүй байх.

4.7.Зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд нь энэ зүйлийн 4.6.3-т заасан шаардлагыг хангахын зэрэгцээ, зураг зүйн зөвлөх эсхүл мэргэшсэн зэрэгтэй инженертэй, боловсруулалтын техник, програм хангамжтай байна.

4.8.Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлага болон энэ хуулийн 4.6, 4.7 дахь хэсэгт заасан суурь нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээд Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлтээ дараах бичиг баримтыг бүрдүүлэн тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн цахим системээр дамжуулан гаргана:

4.8.1.удирдах болон инженер, техникийн ажилтан тус бүрийн диплом;

4.8.2.зөвлөх инженер, мэргэшсэн инженерийн мэргэшлийн зэргийн гэрчилгээ;

4.8.3.хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулгын гэрчилгээ.

4.9.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанаас өмнө дараах баримт бичгийг бүрдүүлэн, тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтийн хамт тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн цахим системээр дамжуулан гаргана:

4.9.1.зөвлөх болон мэргэшсэн, туслах инженерийн сүүлийн 3 жилийн Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа;

4.9.2.зөвлөх болон мэргэшсэн, туслах инженер нь шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд эрх бүхий этгээдийн тушаал, шийдвэр;

4.9.3.гүйцэтгэх удирдлага, зөвлөх болон мэргэшсэн, туслах инженер нь шинээр томилогдсон тохиолдолд тэдгээрийг томилсон эрх бүхий этгээдийн тушаал, шийдвэр, дипломын болон мэргэшсэн инженерийн гэрчилгээний хуулбар;

4.9.4.энэ зүйлийн 4.8.3-т заасан хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийн баталгаажуултын гэрчилгээний хуулбар.

4.10.Энэ хуулийн 24.2.1, 24.3 дахь хэсэгт заасан инженерүүд нь тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн үндсэн ажилтан байх ба багаж тоног төхөөрөмж болон инженер нь энэ хуулийн 5.5.11-д заасан цахим мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд давхцалгүй байна.

4.11.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түтгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн Тавдугаар бүлэг, Зургаадугаар бүлэгт заасанд нийцүүлэн зохион байгуулна.

4.12.Дараах тохиолдолд хуулийн этгээдэд олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

4.12.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дахь зүйлд заасан нөхцөл байдал үүссэн;

4.12.2.тусгай зөвшөөрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хоёр ба түүнээс дээш удаа биелүүлээгүй;

4.12.3.Захиалагчтай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын үр дүн нь холбогдох норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангаагүйгээс захиалагчид хохирол учирсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;

4.12.4.геодези, зураг зүйн ажил нь алдаатай болохыг тогтоосон эрх бүхий байгууллага дүгнэлт гарсан;

4.12.5.гүйцэтгэсэн ажлын мэдээ, тайланг хоёр жилээс дээш хугацаанд цахим системээр дамжуулан ирүүлээгүй.”

2/5 дугаар зүйлийн 5.4.7, 5.5.10, 5.5.11, 5.5.12, 5.5.13, 5.5.14 дэх дахь заалт:

“5.4.7.энэ зүйлий 5.4.6-д заасан шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан хугацаанд бүртгүүлэх;

5.5.10.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон, сунгагдсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан хугацааны дотор гэрчилгээг олгоно;

5.5.11.геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн, инженер техникийн ажилтны, хэмжилтийн багажны мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлийг хөтөлнө;

5.5.12.тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг хянаж, дараа оны нэгдүгээр улиралд багтаан гэрээ дүгнэсэн актыг цахим системд байршуулна;

5.5.13.тусгай зөвшөөрлийг хугацаа дуусахаас өмнө Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэж, бүртгэлд тэмдэглэх;

5.5.14.энэ зүйлийн 4.11-д заасан геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргээ мэрэгжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.”

2 дугаар зүйл.Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6 дахь заалт, 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.4.6 дахь заалт:

“5.4.6.хуулийн этгээдэд геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, гэрээ байгуулах эрх олгох.”

2/6 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эрх, үүрэг

6.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлд зааснаас гадна, дараах үүрэгтэй:

6.1.1.геодезийн хэмжилтийн багажинд жил тутамд, эвдрэл гэмтэл гарсан тохиодолд засварлаж, тухай бүр баталгаажуулалт хийлгэх;

6.1.2.геодезийн хэмжилт, зураглалыг батлагдсан солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо, эрин, тусгагд хийх;

6.1.3.шинээр солбицлын бие даасан тогтолцоо үүсгэж геодезийн хэмжилт, зураглалыг гүйцэтгэсэн бол улсын солбицлын тогтолцоонд холбох хөрвүүлэлтийн утгыг тодорхойлон батлуулах;

6.1.4.төрөл бүрийн сэдэвчилсэн, лавлагааны, сургалтын газрын зураг, атлас зохиохдоо нэг маягийн суурь зураг ашигласан байх;

6.1.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жил гүйцэтгэсэн ажлын тайланг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдөрт багтаан ирүүлэх;

6.1.6.Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу үйл ажиллагааны баримтын архив үүсгэж, хадгах бөгөөд татан буугдах тохиолдолд архивын баримтыг архивын байгууллагад шилжүүлэн өгөх.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хууль,” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “байгууллага гэж” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хууль болон” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

“5.1.Харуул хамгаалалтын үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “эрх бүхий байгууллага” гэх/-аас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.”

2/7 дугаар зүйл:

“7 дугаар зүйл.Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

7.1.Тусгай зөвшөөрөл хүсэгч харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдлийг эрх бүхий байгууллагад гаргах бөгөөд өргөдөлд Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна энэ хуулийн 6.1-д заасныг нотлох баримт, харуул хамгаалалтад ажиллах албан хаагч тус бүрийн тодорхойлолт, тэдгээрийн эрүүл мэндийн магадлагааг хавсаргана.

7.2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бичиг баримт нь эрх бүхий байгууллагад байгаа, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системээс татан авах боломжтой бол иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.

7.3.Эрх бүхий байгууллага зөвшөөрөл хүссэн өргөдлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.”

3/21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг:

“21.3.Эрх бүхий байгууллага харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.”

3 дугаар зүйл.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “эрх бүхий байгууллагад бүртгүүлж,” гэснийг “тусгай зөвшөөрөл авч,” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн “14 хоногийн” гэснийг “10 өдрийн ” гэж, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “ажлын 14” гэснийг “30” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.6 дахь хэсгийн “14 хоногийн” гэснийг “10 өдрийн” гэж, 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсгийн “ажлын 14” гэснийг “30” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.6, 9.7 дахь хэсэг нэмсүгэй:

“9.6.Энэ зүйлийн 9.3.2-т заасан зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

9.7.Энэ зүйлийн 9.3.2-т заасан зөвшөөрлийг олгоход нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас санал авсан байна.”

2 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.3.2.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.11-д заасны дагуу хот, суурин газрын авто замын зурвас газарт худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9 дүгээр зүйл.Гадна зар сурталчилгаа

9.1.Гадна зар сурталчилгаанд нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар байрлуулах зар сурталчилгаа хамаарна.

9.2.Гадна зар сурталчилгаа нь дараах шаардлагыг хангасан байна:

9.2.1.гэрэлтүүлэгтэй байх;

9.2.2.“Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”, “Цахилгаан техникийн угсралтын дүрэм”, Барилгын норм, нормативын дагуу байрлуулах;

9.2.3.нэг орон зайд нэгэн жигд загвар, хэмжээтэй байх;

9.2.4.авто зам болон явган замын зорчих хөдөлгөөнд саад учруулахгүй байх бөгөөд замын байгууламжаас хэвтээ проекцоор 1 м зайтай байх;

9.2.5.барилгабайгууламжийн хана, дээвэрт байрлуулсан сурталчилгааны байгууламж нь тухайн барилгын аюулгүй байдал, өнгө үзэмжийг алдагдуулаагүй байх;

9.2.6.нийтийн тээврийн зогсоол дахь сурталчилгааны байгууламж дээр нийтийн тээврийн хэрэгслийн маршрут, мэдээллийг байрлуулсан байх;

9.2.7.бусдын эзэмшил газар, барилга байгууламж, объектыг ашиглан нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд гадна сурталчилгаа түгээх бол түүний өмчлөгч, эзэмшигчээс зөвшөөрөл авсан байх.

9.3.Гадна зар сурталчилгааны байршил, хугацаа нь аймаг, нийслэл, сум, дүүргийн хот байгуулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлтөд нийцсэн байна.

9.4.Энэ зүйлийн 9.1-д заасан зар сурталчилгааг дэд бүтцийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст байрлуулахыг хориглоно.

9.5.Энэ зүйлийн 9.1-д заасан зар сурталчилгаа нь замын тэмдэг, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгсэлтэй андуурагдах, тэдгээрийн үзэгдэлт ба үр дүнг бууруулах, замын хөдөлгөөнд оролцогчийг гялбуулах, эсхүл анхаарлыг сарниулах,

эсхүл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бусад хэлбэрээр алдагдуулах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.

9.6.Гадна зар сурталчилгааг байрлуулсан этгээд хог хаягдал үүсгэхгүйгээр хураах ажлыг зохион байгуулна.

9.7.Энэ хуулийн 9.1-д заасан зар сурталчилгааг байрлуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгохтой холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.9 дэх заалт:

“4.9.цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох.”

2/5.7 дугаар зүйл:

“5.7 дугаар зүйл.Зарим төрлийн зөвшөөрөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг

1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 6.3-т заасан үнэт цаас үйлдвэрлэх, 6.5-д заасан эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрх хэмжээг энэ хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

2.Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар, эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар Монгол Улсын хуулийн этгээдэд олгоно.

3.Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 4.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

3.1.холбогдох мэргэжлийн байгууллагаас ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн дүгнэлт гарсан байх;

3.2.үнэт цаас үйлдвэрлэхэд ашиглагддаг шаардлага хангасан тоног төхөөрөмжтэй байх;

3.3.үнэт цаас үйлдвэрлэхтэй холбоотой аюулгүй ажиллагаа, нууцлалыг хангасан байх.

4.Эд мөнгөний хонжворт сугалгаа гаргах тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 4.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

4.1.эд мөнгөний хонжворт сугалаа гаргах үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийг нотлох;

4.2.цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байх;

4.3.үйлдвэрийн баталгаа бүхий сугалааны азтан тодруулах зориулалтын тоног төхөөрөмж, программ хангамжаар хангагдсан байх;

4.4.эд мөнгөний хонжворт сугалаа зохион байгуулах үйл ажиллагаа эрхлэх өөрийн өмчийн ажлын байрыг зориулалтын дагуу тохижуулсан байх;

4.5.таван зуун сая төгрөгөөс доошгүй хэмжээний өөрийн хөрөнгөтэй байх;
4.6.татварын өргүй байх.

5.Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

5.1.байгууллагын ерөнхий танилцуулга, үүсгэн байгуулах баримт бичиг;

5.2.үнэт цаасны үйлдвэрлэхтэй холбоотой тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааг ханган ажиллах хүний нөөцийн мэдээлэл;

5.3.үнэт цаасны үйлдвэрлэх горимыг байгууллагаас батлан гаргасан журам, илүүдэл болон алдаатай үнэт цаасны устгал, түүний бүртгэлд тавих хяналт, байгууллагын дотоод хяналтад мөрдөгддөг дүрэм, журмын хуулбар.

6.Эд мөнгөний хонжворт сугалгаа гаргах зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

6.1.аж ахуйн нэгжийн танилцуулга болон тусгай зөвшөөрлийн хугацаанд хамаарах үйл ажиллагааны төлөвлөгөө;

6.2.хуульд заасан тохиолдолд хүсэлт гаргагчийн аудитаар баталгаажуулсан сүүлийн улирлын тайлан;

6.3.эд мөнгөний хонжворт сугалаанаас олсон орлогыг хуваарилах норматив;

6.4.эд мөнгөний хонжворт сугалааг олгох, төлөх үед сугалааны тасалбарыг шалгах магадлах дүрэм;

6.5.эд мөнгөний хонжворт сугалааны тасалбар, эсхүл сугалааны нөхцөлөөр тохирсон бусад баримт бичгийн загвар, түүнд тавигдах шаардлага, түүн дээр буулгасан баримт бичиг, тэмдгийн нууцлал, хонжворт сугалааны тасалбарыг дуурайлган хуулбарлахаас сэргийлэх арга;

6.6.эд мөнгөний хонжворт сугалааны тасалбар борлуулах зах зээлийн судалгаа, сугалааны орлогын урьдчилсан тооцоо, сугалаа зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн талаарх мэдээлэл;

6.7.тараагдсан болон тараагдаагүй сугалааны тасалбар бүртгэх, тодорсон ялагч нь шаардаж аваагүй хонжворыг хадгалах, хонжвор олгох хугацаа дууссаны дараа тэдгээрийг хүлээлгэн өгөх журам;

6.8.татварын өргүй тухай татварын байгууллагын тодорхойлолт;
6.9.энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан нөхцөл, шаардлагыг хангасан талаарх холбогдох баримт бичиг.”

7.Үнэт цаас үйлдвэрлэх болон эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад энэ хуулийн 5.5 дугаар зүйлийн 15 дахь хэсэг хамаарахгүй.

3/6.2 дугаар зүйлийн 1.8 дахь заалт:

“1.8. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6-д заасан хугацаанд улсын тэмдэгтийн хураамжийг төлөөгүй.

4/7.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 3.2 дугаар зүйлийн 2.3-т заасан асуудлыг мэдээлэл технологийн дэвшилтэд аргыг ашиглан хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлнэ.”

5/8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 30, 31 дэх заалт:

1.30.ойгоос мод бэлтгэх эрх	Ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/
1.31.газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

6/8.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 31 дэх заалт:

8.31.үүсмэл орд ашиглах	Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
-------------------------	---

7/8.1 дүгээр зүйлийн 13 дэх хэсгийн 13.21 дэх заалт:

13.21.өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, импортлох, экспортлох, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
--	--

8/8.2 дугаар зүйлийн 1 дэх 1.16 дахь заалт:

1.16.генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
---	--

9/8.2 дугаар зүйлийн 10.12, 10.13, 10.14 дэх заалт:

10.12.нийтийн эзэмшил гудамж, талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэх зорилгоор талбай ашиглах	Тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга
10.13.тогтоосон агаарын хаалганаас гадуур нэвтрэх агаарын хөлөгт зөвшөөрөл олгох	Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага

10.14.хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх	Зэвсэгт хүчний Агаарын цэргийн Командлалын зөвшөөрлийг үндэслэн Хил хамгаалах ерөнхий газар
--	---

2 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эрхээ” гэсний дараа ”бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн” гэж, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хуульд заасан” гэсний дараа “зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон” гэж, мөн зүйлийн 3, 6 дахь хэсгийн “1-д заасан” гэсний дараа “явцын мэдээлэл,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.8, 1.15, 1.21, 1.23, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 6 дахь хэсгийн 6.12, 8 дахь хэсгийн 8.14, 8.28, 8.29 дэх заалтад заасан зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.18, 5 дахь хэсгийн 5.1, 9 дэх хэсгийн 9.2, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.11, 11 дэх хэсгийн 11.1, 11.9, 11.12, 12 дахь хэсгийн 12.1, 12.2, 12.14 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно.”

2/8.2 дугаар зүйлийн 5.1 дэх заалт:

5.1.гадаадын төрийн өмчит хуулийн этгээд этгээд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших	Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
---	--

3/8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“8.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
8.1.мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8.2.кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8.3.радио давтамжийг нийтийн үйлчилгээний бус зориулалтаар ашиглах	Харилцаа холбооны зохицуулах хороо

4/8.2 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.11 дэх заалт:

10.11.хот, суурин газрын авто замын зурвас газарт худалдаа, үйлчилгээ эрхлэх	Тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга
--	---

4 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.7 дахь заалтын “стандартыг” гэснийг “стандарт, техникийн зохицуулалтыг” гэж, 5.3 дугаар зүйлийн 2, 7 дахь хэсгийн “шийдвэрийг” гэснийг “шийдвэр болон улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ, төлөх хугацааны талаар” гэж, 6.2 дугаар зүйлийн 1.8 дахь заалтын дугаарыг “1.9” гэж, 7.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Эрх бүхий этгээдээс ирүүлсэн энэ зүйлийн 3-т заасан шийдвэрийг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын гурван өдрийн дотор бүртгэж,” гэснийг “Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 3-т заасан явцын мэдээлэл, шийдвэрийг” гэж, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.11 дэх заалтын “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, мөн зүйлийн 8 дахь хэсгийн 8.20, 8.21, 8.22, 8.23 дахь заалтын “Мэргэжлийн хяналтын ерөнхий газар” гэснийг “Цөмийн болон цацрагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн зүйлийн 12 дахь хэсгийн 12.1 дэх заалтын “сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архианаас” гэснийг “уламжлалт технологиор үйлдвэрлэсэнээс” гэж, мөн заалтын “Засгийн газар” гэснийг “Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 12.13 дахь заалтын “сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх” гэснийг “уламжлалт технологиор согтууруулах ундаа үйлдвэрлэх” гэж, 8.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.1 дэх заалтын “зүйл, эх олдворын” гэснийг “зүйлийг” гэж, 12 дахь хэсгийн 12.1 дэх заалтын “эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний” гэснийг “эмийн” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.14 дэх заалтын “, устгах” гэснийг, 8.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.12 дахь заалтын “, өмчлөгч өөрөө язгуур зориулалтаар ашиглах” гэснийг, 7 дахь хэсгийн 7.3 дахь заалтын “, ерөнхий боловсролын лаборатори сургууль” гэснийг, 10 дахь хэсгийн 10.11 дэх хэсгийн “болон нийтийн эзэмшлийн гудамж, талбайд” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.2 дахь заалт, 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 13 дахь хэсгийн 13.16 дахь заалт, 8.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.2 дахь заалт, 7 дахь хэсгийн 7.2 дахь заалт, 10 дахь хэсгийн 10.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “5.19 дүгээр зүйл,” гэсний дараа “5.20 дугаар зүйл,” гэж, мөн зүйлийн 6.10 дахь заалтын “14.13” гэсний дараа “14.15” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 14.15 дугаар зүйл нэмсүгэй:

“14.15 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчих

1.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь нэвтрүүлгийг бэлтгэх, нэвтрүүлэх, дамжуулах техник, тоног төхөөрөмж нь сүлжээний найдвартай ажиллагаа, стандартын шаардлагыг хангаагүй бол нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлд зааснаас бусад төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ, байршилд эрхэлсэн бол хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхийг хориглосон этгээд эрхэлсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурсанаар өөрчлөн найруулсугай:

1/6.1 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг:

“11.Нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар зар сурталчилгаа байрлуулсны улмаас хог хаягдал үүсгэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2/14.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Илгээмжийг хүлээн авах, цуглуулах, тээвэрлэх, хаягт эзэнд хүргэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүй эрхэлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 3.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөлтэйгөөр” гэснийг “зөвшөөрөлтэйгээр” гэж, 3.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 18, 21, 22 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөлгүйгээр” гэснийг “зөвшөөрөлгүйгээр” гэж, 6.1 дүгээр зүйлийн 18, 21, 23 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.6 дугаар зүйлийн 6,7 дахь хэсэг, 7.15 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 10.23 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “зөвшөөрөлгүйгээр” гэснийг “тусгай зөвшөөрөлгүйгээр” гэж, 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бохирдуулах” гэснийг “Бохирдуулах” гэж, 7.15 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “, зөвшөөрөл” гэснийг “тусгай зөвшөөрөл” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “тусгай зөвшөөрлийг” гэж, 8.1 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт, 12.1 дүгээр зүйлийн 1.9 дэх заалтын “зөвшөөрөлгүйгээр” гэснийг “дүгнэлтгүйгээр” гэж, 12.3 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “холбогдох гэснийг “тусгай” гэж, 12.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Эрчим хүчний тухай хуульд” гэснийг “Хуульд” гэж, 14.4 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтын “эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр авто замын” гэснийг “Авто замын” гэж, 14.4 дүгээр зүйлийн 2.4 дэх заалтын “, эсхүл зөвшөөрөлгүйгээр”,14.5 дугаар зүйлийн 2,3 дахь хэсгийн “зөвшөөрөлгүйгээр” гэснийг “дур мэдэн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.14 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтын “, эсхүл зөвшөөрөл авах журам зөрчсөн” гэснийг, 6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.15 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр дахин боловсруулсан” гэснийг, 7.13 дугаар зүйлийн 9.5 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 7.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.18 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 10.18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 12.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 13.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 13.4 дүгээр зүйлийн 3, 5 дахь хэсэг, 14.5 дугаар зүйлийн 15 дахь хэсэг, 16.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зэвсэгт хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.2.23 дахь заалт нэмсүгэй:

“14.2.23.Улсын нисэхийн тухай хуулийн 6.2.3-т заасан зөвшөөрөл олгох;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/23 дугаар зүйлийн 23.6, 23.7 дахь хэсэг:

“23.6.Энэ хуулийн 23.2-т заасан баримт бичгийн жагсаалт, загвар, агуулга, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай болон энгийн зөвшөөрөл хүсэгч, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд тавих шаардлага, мөрдөх стандартын жагсаалтыг Монголбанк батална.”

“23.7.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.8-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуулийн 23.6-д заасан нотлох баримтыг бүрдүүлэн Монголбанканд ирүүлнэ.”

2/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:

“24.2.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл хүссэн өргөдөл, баримт бичиг энэ хуулийн 23.7, 27.2-т заасан шаардлагыг хангаагүй бол Монголбанк зөвшөөрөл олгохоос татгалзана.”

3/23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн 23.2.9 дэх заалт:

“23.2.9.энэ хуульд заасан эрхлэх үйл ажиллагааны төрөл, нөхцөл, шаардлагыг тусгасан удирдлага, зохион байгуулалтын бодлого, журам, шийдвэр.”

4/24 зүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн 24.1.4 дэх заалт:

“24.1.4.бизнес төлөвлөгөө, үйл ажиллагаа нь банк, санхүүгийн тогтвортой байдал, зээлийн мэдээллийн үйлчилгээ эрхлэгчийн санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлөх нь магадлан шалгах ажиллагаагаар тогтоогдсон.”

5/26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн 26.1.6 дахь заалт:

“26.1.6.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд тухайн үйл ажиллагааг эрхэлсэн”

2 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“23.4.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, зээлийн мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, үйлчилгээний хөлс тогтоох журмыг Монголбанк тогтооно.”

3 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5 дахь заалтын “ашгийн төлөө хуулийн этгээдийг” гэснийг “компанийг” гэж, 23.2.8 дахь дахь заалтын “өөрийн хөрөнгийн” гэснийг “хувь нийлүүлсэн хөрөнгийн” гэж, 23.3 дахь хэсгийн “хүлээн авч” гэснийг “бүрэн хүлээн авснаас хойш” гэж, 25.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2-т” гэж, 26.1.5 дахь заалтын “хууль тогтоомжийг” гэснийг “хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“13.1.Иргэн, аж ахуйн нэгж иргэний нисэхийн дараах үйл ажиллагааг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлнэ.”

“13.2.Иргэний нисэхийн олон улсын гэрээг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 13.1-д заасан тусгай зөвшөөрөл болон олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн олгох бусад зөвшөөрлийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Иргэний нисэхийн дүрмийн дагуу олгоно”

2 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “ашиглахыг зөвшөөрнө” гэснийг “ашиглана” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “ журмыг” гэснийг “ үйл ажиллагааг” гэж, 19.2 дахь хэсгийн “Улсын бүртгэлд бүртгүүлэхгүйгээр” гэснийг “Энэ хуулийн 13.1.2-т заасан зөвшөөрөлгүйгээр” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.4 хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:

“7.6.Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг Газрын тухай хуулийн 24¹ дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсгийн “иргэн” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Кино урлагийг дэмжих тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн тайлбар:

“Тайлбар: Кино зураг авалт хийх гэдэгт бүрэн хэмжээний болон богино хэмжээний кино, бүх төрлийн кино бүтээх болон дүрс бичлэг хийх зорилгоор дуу авиа дагалдсан эсэхээс үл хамааран дүрсийг хөдөлгөөнт хэлбэрт нэгтгэн хураан авч тоног төхөөрөмжид хадгалах үйл явц буюу зураг авалт хийх ажиллагааг хамааруулна.”

2/20 дугаар зүйлийн 20.9, 20.10, 20.11, 20.12 дахь хэсэг:

“20.9.Зөвлөл кино зураг авалт хийх зөвшөөрөл, зураг авалтын багт ажиллах гадаадын иргэдийн мэдээллийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

20.10.Зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлтийг гэрчилгээнд заасан хугацаа дуусахаас өмнө дараах хугацаанд багтан Зөвлөлд хүргүүлнэ:

20.10.1.зөвшөөрлийг таваас дээш хоногоор авсан бол гурваас доошгүй хоногийн өмнө;

20.10.2.зөвшөөрлийг таваас доош хоногийн хугацаатай бол нэгээс доошгүй хоногийн өмнө.

20.11.Кино зураг авалт хийх зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

20.12.Зөвшөөрөл олгосон кино зураг авалт хийх, кино бүтээхтэй холбоотой үүссэн хохирол, нөхөн төлбөрийг Зөвлөл хариуцахгүй.”

2 дугаар зүйл. Кино урлагийг дэмжих тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.5 дахь заалт:

“7.1.4.кино зураг авалтын үед баримтлах заавар батлах;
7.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.”

2/20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.2.4, 20.2.5, 20.2.6, 20.2.7, 20.2.8, 20.2.9, 20.2.10, 20.2.11, 20.2.12 дахь заалт, 20.3, 20.5 дахь хэсэг:

“20.1.Гадаадын иргэн, хуулийн этгээдэд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхэд зөвшөөрөл олгоно. Зөвшөөрөл олгосныг зөвшөөрлийн баримт бичиг буюу гэрчилгээг олгож баталгаажуулна.

20.2.4.хариуцлагын даатгалын баримт;

20.2.5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу хураамж төлсөн баримт;

20.2.6.жүжигчид болон зураг авалтын багийн дэлгэрэнгүй мэдээлэл, гадаад ын иргэдийн паспортын хуулбар;

20.2.7.зураг авалтын байршил, зураг авалтын хугацаа;

20.2.8.түр хугацаагаар оруулж ирэх тоног төхөөрөмжийн жагсаалт;

20.2.9.байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх мэдээлэл;

20.2.10.хамтран ажиллах этгээдтэй гэрээ байгуулсан бол гэрээний хуулбар;

20.2.11.зураг авалт, кино нь бодит амьдралаас сэдэвлэсэн, бодит хүнийг дүрсэлсэн бол тухайн хүн, холбогдох этгээдийн зөвшөөрөл, амьтан, тэсрэх бодис, галт зэвсэг, сум ашиглах, кино зураглал, тээврийн хэрэгсэл, тусгай эффект гэх мэт зураг авалтын онцлогоос хамааран шаардлагатай бусад баримт бичиг, мэдээлэл;

20.2.12.шаардлагатай тохиолдолд Зөвлөлөөс шаардсан нэмэлт мэдээлэл.

20.3.Энэ хуулийн 20.1-д заасан зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

20.5.Зөвшөөрлийн үндсэн дээр кино зураг авалт хийж байгаа этгээд нь кино зураг авалт хийх зөвшөөрөлд заасан байршил, хугацаа, агуулгыг өөрчлөх тохиолдол бүрд Зөвлөлд мэдэгдэх бөгөөд Зөвлөл зөвшөөрөлд зохих өөрчлөлтийг оруулна.”

3 дугаар зүйл. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Кино бүтээх зорилгоор” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7, 20.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Кибер аюулгүй байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:

“3.4.Энэ хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2/9¹ дүгээр зүйл:

“9¹ дүгээр зүйл. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх

9¹.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авч, хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан гэж үзвэл зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргаж, бүртгэлийн гэрчилгээ олгоно.

9¹.2.Зөвшөөрөл хүсэгч өргөдөлд зөвшөөрлийн ангилал, түүнд холбогдох үйл ажиллагааны зорилго, үндэслэлийг тодорхой тусгах бөгөөд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

9¹.2.1.зөвшөөрөлд тавигдах хуульд заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг;

9¹.2.2.энэ хуулийн 8.2, 9.2, 9.3-т заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг.

9¹.3.Зөвшөөрлийн хугацаа нь зөвшөөрөл эзэмшигчийн орон тооны ажилтны олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллага, эсхүл түүнтэй дүйцэхүйц байгууллагаас олгосон хүчин төгөлдөр зөвшөөрөл олгосон гэрчилгээний дуусах хугацаатай адил байна.

9¹.4.Зөвшөөрөл эзэмшигч өөрийн орон тооны ажилтан өөрчлөгдсөн талаарх мэдээллийг тухай бүр цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, зөвшөөрөл олгосон гэрчилгээнд өөрчлөлт оруулсан бүртгэлийг хийлгэнэ.

9^{1.5}.Энэ хуулийн 9^{1.4}-т заасан бүртгэлийг хийлгээгүй нь зөвшөөрөл эзэмшигчийн эрхийг хүчингүйд тооцох үндэслэл болно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсгийн “гэрчилгээ” гэснийг “гэрчилгээг 30 хоногийн хугацаатай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “импортын зөвшөөрөл олгох” гэснийг, 31 дүгээр зүйлийн 31.3.3 дахь заалтын “экспортлох” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуульд дараах агуулгатай 9.13 дахь хэсэг нэмсүгэй:

9.13.Энэ хуулийн 9.1-д заасан тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 15 дахь хэсэгт заасан зохицуулалт үйлчлэхгүй.”

2 дугаар зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийн “тус бүрд” гэсний дараа, мөн зүйлийн 9.9 дэх хэсгийн “сорьцод” гэсний дараа “180 хоногийн хугацаагаар” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.12 дахь хэсгийг доор дурсанаар өөрчлөн найруулсугай:

“9.3.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

9.12.Тусгай зөвшөөрлөөр ашиглаж байгаа малын генетик нөөцийн бүртгэл, технологийн хяналтыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.”

4 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “12.6, 12.7, 12.8, 12.9-д заасан” гэснийг “12.7, 12.8, 12.9, 12.10-т заасан” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.4, 20.5, 20.6 дахь хэсэг нэмсүгэй:

“20.4.Харьяа нутаг дэвсгэрт хамаарах нийтийн эзэмшлийн гудамж, талбайд худалдаа, үйлчилгээний зориулалтаар талбай ашиглуулах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга олгоно.

20.5.Энэ зүйлийн 20.4-т заасан зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар олгох бөгөөд дуудлага худалдаа зохион байгуулах журмыг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

20.6.Энэ хуулийн 20.4-т заасан зөвшөөрлийн хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.3, 25.4, 25.5, 25.6, 25.7, 25.8, 25.9, 25.10, 25.11 дэх хэсэг нэмсүгэй:

“25.3.Улсын хилийн зурвас, бүс, боомтод нэвтрэх зөвшөөрөл хүсэгч иргэн өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

25.3.1.хүний тоо, зорилго, хугацаа, замнал, байрлах газар;

25.3.2.иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг, гадаадын иргэн бол хүчин төгөлдөр паспортын хуулбар, Монгол Улсад түр оршин суух үнэмлэх;

25.3.3.тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар.

25.4.Улсын хилийн зурвас, бүс, боомтод нэвтрэх зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд өргөдөлд дараах бичиг баримтыг хавсаргана.

25.4.1.үйл ажиллагаа явуулах зорилго, хугацаа, замнал, байрлах газрыг тусгасан, бүдүүвч зураг;

25.4.2.байгууллагын гэрчилгээ, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх бол тусгай зөвшөөрөл, гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

25.4.3.тээврийн хэрэгсэл, тусгай зориулалтын техникийн жагсаалт, тэдгээрийн гэрчилгээний хуулбар;

25.4.4.ажилтнуудын нэрс, тэдгээрийн иргэний үнэмлэх, гадаадын иргэн бол хүчин төгөлдөр паспортын хуулбар, Монгол Улсад түр оршин суух үнэмлэх, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хуулбар.

25.5.Энэ хуулийн 26.2.2-т заасны дагуу Засгийн газраас олгосон эрх, тусгай зөвшөөрлийг үндэслэн улсын хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хилийн зурвас, бүс, боомт нэвтрэх зөвшөөрлийг олгоно.

25.6.Энэ зүйлийн 25.3, 25.4, 25.5-д заасан бичиг баримт нь эрх бүхий байгууллагад байгаа, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системээс татан авах боломжтой бол иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.

25.7.Хил хамгаалах ерөнхий газар болон орон нутагт байрлах хилийн анги /салбар/ нь холбогдох бичиг баримтыг үндэслэн улсын хилийн зурвас, бүс, боомтод

нэвтрэх зөвшөөрлийг тухай бүр шуурхай олгох бөгөөд нэмэлт тодруулга авах тохиолдолд ажлын таван өдрийн дотор шийдвэрлэнэ.

25.8.Хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх зөвшөөрлийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын зөвшөөрлийг үндэслэн ажлын нэг өдрийн дотор олгоно.”

25.9.Улсын хилийн зурвас, бүс, боомтод нэвтрэх зөвшөөрөл нь эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тэмдгээр баталгаажуулсан хэвлэмэл хуудас бүхий байна.

25.10.Зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаагаа явуулахдаа хилийн дэглэмийн гэрээ, энэ хууль бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, хил хамгаалах байгууллагын ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

25.11.Энэ хуулийн 25.10-т заасныг зөрчсөн тохиолдолд улсын хилийн зурвас, бүс, боомтод нэвтрэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл.Монгол Улсын хилийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“25.2.Энэ хуулийн 26.2.3, 30.2.3-т заасан зөвшөөрлийг улсын хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас нэг жил хүртэл хугацаагаар, энэ хуулийн 30.2.3-т заасан зөвшөөрлийг тухайн орон нутагт байрлах хилийн анги /салбар/ 30 хоног хүртэл хугацаагаар тус тус олгож, хяналт тавина.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МУЗЕЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Музейн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.8, 5.9, 5.10, 5.11 дэх хэсэг нэмсүгэй:

“5.8.Иргэн, хуулийн этгээд музей байгуулах тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

5.8.1.музей байгуулах үндэслэл хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон албан бичиг;

5.8.2.музейн зориулалтаар ашиглах барилга байгууламжийн мэдээлэл;

5.8.3.музейн зориулалтаар ашиглах соёлын үнэт зүйлийн жагсаалт;

5.8.4.музей байгуулахыг дэмжсэн аймаг, нийслэлийн Засаг даргын тодорхойлолт.

5.9.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага иргэн хуулийн этгээдийн хүсэлтийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэнэ.

5.10.Иргэн, хуулийн этгээд музейн зориулалтаар ашиглах соёлын биет өвийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

5.11.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хангахаас татгалзаж, холбогдох баримт бичгийг буцаан хүргүүлнэ:

5.11.1.соёлын биет өвийн гарал үүсэл тодорхойгүй;

5.11.2.соёлын үнэт зүйл зохиогчийн эрхийн зөрчилтэй болох нь тогтоогдсон;

5.11.3.соёлын үнэт зүйлс гэмт хэрэг зөрчлийн нотлох баримтад тооцогдсон;

5.11.4.эрх бүхий байгууллагаас барилга байгууламжийг ашиглахыг хориглосон дүгнэлт гаргасан.”

2 дугаар зүйл.Музейн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.3.Музейн үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.5-д заасан тусгай зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд эрхэлнэ.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмсүгэй:

“14.6.Мэргэжлийн сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх асуудлыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1, 5.2, 5.3 дугаар зүйл, 6.1, 6.2 дугаар зүйл, Боловсролын тухай хуулийн 21-24 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

14.4.Энэ хуулийн 4.1.4-т заасан мэргэжлийн сургалтыг хуульд заасны дагуу бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд эрхэлж болно.”

3 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуульд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.4-т” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.1.36, 13.1.37 дахь заалт:

“13.1.36.Энэ хуулийн 13.1.34-т заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.

13.1.37.хуульд заасан бусад бүрэн эрх.”

2/28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэг:

“28.6.Хил хамгаалах байгууллага хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу улсын хилийн шугам дайран гарсан ойд улсын хил тод харагдахаар зурвас гаргах, сэргээх ажлыг төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр хийх бөгөөд дээрх зурвасаас гарсан модыг хуульд заасны дагуу ашиглаж болно.”

3/34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг:

“34.5.Энэ хуулийн 33.1-д заасан гэрээ байгуулах, 34.1-д заасан гарал үүслийн гэрчилгээ, түүнийг олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

4/35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг:

“35.3.Иргэн энэ хуулийн 35.2-т заасны дагуу мод бэлтгэх хүсэлтийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргаж, гэрээ байгуулсны үндсэн дээр мод бэлтгэнэ.”

2 дугаар зүйл. Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.35 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“13.1.35.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.11-д заасан ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох;”

3 дугаар зүйл. Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8.2 дахь заалтын “эзэмшихийг зөвшөөрсөн” гэснийг “эзэмшүүлэх талаарх” гэж, мөн зүйлийн 21.9 дэх хэсгийн “байгуулж, гэрчилгээ олгоно” гэснийг “байгуулна” гэж, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “эрхийн бичигт” гэснийг “гарал үүслийн гэрчилгээнд” гэж, мөн

зүйлийн 34.3 дахь хэсгийн “эрхийн бичгийг” гэснийг “гарал үүслийн гэрчилгээг” гэж, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн “Зохих зөвшөөрөл авсан иргэн” гэснийг “Иргэн” гэж, мөн зүйлийн 35.3 дахь хэсгийн “Зохих зөвшөөрөл авсан” гэснийг “Гэрээ байгуулсан” гэж, мөн зүйлийн 35.4.1 дэх заалтын “зөвшөөрлийн баримт бичигт” гэснийг “гарал үүслийн гэрчилгээнд” гэж, 35.4.2 дахь заалтын “зөвшөөрөлгүйгээр” гэснийг “гарал үүслийн гэрчилгээгүйгээр” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтын “/мод бэлтгэхийг зөвшөөрсөн тухай эрх бүхий этгээдийн шийдвэр/”, 34 дүгээр зүйлийн гарчгийн, 34.1 дэх хэсгийн “эрхийн бичиг,”, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн “зохих зөвшөөрөл авсан” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.23 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТЭМДГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай тайлбар нэмсүгэй:

“Тайлбар: Энэ хуульд заасан “согтууруулах ундаа” гэдэгт Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 6.1¹ дэх хэсэгт заасан бүтээгдэхүүнийг ойлгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг:

“7.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.5, 9.6, 9.7, 9.9, 9.14-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Харилцаа холбооны тухай хуулиар зохицуулна.”

2/9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг:

“9.2.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд эзэмшлийн мэдээллийг Зохицуулах хорооноос баталсан маягтад нийцүүлэн хавсаргаж ирүүлэх бөгөөд хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийг эзэмшлийн мэдээлэлд дурдана.”

3/10 дугаар зүйлийн 10.6, 10.7, 10.8, 10.9, 10.10, 10.11 дэх хэсэг:

“10.6.Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгоно. Сонгон шалгаруулалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

10.7.Сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг олон нийтэд ил тод мэдээлэх бөгөөд энэ хугацааг нэг удаа 14 хоногоор сунгаж болно.

10.8.Сонгон шалгаруулалтад энэ хуульд заасан шаардлагаас гадна дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

10.8.1.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага хангасан байдал;

10.8.2.өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүргэхээр төлөвлөсөн энэ хуулийн 8.1.1-д заасан стратеги төлөвлөгөө нь төрөөс баримтлах бодлого, энэ хуульд заасан зарчим, шаардлагыг хангасан байдал;

10.8.3.зохицуулалтын чиглэлийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлснээр үүсэх үр дүн;

10.8.4.үйлчилгээний төлөвлөлт, хөтөлбөр, техник технологийн сонголт нь энэ хуулийн Тавдугаар бүлэгт заасан тавигдах шаардлагыг хангасан байдал;

10.8.5.өрсөлдөөн, зах зээлд үзүүлэх нөлөө.

10.9.Энэ хуулийн 10.8-д заасан нөхцөлийн дагуу үнэлгээ өгч, хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдэд тусгай зөвшөөрөл олгоно.

10.10.Энэ хуулийн 10.9-д заасны дагуу шалгарсан этгээд эрх бүхий этгээдээс шалгарсан тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээг байгуулаагүй тохиолдолд дараагийн хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдтэй гэрээ байгуулна.

10.11.Энэ хуулийн 10.6-д заасан сонгон шалгаруулалтаар 1 этгээд хүсэлт ирүүлсэн бол тухайн этгээд хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд шалгарсан тухай мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулж тусгай зөвшөөрлийг олгоно.

10.12.Дараах тохиолдолд сонгон шалгаруулалтыг дахин зарлана:

10.12.1.энэ хуулийн 10.7-д заасан хугацаанд хүсэлт ирүүлээгүй;

10.12.2.сонирхогч этгээдийн ирүүлсэн хүсэлт нь хуульд заасан шаардлага хангаагүй;

10.12.3.энэ хуулийн 10.10-т заасан хугацаанд гэрээ байгуулаагүй.

10.13.Энэ хуулийн 10.12.1-д заасны дагуу зарласан сонгон шалгаруулалтад сонирхогч этгээд хүсэлт ирүүлээгүй бол тухайн жилд дахин сонгон шалгаруулалт зарлахгүй.

10.14.Тусгай зөвшөөрөлтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Харилцаа холбооны тухай хуулиар зохицуулна.”

4/13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг:

“13.5.Зохицуулах хороо Харилцаа холбооны тухай хуулийн 14.11-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана.”

5/30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт:

“30.1.10.хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;”

2 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “сүлжээгээр” гэсний дараа “, интернэт протоколд суурилж” гэж, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалтын “энэ хуулийн” гэсний дараа “6.1.3,” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Зохицуулах хороо” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.5, 9.14-д заасан тусгай зөвшөөрлийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг:

“12.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.14-т заасан тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаатай, 9.5, 9.9-д заасан тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаатай олгож, хугацааг анх олгосон хугацаагаар сунгана.”

2/14 дүгээр зүйл:

“14 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

14.1.Тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн 14.12-т зааснаас гадна доор дурдсан үндэслэлээр 90 хүртэл хоногийн хугацаагаар түдгэлзүүлнэ:

14.1.1.Зохицуулах хорооны хяналт, мониторингийн тайлан, шалгалтаар холбогдох хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон;

14.1.2.тусгай зөвшөөрөлд заасан үйлчилгээ эрхлэх хүрээ, байршилд үйл ажиллагаа явуулаагүй;

14.1.3.оюуны өмчийн эрхийг удаа дараа зөрчсөн нь холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон.

14.2.Зохицуулах хороо энэ хуулийн 14.1.3-т заасан үндэслэл, нөхцөл, шаардлага арилгасан гэж үзвэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.”

3/15 дугаар зүйл:

“15 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл шилжүүлэх

15.1.Тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 18-д зааснаас гадна өөрийн компанийн нэгдлээс бусдад шилжүүлэхийг хориглоно.

15.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн компанийн нэгдэлд тусгай зөвшөөрлийг шилжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг хамтад нь шилжүүлнэ.”

4/30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалт:

“30.1.9.өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоох.”

4 дүгээр зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.4 дэх заалтын “хамрах хүрээ” гэснийг “үйлчилгээ эрхлэх хүрээ, байршил” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “Зохицуулах хорооноос тогтоосон” гэснийг “стратегийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай” гэж, мөн зүйлийн 8.1.3 дахь заалтын

“өнгөрөөгүй” гэснийг “өнгөрсөн” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “гурван сарын” гэснийг “30-аас доошгүй хоногийн” гэж, мөн хэсгийн “гаргаж болно.” гэснийг “гаргана.” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “хамрах хүрээнд” гэснийг “үйлчилгээ эрхлэх хүрээ, байршилд” гэж, мөн зүйлийн 21.2 дахь хэсгийн “найдвартай ажиллагаа, стандартын” гэснийг “найдвартай, үндэсний стандарт, норматив баримт бичгийн” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалтын дугаарыг “30.1.11” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалтын “6.1.1” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрсөлдөөний тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.4, 6.5, 6.6, 6.7 дахь хэсэг нэмсүгэй:

“6.4.Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч бараа бүтээгдэхүүнийхээ тоо, хэмжээ, үнэд өөрчлөлт оруулах тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт өргөдөл гаргана.

6.5. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, нэмэлт мэдээ, мэдээлэл, баримт материалыг гаргуулан авах шаардлагатай гэж үзвэл энэ талаар зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчид мэдэгдэнэ.

6.6.Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч нь нэмэлт мэдээ, мэдээлэл, баримт материалыг бүрдүүлж ирүүлэх хугацаа 30 хүртэл хоног байна.

6.7.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн өргөдөл энэ зүйлийн 6.5-д заасан баримт бичгийн бүрдлийг хангасан гэж үзвэл бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн өөрчлөлтийг 30 хоногийн дотор хянан зөвшөөрөл олгоно.

2 дугаар зүйл.Өрсөлдөөний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “зөвшөөрсөн, эсхүл татгалзсан” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Радио долгионы тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

“9.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Харилцаа холбооны тухай хуулиар зохицуулна.”

2/18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт:

“18.1.4.энэ хуулийн 5.2.6-д баримт бичгийн дагуу шинэ төрлийн дэвшилтэт технологи, үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор радио давтамжийн зурвасыг дахин хуваарилсан.”

2 дугаар зүйл. Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.6 дахь заалтад “батлах” гэсний дараа “, хүснэгтэд сонгон шалгаруулалтаар олгох радио давтамжийн зурвасыг тодорхойлох” гэж, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “зөвшөөрлийн хугацааг” гэсний дараа “анх олгосон хугацаагаар” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Радио долгионы тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5¹ дүгээр зүйлийн 5¹.1.11 дэх заалт:

“5¹.1.11.радио давтамжийн зурвасыг олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;”

2/11 дүгээр зүйл:

“11 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох

11.1.Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.8, 8.2 дугаар зүйлийн 8.3-т заасан тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл /цаашид “эрхийн бичиг” гэх/ олгох бөгөөд тусгай зөвөөшөрл, эрхийн бичиг авах өргөдлийг хүлээн авч өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 10.1, 13.3-т заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянана.

11.2.Зохицуулах хороо нь радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл авах өргөдлийг хүлээн авснаас хойш Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

11.2.1.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох;

11.2.2.Харилцаа холбооны тухай хуулийн 14.2-т заасан үндэслэлээр, эсхүл тухайн радио давтамж нь тусгай хэрэглээний ангилалд орсон, хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл, эрхийн бичгээр ашиглагдаж байгаа, радио давтамжийн үйлчлэх хүрээтэй давхацсан, радио давтамжийн нөөц байхгүй, харилцан нөлөөлөл үүсгэх бол радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах.

11.3.Тухайн радио давтамжийг ашиглах асуудлыг олон улсын байгууллага зохицуулдаг бол уг радио давтамжийг олон улсын байгууллагаас санал авсны үндсэн дээр энэ хуулийн 11.1-д заасны дагуу ашиглах зөвшөөрөл олгоно.

11.4.Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тодорхойлсноос гадна ижил радио давтамжийг нэг нутаг дэвсгэрт ашиглах тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд сонгон шалгаруулах журмаар тусгай зөвшөөрөл олгоно. Сонгон шалгаруулалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

11.5.Сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг олон нийтэд ил тод мэдээлэх бөгөөд энэ хугацааг нэг удаа 14 хоногоор сунгаж болно.

11.6.Сонгон шалгаруулалтын үнэлгээнд дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

11.6.1.радио давтамж ашиглан байгуулах сүлжээ, үйлчилгээний төрөл, түүний хамрах нутаг дэвсгэр;

11.6.2.техник, технологийн сонголт, үзүүлэлт;

11.6.3.үйлчилгээ хүргэх хугацааны төлөвлөлт;

11.6.4.өрсөлдөөн, зах зээлд үзүүлэх нөлөө;

11.6.5.санхүүгийн төлөвлөлт, чадавх;

11.6.6.хүний нөөцийн чадавх;

11.6.7.тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага хангах байдал.

11.7.Энэ хуулийн 11.6-д заасан нөхцөлийн дагуу үнэлгээ өгч, хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдэд тусгай зөвшөөрөл олгоно.

11.8.Энэ хуулийн 11.7-д заасны дагуу шалгарсан этгээд эрх бүхий этгээдээс шалгарсан тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээг байгуулаагүй тохиолдолд дараагийн хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдтэй гэрээ байгуулна.

11.9.Энэ хуулийн 11.5-д заасан сонгон шалгаруулалтаар 1 этгээд хүсэлт ирүүлсэн бол тухайн этгээд хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд

шалгарсан тухай мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулж тусгай зөвшөөрлийг олгоно.

11.10. Дараах тохиолдолд сонгон шалгаруулалтыг дахин зарлана:

11.10.1. энэ хуулийн 11.5-д заасан хугацаанд хүсэлт ирүүлээгүй;

11.10.2. сонирхогч этгээдийн ирүүлсэн хүсэлт нь хуульд заасан шаардлага хангаагүй;

11.10.3. энэ хуулийн 11.9-д заасан хугацаанд гэрээ байгуулаагүй.

11.11. Энэ хуулийн 11.10.1-д заасны дагуу зарласан сонгон шалгаруулалтад сонирхогч этгээд хүсэлт ирүүлээгүй бол тухайн жилд дахин сонгон шалгаруулалт зарлахгүй.

11.12. Зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд нь түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлж, гэрээ байгуулна. Жилийн төлбөр төлөөгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохгүй.

11.13. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохдоо тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах бөгөөд гэрээнд радио давтамж, радио давтамжийн зурвас, үйлчлэх нутаг дэвсгэр, ашиглах зориулалт, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, технологи, зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, төлбөрийн зохицуулалтыг тусгана.”

2/13 дугаар зүйл:

“13 дугаар зүйл. Эрхийн бичиг

13.1. Иргэн, хуулийн этгээд хувийн болон дотоод хэрэглээний харилцаанд зориулан радио холбоо зохион байгуулах, эрдэм шинжилгээ, туршилтын ажиллагаа явуулах бусад бүх төрлийн радио төхөөрөмжийг нийтийн үйлчилгээний бус зориулалтаар ашиглахад зөвшөөрөл авах бөгөөд радио давтамж ашиглах эрхийг баталгаажуулсан баримт бичиг /цаашид “эрхийн бичиг” гэх/олгоно.

13.2. Эрхийн бичиг авах өргөдөлд өргөдөл гаргагчийн нэр, албан ёсны хаяг, утас ба факсны дугаар, газар зүйн байршил, хамрах хүрээ, ашиглалтын зориулалт, ашиглах радио төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг тусгана.

13.3. Иргэн, хуулийн этгээд эрхийн бичиг хүссэн өргөдөлд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна радио төхөөрөмжийн байгуулалтын зураглал, ажиллах зарчим, газар зүйн байршил, хамрах нутаг дэвсгэр, ашиглах радио давтамж, радио давтамжийн зурвас, технологи, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг нотолсон баримт бичиг, радио төхөөрөмжийг баталгаажуулсан тухай эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг хавсаргана.

13.4. Зохицуулах хороо өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгаж, хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан гэж үзвэл эрхийн бичиг олгох тухай шийдвэр гаргах бөгөөд шийдвэр нь Зохицуулах хорооны даргын тушаал байна.

13.5.Эрхийн бичгийн хугацаа 3 жилээр олгох бөгөөд хугацааг анх олгосон хугацаагаар сунгана.

13.6.Эрдэм шинжилгээ, туршилт болон сонирхогчийн радио станцын зориулалтаар ашиглах эрхийн бичгийн хугацаа 3 сараар олгох бөгөөд хугацааг анх олгосон хугацаагаар нэг удаа сунгаж болно.

13.7.Эрхийн бичигт радио төхөөрөмжийн байршил, хамрах нутаг дэвсгэр, радио давтамж, хүчин чадал, технологи, зөвшөөрлийн хугацаа, ашиглалтын зориулалтыг заана.

13.8.Ижил радио давтамж ашиглах эрхийн бичиг авахаар хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд эхний ээлжинд өргөдөл гаргаж бүртгүүлсэн этгээдэд түүнийг олгоно.

13.9.Эрхийн бичиг олгох тухай шийдвэрийг мэдэгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор зөвшөөрөл хүсэгч этгээд нь эрхийн бичгийн төлбөрийг жилээр, энэ хуулийн 13.6-д заасан зориулалтаар ашиглах бол зөвшөөрөлд заасан хугацаагаар эрхийн бичгийн төлбөрийг төлнө.

13.10.Эрхийн бичигт дараах тохиолдолд өөрчлөлт оруулна:

13.10.1.эрхийн бичиг эзэмшигч хүсэлт гаргасан;

13.10.2.эрхийн бичгийн төрөл, ангилал, радио давтамж, радио давтамжийн зурваст харилцан нөлөөлөл орсноос эрхийн бичигт зайлшгүй өөрчлөлт оруулахаар Зохицуулах хорооноос шийдвэрлэсэн.

13.11.Энэ хуулийн 13.10.1-д заасан хүсэлтэд тухайн эрхийн бичгээр эрхлэх үйлчилгээний хамрах хүрээ, техник технологийн шийдэл, тоног төхөөрөмжийн тоо, ширхэг, радио давтамж болон радио давтамжийн зурваст өөрчлөлт оруулах саналыг тусгасан байна.

13.12.Зохицуулах хороо энэ хуулийн 13.10.2-т заасны дагуу өөрчлөлт оруулах бол 30-аас доошгүй хоногийн өмнө өөрчлөлт оруулах шалтгаан, нөхцөлийн талаар эрхийн бичиг эзэмшигчид мэдэгдэнэ.

13.13.Эрхийн бичиг эзэмшигч нь эрхийн бичгийг анх авсан зориулалтаар бусад этгээдэд шилжүүлж болно. Шилжүүлэн авах хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, иргэн бол иргэний үнэмлэхийг магадлан шалгаж эрхийн бичгийг шилжүүлнэ.

4 дүгээр зүйл.Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.11 дэх заалтын дугаарыг “5¹.1.12” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “үйл ажиллагаа эхлэх дуусах” гэснийг “технологи, зөвшөөрлийн” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “20 хүртэл” гэснийг “5” гэж, 12.2 дахь хэсгийн “60” гэснийг “30” гэж, 12.3 дахь хэсгийн “10 өдрийн дотор” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан хугацаанд багтаан” гэж, 14 дүгээр зүйлийн нэрийн “давтамж” гэснийг “давтамжийг” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн нэрийн “тусгай” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/5¹ дүгээр зүйл:

“5¹ дүгээр зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох төсөл сонгон шалгаруулах журам

5¹.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын урилгыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар/ үндэсний өдөр тутмын хэвлэл болон цахим хуудсаараа дамжуулан нийтэд зарлах ба төсөл хүлээн авах хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.

5¹.2.Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан ерөнхий нөхцөл, шаардлагыг хангаж байгаа тухай баримт, энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан баримт бичиг болон сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлтийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар/-д ирүүлнэ.

5¹.3.Энэ хуулийн 5¹.2.-т заасан баримт бичгийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар/ хүлээн авч, сонгон шалгаруулалтын ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх)-ийг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн /аймаг, нийслэлийн Засаг дарга/-ий шийдвэрээр байгуулна.

5¹.4.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төрийн захиргааны байгууллагын хүнс, эрүүл мэнд, хууль эрх зүй, хүнсний салбарын эрдэм шинжилгээ, сургалтын болон төрийн бус байгууллагын холбогдох төлөөллийг оролцуулна.

5¹.5.Ажлын хэсэг нь хуулийн этгээдийн ирүүлсэн баримт бичигт согтууруулах ундааны төрөл тус бүрээр энэ хуулийн 5¹.6-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргана.

5¹.6.Согтууруулах ундааны үйлдвэрийн төслийн баримт бичигт дараах үнэлгээг хийнэ:

5¹.6.1.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад ирүүлсэн согтууруулах ундааны үйлдвэрийн төслийн баримт бичиг, саналыг согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт, заавал мөрдөх стандартын шаардлагын дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

5¹.6.2.Согтууруулах ундааны үйлдвэрийн төслийн баримт бичиг нь удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, үйлдвэрийн үйл ажиллагаа, дүгнэлт гэсэн хэсгээс бүрдсэн байна.

5¹.6.2.1.тусгай зөвшөөрөл хүсэгчийн талаарх мэдээлэлд төслийн товч агуулга, хуулийн этгээдийн нэр, үйлдвэрийн байршил, нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр, төрөл, жилийн эргэлт, борлуулалт, экспортод эзлэх хувь, одоогийн эрхэлж байгаа бизнесийн талаарх мэдээллийг тусгана.

5¹.6.2.2.удирдлага, зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын мэдээллийн хэсэгт удирдлагын бүтэц, орон тоо, ажиллагсдын мэргэжил, мэргэшлийн ур чадвар, шинээр бий болгох ажлын байрны тоо, аймаг, нийслэл, орон нутгийн бүртгэлтэй ажилгүй иргэдээс авч ажиллуулах хүний тоо;

5¹.6.2.3.зах зээлийн судалгааны хэсэгт зах зээлийн төлөв байдал, SWOT шинжилгээ, хэрэглэгчдийн тодорхойлолт;

5¹.6.2.4.эдийн засгийн тооцооны хэсэгт үндсэн үйлдвэрлэл, нийт орлого, борлуулалтын орлогын тооцоо, үйлдвэрлэлийн зардлын тооцоо, бүтээгдэхүүний өртгийн тооцоо, төлөвлөж байгаа борлуулалтын төлөвлөгөө, үйлдвэрлэлийн үр ашгийн тооцоо, төслийн өгөөж, өртгийн тооцоо, төслийн эрсдлийн удирдлагын тооцоо, байгаль орчинд ээлтэй болон хор хөнөөлгүй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулах тооцоо;

5¹.6.2.5.үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэсэгт түүхий эдийн чанарын үзүүлэлт, түүхий эдийн нөөц, үйлдвэрлэлийн хүчин чадал, үйлдвэрлэлийн технологийн ажиллагаа, Үүнд: а/үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр төлөвлөсөн дэвшилтэт технологи, технологийн заавар, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, агуулах, тээврийн хэрэгсэл, үүнээс нэвтрүүлэхээр төлөвлөсөн дэвшилтэт тоног төхөөрөмж, лонх, сав, баглаа боодол, шошгололт, бүтээгдэхүүн, түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлт; б/дотоод хяналтын лаборатори болон бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын дотоод хяналт, удирдлагын тогтолцооны бүрдүүлэлт, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, буцаан болон татан авалт, дотоод хяналт, шалгалтын бүртгэл;в/Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон галын аюулгүй байдлыг хангах нөхцөл, хөдөлмөрийн дотоод дүрэм;

5¹.6.2.6.энэ хуулийн 6.1.1-6.1.11-д заасан баримт бичгийн бүрдэл;

5¹.6.2.7.тоног төхөөрөмжийн жагсаалт, зураг, үйлдвэрийн гадна орчин, барилга байгууламж, үйлдвэрлэлийн зураг төслийн иж бүрдэл;

5¹.6.2.8.дүгнэлтэд энэ хуулийн 5¹.6.2.1.- 5¹.6.2.7-д заасан тооцоо судалгаанд үндэслэн төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн, эрсдэл зэргийг тооцоолсон мэдээллийг тусгана.

5¹.6.3.Энэ хуулийн 5¹.6.1-д заасны дагуу шалгуур үзүүлэлтийг ажлын хэсгийн гишүүн бүр оноогоор үнэлж, оноог гишүүдийн дундаж үнэлгээгээр гаргана.

5¹.6.4.Ажлын хэсэг нь согтууруулах ундааны үйлдвэрлэл явуулах газар дээр нь хяналт тавьж болох ба шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй.

5¹.6.5.Энэ хуулийн 5¹.5-д заасан дүгнэлтийг ажлын 10 өдөрт багтаан гаргаж хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн /аймаг, нийслэлийн Засаг дарга/-д хүргүүлнэ.”

2/15¹ дүгээр зүйл:

“15¹ дүгээр зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох

15¹.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд нь тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагчид дараах баримт бичгийн хамт албан бичиг /цахим/-ээр хүргүүлнэ:

15¹.1.1.тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг /эрхлэх үйлчилгээний төрөл, оноосон нэр, байрлах хаяг, харилцах утсыг тодорхой дурдах/;

15¹.1.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

15¹.1.3.хяналтын эрх бүхий байгууллагаас тухайн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагааг эрхлэх талаар гаргасан улсын байцаагчийн болон ажлын байрны дүгнэлт;

15¹.1.4.худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлагыг дүгнэсэн стандартын хуудасны хуулбар;

15¹.1.5.тухайн үйл ажиллагааг эрхлэх байранд хийгдсэн онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын галын дүгнэлт.

15¹.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нь тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан журмыг баримтлан хугацаанд нь шийдвэрлэнэ.

15¹.3.Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах ажлын хэсгийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагчийн захирамжаар байгуулна. Ажлын хэсэг баримт бичгийн бүрдэл шалгах болон магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд хийж шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

15¹.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нь энэ хуулийн 15¹.3-т заасан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн шаардлага хангасан хуулийн этгээдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоно.

15¹.5.Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд шийдвэр гарснаас хойш ажлын 2 өдрийн дотор үндэслэлийг тодорхой дурдсан мэдэгдлийг тухайн хуулийн этгээдэд хүргүүлнэ.”

3/15² дугаар зүйл:

“15² дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

15².1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан этгээдэд дараах баримт бичгийг хүргүүлнэ:

15².1.1.тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай өргөдөл;

15².1.2.цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

15².1.3.тухайн баг, хорооны Засаг даргын санал;

15².1.4.хяналтын улсын байцаагчийн дүгнэлт.”

4/5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсэг

“5.10.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

5/14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн 14.5.8, 14.5.9, 14.5.10 дахь заалт, 14.16 дахь хэсэг:

“14.5.8.энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан шинжилгээнд хамруулж, эрүүл ахуйн шаардлага хангасан талаарх баримт;

14.5.9.импортын согтууруулах ундаа хадгалах барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын санал;

14.5.10.татварын өргүй талаар татварын байгууллагын тодорхойлолт.

14.16.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

6/15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсэг:

“15.10.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “шийдвэрлэж болно.” гэсний дараа “Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.1.7, 6.1.8, 6.1.10, 6.1.11-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ.” гэж, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “зөвшөөрөл хүсэгч нь” гэсний дараа “зөвшөөрөл шинээр авах болон хугацаа сунгуулахад” гэж, 14.9 дэх хэсгийн “болно.” гэсний дараа “Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг дүгнэсний үндсэн дээр сунгах асуудлыг шийдвэрлэх ба тусгай зөвшөөрлийн

нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “захирагч” гэсний дараа “энэ хуулийн 15¹ дүгээр зүйлд заасны дагуу” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.2.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан журмын дагуу төсөл сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр олгоно.”

4 дүгээр зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “татвар, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 5.2-т заасан журмын дагуу” гэснийг “татварын байгууллагын санал, хяналтын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн” гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “баримтална.” гэснийг “баримтлах ба 10 жилээс дээш хугацаагаар сунгахгүй.” гэж, 14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсгийн “сунгаж болно.”, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “сунгана.” гэснийг “сунгаж болох ба 5 жилээс дээш хугацаагаар сунгахгүй.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “, импортлох тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/27 дугаар зүйлийн 27.12 дахь хэсэг:

“27.12.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.6, 6.7-д заасан судалгаа хийх зөвшөөрөл авах хүсэлтээ соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана. Хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

27.12.1.судалгаа хийх үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон албан бичиг;

27.12.2.судалгааны ажлын баталгаажсан удирдамж;

27.12.3.дотоод, гадаадын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх бол хамтын ажиллагааны гэрээ;

27.12.4.судалгааны ажлыг гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнийг томилсон тушаалын хуулбар.”

2/27¹ дугаар зүйл:

“27¹ дугаар зүйл.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл

27¹.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 10 өдөрт багтаан хүсэлтийг энэ хуулийн 14.1.12-т заасан палеонтологи, археологийн болон соёлын биет бус өвийн Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулна.

27¹.2.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд зөвшөөрөлд заасан хугацаанд судалгааны ажлыг гүйцэтгэж, тайланг тухайн жилд багтаан соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

27¹.3.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас зөвшөөрөлд заасан хугацаанд судалгааны ажлыг гүйцэтгэх боломжгүй болсон бол энэ тухайн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдэгдэж, зөвшөөрлийн хугацааг сунгуулж болно.

27¹.4.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон бол соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгосон зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.

27¹.5.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээдэд судалгаа хийх зөвшөөрөл олгосон талаар тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ.”

3/46 дугаар зүйлийн 46.8, 46.9, 46.10, 46.11, 46.12 дахь хэсэг:

“46.8.Энэ хуулийн 46.1-д заасан мэргэжлийн байгууллага, иргэн соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрөл авах хүсэлтээ соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана. Хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

46.8.1.сэргээн засварлах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон албан бичиг, иргэний хувьд өргөдөл;

46.8.2.сэргээн засварлах ажлын төлөвлөгөө;

46.8.3.түүхэн дурсгалт барилга архитектурын дурсгалын хувьд баталгаажсан зураг төсөл;

46.8.4.дотоод, гадаадын байгууллага, хувь хүнтэй хамтран хэрэгжүүлэх бол хамтын ажиллагааны гэрээ;

46.8.5.сэргээн засварлах ажил гүйцэтгэх мэргэжилтний дэлгэрэнгүй танилцуулга.

46.9.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 10 өдөрт багтаан хүсэлтийг энэ хуулийн 14.1.12-т заасан соёлын биет өвийг сэргээн засварлах Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дүгнэлт гаргуулна.

46.10.Мэргэжлийн байгууллага, иргэн зөвшөөрөлд заасан хугацаанд сэргээн засварлах ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэж, тайланг тухайн жилд багтаан соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

46.11.Мэргэжлийн байгууллага, иргэн гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас зөвшөөрөлд заасан хугацаанд сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх боломжгүй болсон бол энэ тухайн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдэгдэж, зөвшөөрлийн хугацааг сунгуулж болно.

46.12.Мэргэжлийн байгууллага, иргэн энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон бол соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгосон зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.”

4/51 дүгээр зүйлийн 51.3, 51.4, 51.5, 51.6 дахь хэсэг:

“51.3.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг зөөж тээвэрлэх зөвшөөрлийг тухайн дурсгалт зүйлийг эзэмшигч хуулийн этгээдэд олгоно.

51.4.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг зөөж тээвэрлэх зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээдэд олгоно.

51.5.Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх зөвшөөрлийг хувь хүн болон энэ хуулийн 51.3, 51.4-т зааснаас бусад хуулийн этгээдэд олгохгүй.

51.6.Энэ хуулийн 51.1-д заасан зөвшөөрөл эзэмшигч соёлын биет өвийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, зөөж тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.”

5/52 дугаар зүйлийн 52.10, 52.11, 52.12, 52.13, 52.14, 52.15, 52.16, 52.17 дахь хэсэг:

“52.10.Улсын хилээр нэвтрүүлэх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл нь дараах шаардлагыг хангасан байна:

- 52.10.1.гэмт хэрэг зөрчлийн нотлох баримтад тооцогдоогүй байх;
- 52.10.2.даатгуулсан байх;
- 52:10.3.өмчлөлийн маргаангүй байх.

52.11.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага доор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хүсэлт гаргана:

52.11.1.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зорилго, ач холбогдол, хугацаа, тээвэрлэлт болон хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдлыг хангах асуудлыг тусгасан танилцуулга;

52.11.2.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн талаарх лавлагаа;

52.11.3.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн нэр, тодорхойлолт, тоо ширхэг, хэмжээ, жин зэрэг шаардлагатай мэдээллийг багтаасан жагсаалт;

52.11.4.өмчлөгч өөрөө язгуур зориулалтаар нь ашиглахаас бусад тохиолдолд дурсгалт зүйлийг сэргээн засварлах, үзэсгэлэнд оролцуулах, судалгааны дээжийг судалж шинжлүүлэх талаар гадаадын байгууллагатай байгуулсан хүчин төгөлдөр гэрээний хуулбар;

52.11.5.хосгүй үнэт дурсгалт зүйлийн 10х15 хэмжээтэй 2 хувь өнгөт гэрэл зураг;

52.11.6.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг даатгуулсан баримт.

52.12.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бусдын өмчлөлийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх бол хууль ёсны өмчлөгчтэй харилцан тохиролцож гэрээ байгуулсан байна.

52.13.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх хүсэлтийг Зөвшөөрлийн

тухай хуульд заасны дагуу магадлан шалгаж, ажлын 10 өдөрт багтаан Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулна.

52.14.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 52.13-т заасан магадлан шалгах ажиллагаа дууссанаас хойш ажлын хоёр өдөрт багтаан саналыг Засгийн газарт хүргүүлнэ. Засгийн газар ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, зөвшөөрөл олгох эсэх асуудлаар шийдвэр гаргана.

52.15.Зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэгтэй:

54.15.1.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн аюулгүй байдлыг найдвартай хангах арга хэмжээ авах;

52.15.2.түүх, соёлын хөдлөх дурсгал зүйлийг зөвшөөрөлд заасан нөхцөлөөр ашиглах;

52.15.3.зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй байх;

52.15.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг зориулалтын дагуу ашиглах;

52.15.5.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг заавал даатгуулсан байх;

52.15.6.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлсний дараа үрэгдсэн, хулгайлагдсан, эвдэрч гэмтсэн тохиолдолд нэн даруй соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх;

52.15.7.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд улсын хилээр буцаан авч ирэх;

52.15.8.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр буцаан авч ирснээс хойш 5 хоногт багтаан тайланг бэлтгэж, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

52.16.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр гадаад улсад гаргасны дараа зөвшөөрөл авсан иргэн нас барсан, эрх зүйн чадамжаа алдсан, эсхүл Монгол Улсын харьяатаас гарсан, аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан тохиолдолд зөвшөөрөл эзэмших эрхийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шилжүүлэн авч, хосгүй үнэт дурсгалт зүйлийг буцаан авч ирэх ажлыг зохион байгуулна. Ийнхүү шилжсэн нь хосгүй үнэт дурсгалт зүйлийн өмчлөх эрхэд хамаарахгүй.

52.17.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл нь нэг удаагийн зөвшөөрөл байна.

6/53 дугаар зүйлийн 53.4, 53.5 дахь хэсэг:

“53.4.Нийтийн өмчийн соёлын биет өвийг эзэмшигч энэ хуулийн 53.1-д заасан зөвшөөрлийг зөвхөн нэг удаа ашиглана.

53.5.Соёлын биет өвийг 1:1 масштабаар хувиалан олшруулсан эхийг давтан олшруулахгүй.”

2 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.12 дахь заалтын “мэргэжлийн” гэсний өмнө “соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах палеонтологийн, археологийн, соёлын биет бус өвийн, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн, соёлын биет өвийг сэргээн засварлах” гэж, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “судалгаа” гэсний дараа “болон соёлын биет бус өвийн судалгаа” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 13.1.10 дахь заалт:

“13.1.10.соёлын биет өвийг хувилан олшруулах, гэрэл зураг, дүрс бичлэг хийх журам батлах;”

2/27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг:

“27.3.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх болон соёлын биет бус өвийн судалгаа хийх зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 27¹.1-д заасан санал, дүгнэлтэд үндэслэн олгоно.”

3/38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг:

“38.2.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээдийн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.6, 6.7-д заасан судалгааг урьдчилан гүйцэтгэсэн ажлын дүгнэлтээр соёлын өвд эрсдэл учирч болзошгүй байгаа нь тогтоогдсон бол аж ахуйн үл ажиллагааг зогсоох үндэслэл болно.”

4/46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг:

“46.3.Соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 46.9-д заасан дүгнэлтэд үндэслэн олгоно.”

5/51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг:

“51.1.Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

6/52 дугаар зүйлийн 52.1, 52.3, 52.4 дэх хэсэг:

“52.1.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг судлах, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор хадгалалт хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр улсын хилээр нэвтрүүлнэ.

52.3.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. Энэ хэсгийн заалт палеонтологи, археологийн судалгааны дээжийг улсын хилээр нэвтрүүлэхэд нэгэн адил хамаарна.

52.4.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг Засгийн газар олгоно.”

7/53 дугаар зүйлийн 53.1, 53.2 дахь хэсэг:

“53.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг 1:1 болон бусад масштабаар хувиран олшруулах зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

53.2.Хувийн өмчийн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг 1:1 масштабаар хувиран олшруулах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй заавал зөвшилцөнө.”

4 дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсгийн “зөвшөөрлөөр” гэснийг “шийдвэрээр” гэж, 38 дугаар зүйлийн 38.1.3 дахь заалтын “зөвшөөрөлгүйгээр” гэснийг “шийдвэргүйгээр” гэж, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсгийн “тогтооно” гэснийг “батална” гэж, 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсгийн “52.3” гэснийг “52.3, 52.4” гэж, 52.7 дахь хэсгийн “52.1, 52.3” гэснийг “52.3, 52.4” гэж, 53 дугаар зүйлийн гарчгийн “Соёлын өвийг хувилах” гэснийг “Соёлын биет өвийг хувиран олшруулах” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр” гэснийг, 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн “соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр” гэснийг, 59 дүгээр зүйлийн 59.1.4 дэх заалтын “зөвшөөрөлгүйгээр” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.11 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.3.1, 52.3.2, 52.3.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“38.1.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.10-т заасан зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.

38.4.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Соёлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.5, 9.6 дахь хэсэг:

“9.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 1.3, 1.5, 1.12, 1.13, 1.15, 1.16, 1.17, 1.18, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 3 дахь хэсгийн 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.11, 3.12, 3.13, 3.14, 3.15, 3.16, 3.17, 3.18, 3.19, 3.20, 3.21, 3.22 дахь заалт, 5 дахь хэсгийн 5.1 дэх заалт, 6 дахь хэсгийн 6.4, 6.5 дахь заалт, 7 дахь хэсгийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6, 7.7, 7.8 дахь заалт, 8 дахь хэсгийн 8.1, 8.4, 8.5, 8.6, 8.11, 8.17 дахь заалт, 9 дэх хэсгийн 9.1, 9.2, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.11, 9.12, 9.13, 9.14, 9.15 дахь заалт, 10 дахь хэсгийн 10.1 дэх заалт, 11 дэх хэсгийн 11.7 дахь заалт, 13 дахь хэсгийн 13.1, 13.2, 13.3, 13.4, 13.5, 13.6, 13.7, 13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12, 13.13, 13.14, 13.15, 13.16, 13.17, 13.18, 13.19, 13.20, 13.21 дэх заалт, 14 дэх хэсгийн 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.7, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13, 14.15, 14.16, 14.17, 14.18, 14.19, 14.20, 14.21, 14.22 дахь заалтад заасан тусгай зөвшөөрөл болон 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.9, 1.11 дэх заалт, 5 дахь хэсгийн 5.3 дахь заалт, 7 дахь хэсгийн 7.1 дэх заалт, 8 дахь хэсгийн 8.1 дэх заалт, 12 дугаар хэсгийн 12.1 дэх заалтад заасан энгийн зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаанд холбогдох стандартыг мөрдөнө.

9.6.Зөвшөөрөл эзэмшигч нь энэ зүйлийн 9.5-д заасан стандартыг заавал мөрдөх үүрэгтэй бөгөөд зөрчсөн тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүйд тооцох үндэслэл болно.”

2/12 дугаар зүйлийн 12.6, 12.7 дахь хэсэг:

“12.6.Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь стандартын шаардлага хангасныг энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан байгууллага, хуульд заасан эрх бүхий байгууллага тогтооно.

12.7.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд тодорхой төрлийн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг баталгаажуулалтын байгууллагаас олгосон тохирлын гэрчилгээг үндэслэн хялбаршуулсан журмаар явуулж болно. Энэ үйл ажиллагаанд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар батална.”

3/15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэг:

“15.8.Тохирлын үнэлгээний үр дүнгээр тохирлын гэрчилгээг хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээдэд болон стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ. Мэдэгдлийг үндэслэн зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд тухайн зөвшөөрлийг хүчингүй болгоно.”

2 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.2."стандарт" гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг тогтоосон сонгон хэрэглэх, эсхүл хуульд заасны дагуу заавал дагаж мөрдөх баримт бичгийг;”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Тамхины хяналтын тухай хуульд доор дурдсан агуулгатай 7¹, 7² дугаар зүйл тус тус нэмсүгэй:

1/7¹ дүгээр зүйл:

“7¹ дүгээр зүйл. Тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам

7¹.1. Тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох төсөл сонгон шалгаруулах зарыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл болон цахим хуудсаараа дамжуулан нийтэд зарлах ба төсөл хүлээн авах хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.

7¹.2. Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлтээ Тамхины хяналт тогтоох тухай суурь конвенц, стандартад заасан болон доор дурдсан баримт бичгийн хамт хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ:

7¹.2.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

7¹.2.2. татварын өргүй болохыг нотлох баримт;

7¹.2.3. татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлд заасан цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байхыг нотлох баримт;

7¹.2.4. аймаг, нийслэлийн Засаг даргын санал;

7¹.2.5. байгаль орчны нарийвчилсан үнэлгээ.”

7¹.3. Сонгон шалгаруулалтад оролцох тусгай зөвшөөрөл хүсэгчээс ирүүлсэн баримт бичигт үнэлгээ өгөх ажлын хэсгийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилно.

7¹.4. Энэ хуулийн 7¹.3-т заасан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрүүл мэнд, хууль, хүнсний салбарын эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн байгууллагын төлөөллийг оролцуулна.

7¹.5. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналыг Тамхины хяналт тогтоох тухай суурь конвенц, холбогдох стандартын шаардлагын дагуу дараах үзүүлэлт, оноогоор үнэлнэ:

7¹.5.1.тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх төслийн техник, эдийн засгийн үнэлгээ 0-15 хүртэл оноо;

7¹.5.2.үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, үүнээс нэвтрүүлэхээр төлөвлөсөн дэвшилтэт техник 0-10 хүртэл оноо;

7¹.5.3.үйлдвэрлэлийн технологи, үүнээс нэвтрүүлэхээр төлөвлөсөн дэвшилтэт технологи 0-15 хүртэл оноо;

7¹.5.4.эрүүл ахуйн нөхцөл 0-5 хүртэл оноо;

7¹.5.5.мэргэжлийн боловсон хүчний байдал 0-4 хүртэл оноо;

7¹.5.6.лаборатори болон технологийн хянал 0-10 хүртэл оноо;

7¹.5.7.хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах нөхцөл 0-8 хүртэл оноо;

7¹.5.8.галын аюулгүй байдлыг хангах нөхцөл 0-4 хүртэл оноо;

7¹.5.9.үйлдвэрлэлийн зураг төслийн иж бүрдэл 0-9 хүртэл оноо;

7¹.5.10.хайрцаг, сав, баглаа боодлын загвар (стандартын шаардлага, эрүүл ахуйн анхааруулгыг оруулна) 0-6 хүртэл оноо;

7¹.5.11.баримт бичгийн бүрдэлт (өргөдөл, Засаг даргын санал, улсын бүртгэлийн гэрчилгээний, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ) 0-14 хүртэл оноо.

7¹.6.Сонгон шалгаруулах төсөл бүрийн үзүүлэлтийг ажлын хэсгийн гишүүн бүр үнэлж, оноог гишүүдийн дундаж үнэлгээгээр гаргана.

7¹.7.Ажлын хэсэг нь шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй.

7¹.8.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад оролцсон төсөл бүрийг ажлын 5 өдөрт, холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд ажлын 8 өдөрт багтаан шалгаж, дүгнэлт гарган хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.”

2/7² дугаар зүйл:

“7² дугаар зүйл.Тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох журам

7².1.Тамхи импортлох тусгай зөвшөөрлийг ашгийн төлөө хуулийн этгээдэд олгоно.

7².2.Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь дараах баримт бичгийг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

7².2.1.тусгай зөвшөөрлийн хүсэлт;

7².2.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

7².2.3.татварын албаны санал, тодорхойлолт;

7².2.4.тохирлын гэрчилгээний хуулбар;

7².2.5.тамхи худалдан авах гэрээ;

7².2.6.импортлох тамхийг үйлдвэрлэсэн болон экспортолсон улс орны чанар, стандартын шаардлага хангаж байгааг тодорхойлсон гэрчилгээ, баримт бичиг;

7².2.7.импортолсон бүтээгдэхүүнээ хадгалах агуулахын талаарх мэдээлэл;

7².2.8.импортын тамхи хадгалах барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын санал;

7².2.9.аймаг, нийслэлийн Засаг даргын санал;

7².2.10.энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан импортлох тамхины төрөл тус бүрийн эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаарх дүгнэлт;

7².2.11.импортлох тамхины дээжийг гаалийн байгууллагын урьдчилсан шинжилгээнд хамруулж, эрүүл ахуйн шаардлага хангасан талаарх баримт.

2 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7 дугаар зүйл.Тусгай болон энгийн зөвшөөрөл

7.1.Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүнс, хөдөө аж ахуйн, тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Засгийн газар олгож, хүчингүй болгоно.

7.2.Засгийн газар тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох эрхээ хүнс, хөдөө аж ахуйн болон үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд шилжүүлж болно.

7.3.Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хоёр жил, тамхи импортлох тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгана.

7.4.Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих тусгай зөвшөөрлийг хоёр жил, тамхи импортлох тусгай зөвшөөрлийг гурван жилээс дээш хугацаагаар сунгахгүй.

7.5.Тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 7¹ дүгээр зүйлд заасны дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.

7.6.Хүнс, хөдөө аж ахуйн болон үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох тухай хүсэлтийг хүлээн авч Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд багтаан магадлан шалгаж, Засгийн газарт хүргүүлнэ.

7.7.Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хяналт тавих чиг үүргийг хүнс, хөдөө аж ахуйн, тамхи импортлох тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хяналт тавих чиг

үүргийг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус хэрэгжүүлнэ.

7.8.Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад энэ хуулийн 7¹.2.1-7¹.2.5-д заасан баримт бичгийг, тамхи импортлох тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад энэ хуулийн 7² дугаар зүйлийн 7².2 дахь хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлж холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.9.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.

7.10.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

7.10.1.тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг /оноосон нэр, байрлах хаяг, харилцах утсыг тодорхой дурдах/;

7.10.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

7.10.3.хяналтын эрх бүхий байгууллагаас тухайн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагааг эрхлэх талаар гаргасан улсын байцаагчийн болон ажлын байрны дүгнэлт;

7.10.4.худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлагыг дүгнэсэн стандартын хуудасны хуулбар;

7.10.5.тухайн үйл ажиллагааг эрхлэх байранд хийгдсэн онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын галын дүгнэлт.

7.11.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгуулахад доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

7.11.1.тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай өргөдөл;

7.11.2.цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

7.11.3.тухайн баг, хорооны Засаг даргын санал;

7.11.4.хяналтын улсын байцаагчийн дүгнэлт.

7.12.Тамхи үйлдвэрлэх, импортлох, худалдах, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.12 дахь хэсэг нэмсүгэй:

“16.12.Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгох шийдвэрийг Засгийн газар, тус зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх шийдвэрийг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-т заасны дагуу төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.”

2 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“16.8.Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох, сунгах өргөдлийг хүлээн авч магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлж, шийдвэр гаргуулахаар ажлын 2 өдөрт багтаан Засгийн газарт хүргүүлнэ. Засгийн газар зөвшөөрөл олгох, сунгах саналыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэрийг гаргана.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2¹ дүгээр зүйл:

“2¹ дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1.“тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө” гэж тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалт, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд болон ойрын хугацааны төлөвлөгөө бүхий баримт бичгийг;

2.“тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүсчлэл” гэж дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын байгалийн хэв шинжийг төлөөлөх онцлог, ховор, нэн ховор амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйлүүдийн байршлыг харгалзан тогтоосон өөр өөр хамгаалалтын дэглэм бүхий газар нутгийн хуваарийг.”

2/6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5, 6, 7, 8, 9 дэх заалт:

“5/Засгийн газрын тусгай санд төвлөрүүлсэн тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн нөөц ашиглах, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж болон тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил, үйлчилгээний нэг удаагийн төлбөр орлого;

6/тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн нөөц ашигласны төлбөр;

7/тусгай хамгаалалттай газар нутгийн бэлчээр ашигласны төлбөр;

8/тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн орлого;

9/тусгай хамгаалалттай газар нутагт байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр.”

3/6¹ дугаар зүйл:

“6¹ дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент

1.Тусгай хамгаалалттай газар нутаг нь тусгай хамгаалалттай газрын менежментийн зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилт, үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон менежментийн төлөвлөгөөтэй байна. Менежментийн төлөвлөгөөг 10 жилийн хугацаатайгаар тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.Тусгай хамгаалалттай газар нутагт ашиглаж болох газар нутгийн хэсгийг тодорхойлж төлөвлөсөн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны саналыг авсны үндсэн дээр батална.

3.Энэ зүйлийн 2-т заасан газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлагдсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

4.Тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр ашиг, үр нөлөөг үнэлэх журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд уг журмын дагуу менежментийн төлөвлөгөөг 2 жил тутам үнэлж, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулна.

5.Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг менежментийн төлөвлөгөөтэй байж болох бөгөөд төлөвлөгөөг тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.”

4/27 дугаар зүйлийн 12, 13, 14, 15, 16, 17, 18 дахь заалт:

“12/Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.18-д зааснаар тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрлийг мөн хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулалтаар олгох;

13/Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6-д заасан тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах зөвшөөрөл олгох;

14/газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах журмыг батлах;

15/улсын тусгай хамгаалалттай газрын дотоод бүсчлэл тогтоох;

16/улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

17/тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах аргачлал, үр ашигт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах;

18/энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5, 7, 8-д заасан төлбөр, хураамжийн хэмжээг тогтоох.”

5/28 дугаар зүйлийн 4 дэх заалт:

“4/орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг батлах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг орон нутгийн төсөвт тусгах.”

6/29 дүгээр зүйлийн 4, 5 дахь заалт:

“4/байгалийн нөөц газар, дурсгалт газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг эрхлэх;

5/орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах.”

7/30 дугаар зүйлийн 11 дэх заалт:

“11/тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтийг хангах.”

8/35 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Энэ зүйлийн 2-т заасны дагуу ирүүлсэн саналд тухайн газар ашиглах зөвшөөрөл авах сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжээгүй тохиолдолд тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн этгээдийг сонгон шалгаруулалтад оруулахаас татгалзаж болно.”

9/36¹, 36² дугаар зүйл:

“36¹ дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалт

1.Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтыг өөрийн санаачилгаар явуулах бол тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд үндэслэн олон нийтэд нээлттэй явуулна.

2.Тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газрыг ашиглах хүсэлтийг 2 ба түүнээс дээш этгээд ирүүлсэн тохиолдолд тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн этгээдийн ирүүлсэн төслийг харьцуулан үнэлж газар ашиглах зөвшөөрөл олгож болно.

3.Сонгон шалгаруулалтад оролцож байгаа хүн, хуулийн этгээдийн тухайн тусгай хамгаалалттай газарт хэрэгжүүлэх төслийг үнэлсний үндсэн дээр хамгийн сайн үнэлэгдсэн төсөл ирүүлсэн хүн, хуулийн этгээдэд энэ хуульд заасны дагуу тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олгоно.

4.Сонгон шалгаруулалтад оролцогчид болон ирүүлэх төсөлд тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлсон журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

36² дугаар зүйл.Сонгон шалгаруулах үйл ажиллагааны дараалал

1.Сонгон шалгаруулалтыг дараах дарааллын дагуу явуулна:

1/төсөл сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлэх;

2/төслийг хүлээн авах;

3/сонгон шалгаруулалтад оролцогч этгээдийн талаар энэ хуулийн 35 дугаар зүйлийн 2-т заасан саналыг авах;

- 4/төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;
- 5/шалгарсан этгээдэд газар ашиглах зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах

2. Сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлэх:

1/төсөл сонгон шалгаруулалтын зар (цаашид “зар” гэх)-ыг уг ажиллагааг явуулахаар төвлөсөн өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө цахимаар болон өдөр тутмын хэвлэлээр нийтэд мэдээлнэ;

2/сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлэх зард төслийг хүлээн авах газрын хаяг, харилцах утасны дугаар, төслийг ирүүлэх сүүлийн хугацаа, газар ашиглалтын зориулалт, газрын талбайн хэмжээ, газар ашиглуулах хугацаа, газрын байршил, хилийн заагийг харуулсан зургийг заавал тусгана;

3/тухайн газрын онцлог, шинж чанараас шалтгаалан нэмэлт шаардлага тавьж болох бөгөөд түүнийг төсөл сонгон шалгаруулалтын зард заавал тусгана.

3. Төслийг хүлээн авах:

1/оролцогч нь битүүмжилсэн төслөө тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өөрөө буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр биечлэн хүргүүлэх, хэрэв ийнхүү хүргүүлэх боломжгүй бол зар мэдээнд заасан хугацаанд шуудангаар хүргүүлж болно;

2/тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийг зард заасан хугацаанд хүлээн авч бүртгэнэ:

3/төслүүдийг ирүүлсэн дарааллын дагуу он, сар, өдөр, цаг, минутаар нь тэмдэглэн бүртгэж, тусгай тэмдэглэл үйлдэн архивын нэгж үүсгэн хадгална;

4/зард заасан хугацаа дууссаны дараа ирүүлсэн төслүүдэд хоцорсон тухай тусгай тэмдэглэл үйлдэн, хүлээн авахаас татгалзаж буцаана.

5/төсөл сонгон шалгаруулалтад оролцогч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамжийг урьдчлан төлнө.

6/төслийг тусгай программ хангамж бүхий цахим хуудсаар хүлээн авч болно.

4. Сонгон шалгаруулалтад оролцогчийн төслийг дараах шалгуур үзүүлэлт нэг бүрээр үнэлнэ:

1/газар ашиглалтын зориулалт нь хууль болон газар зохион байгууллалтын төлөвлөгөөнд нийцсэн эсэх;

2/тухайн хэрэгжүүлэх төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл;

3/төсөл хэрэгжүүлэгч ашиглахаар хүсэлт гаргасан газарт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээний төлөвлөлт, түүнд зарцуулах зардлын тооцоолол.”

10/40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

“3/тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх хүчингүй болсон.”

11/40 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

“3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол тухайн хамгаалалтын захиргаа газрыг албадан чөлөөлөх шийдвэр гарган, харьяалах төрийн байгууллагатай хамтран газрыг албадан чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулан зардлыг буруутай иргэн, хуулийн этгээдээр нөхөн төлүүлнэ.

4.Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх дараах тохиолдолд хүчингүй болно:

1/Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-40.1.7-д заасан үндэслэлээр;

2/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тэмдэгтийн хураамж төлөөгүй.”

2 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Соёлын өвийг хамгаалах тухай хууль,” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хууль,” гэж, 12 дугаар зүйлийн 1 дэх заалтын “олборлох,” гэсний дараа “геологийн судалгаа хийх, металл хайгч, химийн хорт болон тэсрэх бодис авч явах, ашиглах,” гэж, 37 дугаар зүйлийн 2 дахь заалтын “үүрэг” гэсний дараа “, төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх хугацаа” гэж, 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “хамгаалалтын” гэсний дараа “дэглэм” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр энэ хуулийн 27 дугаар зүйлийн 12-т заасан зөвшөөрлийн үндсэн дээр гэрээгээр ашиглуулж болно.”

2/34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан газар ашиглах зөвшөөрөл гэрээний хугацаа 5 жилээс доошгүй байх бөгөөд уг хугацааг нэг удаа сунгах хугацаа 5 жилээс доошгүй байна. Газар ашиглах зөвшөөрөл, гэрээний хугацааг тогтоохдоо тухайн газар дээр хэрэгжих төслийн хугацааг харгалзан үзэж болно.”

3/35 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

“1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан журмыг баримтлан газар ашиглах зөвшөөрөл авах, сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлтээ тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

2.Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газар ашиглах зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад

оролцох тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт болон түүний талаарх саналыг энэ хуулийн 36¹ зүйлийн 2-т заасан сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанаас, хамгаалалтын захиргаа байхгүй бол сум дүүргийн Засаг даргаас авна.”

4/36 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын хязгаарлалтын бүс болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг энэ хуулийн 27 дугаар зүйлийн 12-т заасан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн гаргана.”

5/37 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Энэ хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах тухай гэрээг төрийн захиргааны төв байгууллага хамгаалалтын захиргаатай хамтран байгуулснаар тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах тухай гэрчилгээг олгож, улсын бүртгэлд бүртгэнэ.”

4 дүгээр зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хамгаалалтын захиргаа буюу зохих шатны Засаг даргатай тохиролцон тогтооно” гэснийг “Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална” гэж, 11 дүгээр зүйлийн 7 дахь заалтын “зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах” гэснийг “зориулалттай орон байр барих, ашиглах” гэж, 40 дүгээр зүйлийн гарчгийн “эрх дуусгавар болох,” гэснийг “зөвшөөрлийн эрх дуусгавар болох, хүчингүй болох,” гэж, 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллагаас” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6-д заасан” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “уламжлалт” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 3 дахь заалтыг, 30 дугаар зүйлийн 10 дахь заалтыг, 36 дугаар зүйлийн 2, 3, 5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “авмагц” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээг авсны дараа” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.2.Төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан энэ хуулийн 14.1.4-т заасан магадлан шалгах ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр холбогдох дүгнэлтийг цахимаар хүргүүлнэ.”

3 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “мэдэгдлийг” гэснийг “дүгнэлтийг” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “түдгэлзүүлэх” гэсний дараа “сэргээх” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “түдгэлзүүлэх” гэсний дараа “сэргээх” гэж, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “тодорхойлохдоо” гэсний дараа “шинжээчийн” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцож байгаа хуулийн этгээд нь үйл ажиллагааны эрсдэл, иргэний амь нас, эрүүл мэндийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу заавал даатгуулсан байна.”

3 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “4.1.9.” гэснийг “4.1.8.” гэж, “4.1.10.” гэснийг “4.1.9.” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран тооцоогоор тогтоох” гэснийг “сард нэг удаа тогтоох” гэж, 6.1.2 дахь заалтын “Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтын “мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын” гэснийг “шинжээчийн” гэж, 11.4 дэх хэсгийн “мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллага,” гэснийг “шинжээчийн болон” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын төв байгууллагын зөвшөөрөлтэйгөөр худалдаж” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдсэнээр шилжүүлж” гэж, мөн зүйлийн “13.4” гэснийг “13.2” гэж, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын төв” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, мөн зүйлийн 14.8 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж, “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад” гэснийг “энэ хуулийн 5.1.6-д заасан журмын дагуу мэдээллийн нэгдсэн санд” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын” гэснийг “шинжээчийн” гэж, “мэргэжлийн хяналтын төв байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх зүйлийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 23.3 дахь

хэсгийн “Мэргэжлийн хяналтын төв байгууллага” гэснийг “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “болон эрсдэлийн” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “Тайланд тэсэлгээний ажлын тохиолдол бүрийг тусгана.” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын төв байгууллага,” гэснийг, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтын “болон мэргэжлийн хяналтын” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.5, 15.6 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.4.2 дахь заалт, 17.6 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.7, 23.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын нисэхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.4.Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал нь хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх зөвшөөрлийг улсын болон иргэний нисэхийн байгууллагын агаарын хөлөгт олгоно. Зөвшөөрөл хүсэгчийн өргөдлийг үндэслэн ажлын нэг өдрийн дотор олгоно.

14.5.Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал нь энэ зүйлийн 14.4-д заасан зөвшөөрөл олгосон шийдвэр гарсан даруй иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэж, шийдвэрийн хуулбарыг хил хамгаалах байгууллагад хүргүүлнэ.”

2 дугаар зүйл. Улсын нисэхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, 14.6 дахь хэсгийн дугаарлалтыг “14.6., 14.7.” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/21 дүгээр зүйлийн 21.1.38-21.1.47 дахь заалт:

“21.1.38.химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000-10 000 000 төгрөг;

21.1.39.байгаль орчны аудит хийх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

21.1.40.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 10 000-100 000 төгрөг;

21.1.41.цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 120 000-500 000 төгрөг;

21.1.42.ан амьтны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг, сунгахад 250 000 төгрөг;

21.1.43.нэн ховор амьтныг эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнах, барих зөвшөөрлийн хураамжийг тухайн ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар;

21.1.44.харь ургамлыг байгальд тарималжуулах зөвшөөрөл олгоход 150 000 төгрөг;

21.1.45.гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны сан бүхий газарт ус, усан орчинтой холбоотой шинжилгээ судалгаа явуулах зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг;

21.1.46.тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

21.1.47.байгалийн ойгоос зулзаган модыг шилжүүлэн суулгахад 20 000 төгрөг.”

2/22 дугаар зүйлийн 22.1.10, 22.1.11, 22.1.12 дахь заалт:

“22.1.10.гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургууль байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 1 500 000 төгрөг;

22.1.11.олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 2 500 000 төгрөг;

22.1.12.их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль байгуулах энгийн зөвшөөрөл олгоход 3 000 000 төгрөг.”

3/23 дугаар зүйлийн 23.1.10, 23.1.11, 23.2.5, 23.2.6 дахь заалт:

“23.1.10.эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;

23.1.11.хийгээр хангах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход зөвшөөрөл тус бүрд 1 000 000 төгрөг.

23.2.5.4.0 МПа-аас доош даралтад ажилладаг тоноглолын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.2.6.4.0 МПа-аас дээш даралтад ажилладаг тоноглолын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг.”

4/26 дугаар зүйлийн 26.3.3 дахь заалт, 26.4 дэх хэсэг:

“26.3.3.мал, амьтны тэжээлийн нэмэлт, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох зөвшөөрөл олгоход 6 000-12 500 төгрөг.

26.4.энэ хуулийн 26.2-т зааснаас бусад малыг гадаадад гаргах зөвшөөрөл олгоход малын тоо толгой тутмаас доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 26.4.1.адуу 48 000-120 000 төгрөг;
- 26.4.2.үхэр 32 000-80 000 төгрөг;
- 26.4.3.хонь 19 200-48 000 төгрөг;
- 26.4.4.ямаа 19 200-48 000 төгрөг;
- 26.4.5.тэмээ 96 000-240 000 төгрөг.”

5/27 дугаар зүйлийн 27.5, 27.6 дахь хэсэг:

“27.5.хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 44 000-110 000 төгрөг;

27.6.эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа хийх зөвшөөрөл олгоход 40 000 төгрөг.”

6/28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалт:

“28.1.10.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг.”

7/35 дугаар зүйлийн 35.1.23 дахь заалт:

“35.1.23.хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч хуулийн этгээдэд ус ашиглах зөвшөөрөл олгоход 100 шоометр хүртэлх ус ашиглах зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг, 100, түүнээс дээш шоометр ус ашиглах зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг.”

8/42 дүгээр зүйлийн 42.6 дахь хэсэг:

“42.6.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 болон 8.2-т заасан зөвшөөрөлд хамаарах улсын тэмдэгтийн хураамжийг зөвшөөрөл олгох болон сунгах тухай шийдвэр гарсныг мэдэгдсэнээс хойш ажлын 3 өдөрт багтаан төлнө.”

2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.11, 21.1.17, 21.1.18, 21.1.20, 21.1.30, 22¹ дүгээр зүйлийн 22¹.1.5 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 23.1.9, 25 дугаар зүйлийн 25.1.7-25.1.9, 25.1.12, 29 дүгээр зүйлийн 29.1.7, 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.16 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “зөвшөөрөл” гэсний өмнө “тусгай” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтын “үйлдвэрлэх” гэсний дараа “импортлох, экспортлох, ханган нийлүүлэх, мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах” гэж, 27.1.5 дахь заалтын “импортлох,” гэсний дараа “экспортлох,” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалтын “гүүр засварлах, арчлах” гэсний дараа “тусгай” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалтын “зөвшөөрлийг” гэсний өмнө “тусгай” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.1.11 дэх заалт:

“5.1.11.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйл болон 8.2 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;”

2/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

“6.2.Энэ хуулийн 11.2, 11.4, 11.5 дахь хэсэг, 12, 14-20 дугаар зүйл, 21.1.8-21.1.21, 21.1.23-21.1.30, 21.1.32-21.1.38, 21.1.40, 21.1.41, 21.1.43 дахь заалт, 22¹, 24 дүгээр зүйл, 25.1.2, 25.1.3, 25.1.7-25.1.9, 26.1.2, 26.1.6-26.1.9 дэх заалт, 26.2, 26.3, 26.4 дэх хэсэг, 27.1.1, 27.1.4-27.1.6 дахь заалт, 27.2-27.5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.8, 28.1.9 дэх заалт, 29 дүгээр зүйл, 32, 33 дугаар зүйлийн 33.1.3, 35 дугаар зүйлийн 35.1.1-35.1.3 дахь заалт, 37, 40 дүгээр зүйлд заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.”

3/21 дүгээр зүйлийн 21.1.9, 21.1.12, 21.1.16, 21.1.22, 21.1.24, 21.1.26, 21.1.27, 21.1.31, 21.1.34 дэх заалт:

“21.1.9.Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин боловсруулах, дахин цэнэглэх, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, засвар

үйлчилгээ хийх, устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

21.1.12.амьтан тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох, нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах тусгай зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг;

21.1.16.нэн ховор ургамал, тэдгээрийн түүхий эдийг судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглах, гадаад улсад гаргах зөвшөөрөл олгоход тухай үеийн жингийн килограмм тутамд газрын дээд хэсэг 30 000-50 000 төгрөг, газрын доод хэсэг 45 000-55 000 төгрөг;

21.1.22.усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг, сунгахад 500 000 төгрөг;

21.1.24.ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 60 000-300 000 төгрөг, сунгахад 60 000-150 000;

21.1.26.аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 8000-20 000 төгрөг;

21.1.27.олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын хавсралтад заасан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох, импортлох тусгай зөвшөөрөл олгоход 20 000-260 000 төгрөг;

21.1.31.ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих зөвшөөрлийн хураамжийг нэг удаагийн эрхийн бичигт 10000 төгрөг;

21.1.34.нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргахад тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 20-30 хувиар;”

4/22 дугаар зүйлийн 22.1.1, 22.1.3, 22.1.4, 22.1.5, 22.1.7 дахь заалт:

“22.1.1.их сургууль, дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг;

22.1.3.магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх энгийн зөвшөөрөл олгоход хөтөлбөр тус бүрээр магистр 2 000 000, доктор 3 000 000 төгрөг;

22.1.4.дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах энгийн зөвшөөрөл олгоход хөтөлбөр тус бүрээр 1 000 000 төгрөг;

22.1.5.төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 3 000 000 төгрөг;

22.1.7.гадаадын хуулийн этгээд Монгол Улсад боловсролын байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;”

5/23 дугаар зүйлийн 23.1.1-23.1.7 дахь заалт:

“23.1.1.0.1-5МВт-ын эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, ус болон түлшээр ажилладаг/ барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.1.2.0.1-100МВт-ын эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, ус болон түлшээр ажилладаг/ барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;

23.1.3.100МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, ус болон түлшээр ажилладаг/ барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 37 500 төгрөг;

23.1.4.0.4-15кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.1.5.0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.1.6.0.4-110кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;

23.1.7.220кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 37 500 төгрөг;”

6/23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3, 23.2.4 дэх заалт:

“23.2.1.0.7-1.6 МПа даралттай зуух, даралтат сав, дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.2.2.0.7-4.0 МПа даралттай зуух, даралтат сав, дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.2.3.0.7-8.0 МПа даралттай зуух, даралтат сав, дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;

23.2.4.8.0 МПа-аас дээш даралттай зуух, даралтат сав, дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;”

7/26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалт, 26.3 дахь хэсэг:

“26.1.2.согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгоход хатуулгаас нь шалтгаалан 20 000 000-200 000 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 10 000 000-100 000 000 төгрөг;

26.3.Малын үржүүлгийн бүтээгдэхүүн, тэжээлийн нэмэлт, эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:”

26.3.2.малын үржүүлгийн бусад бүтээгдэхүүн 5 000-50 000 төгрөг;”

8/28 дугаар зүйл:

“28 дугаар зүйл.Барилга, хот байгуулалтын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

28.1.Барилга, хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

28.1.1.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгоход:

Төвөгшлийн ангилал		Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
Бага төвөгшилтэй барилга байгууламж		500 000
Дунд төвөгшилтэй барилга байгууламж		750 000
Өндөр төвөгшилтэй барилга байгууламж		1 000 000
Онцгой төвөгшилтэй барилга байгууламж	Тухайлсан барилга байгууламж	1 250 000
	Тухайлснаас бусад	1 250 000

28.1.2.барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход:

Төвөгшлийн ангилал		Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/	Хураамжийн хэмжээ /сунгахад, төгрөгөөр/
Бага төвөгшилтэй барилга байгууламж		1 000 000	800 000
Дунд төвөгшилтэй барилга байгууламж		1 250 000	1 000 000
Өндөр төвөгшилтэй барилга байгууламж		1 500 000	1 200 000
Онцгой төвөгшилтэй барилга байгууламж	Тухайлсан барилга байгууламж	1 750 000	-
	Тухайлснаас бусад	1 750 000	1 400 000

28.1.3.барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход:

Үйлдвэрлэлийн хүчин чадлын ангилал	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/

Бага хүчин чадалтай үйлдвэрлэл	400 000
Дунд хүчин чадалтай үйлдвэрлэл	500 000
Өндөр хүчин чадалтай үйлдвэрлэл	600 000

28.1.4.өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход:

Төвөгшлийн ангилал	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
Бага төвөгшилтэй	50 000
Дунд төвөгшилтэй	150 000
Өндөр төвөгшилтэй	250 000
Онцгой төвөгшилтэй	350 000

28.1.5.барилгын ажлын зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг;

28.1.6.газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх шинээр олгоход 300 000 төгрөг, сунгахад 200 000 төгрөг;

28.1.7.газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх шинээр олгоход 300 000 төгрөг, сунгахад 200 000 төгрөг;

28.1.8.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход 200 000-500 000 төгрөг, сунгахад 300 000 төгрөг;

28.1.9.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах зөвшөөрөл олгоход 360 000-900 000 төгрөг.

9/30 дугаар зүйл:

“30 дугаар зүйл.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

30.1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох, сунгахад доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

30.1.1.тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад 5 000 000 төгрөг;

30.1.2.арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг;

30.1.3.мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг;

30.1.4.харилцаа холбооны үйлчилгээ эрхлэхэд 100 000 төгрөг;

30.1.5.олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 40 000 төгрөг, аймагт 20 000 төгрөг;

30.1.6.олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэхэд 80 000 төгрөг;

30.1.7.өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг;

30.1.8.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахад 25 000 төгрөг;

30.1.9.радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэхэд 80 000 төгрөг;

30.1.10.сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэхэд 200 000 төгрөг;

30.1.11.харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэхэд 200 000 төгрөг;

30.1.12.харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг;

30.1.13.дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг;

30.1.14.төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг;

30.1.15.улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг.

30.2.Бүртгэлийн гэрчилгээ олгоход 20 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.”

10/33 дугаар зүйлийн 33.1.2, 33.1.4 дэх заалт:

“33.1.2.барилга, байгууламжийг шинээр барих зураг төсөлд хяналт хийн дүгнэлт гаргахад:

№	Барилга байгууламжийн төвөгшил	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
1	Бага төвөгшилтэй барилга байгууламж	50 000
2	Дунд төвөгшилтэй барилга байгууламж	100 000
3	Өндөр төвөгшилтэй барилга байгууламж	150 000
4	Онцгой төвөгшилтэй барилга байгууламж	200 000

33.1.4.Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6.1.3 -д заасны дагуу барилга байгууламжийг барих, ашиглах явцад галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргахад 25000 төгрөг”

11/35 дугаар зүйлийн 35.1.18, 35.1.21 дэх заалт:

“35.1.18.ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 0-10 килограмм бол 1000-4000 төгрөг, 10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд 50-200 төгрөг нэмж;

35.1.21.малын удам гарвацийн болон эрүүл мэндийн гэрчилгээ, шилжилт хөдөлгөөний тодорхойлолт, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх итгэмжлэлийн гэрчилгээ, мал, үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ олгоход 2000-10000 төгрөг.”

4 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “арилжааны” гэснийг “ердийн, урт хугацааны, давхар” гэж, мөн зүйлийн 18.1.6 дахь заалтын “даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх

болон нэгтгэх хүсэлт гаргаж,” гэснийг “даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдэд шилжүүлэх болон бусад этгээдийн үйл ажиллагаатай нэгтгэх” гэж, мөн зүйлийн 18.1.7 дахь заалтын “даатгалын мэргэжлийн оролцогч” гэснийг “даатгагч” гэж, мөн зүйлийн 18.3.1 дэх заалтын “зээлийн” гэснийг “зээл олгох” гэж, мөн зүйлийн 18.3.2 дахь заалтын “үйл ажиллагаа” гэснийг “үйлчилгээ” гэж, мөн зүйлийн 18.3.7 дахь заалтын “үйлчилгээ, үйл ажиллагаа” гэснийг “арилжаа” гэж, мөн зүйлийн 18.3.8 дахь заалтын “үйлчилгээ, үйл ажиллагаа” гэснийг “үйлчилгээ” гэж, мөн зүйлийн 18.3.12 дахь заалтын “хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахад Санхүүгийн зохицуулах хорооны” гэснийг “өөрчлөн байгуулах, татан буулгах” гэж, мөн зүйлийн 18.3.14 дэх заалтын “төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагын” гэснийг “арилжааны тооцооны, төлбөрийн, төвлөрсөн хадгаламжийн, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх” гэж, мөн зүйлийн 18.3.15 дахь заалтын “үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага байгуулах” гэснийг “хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх” гэж, мөн зүйлийн 18.3.16 дахь заалтын “хөрөнгө оруулалтын сангийн зөвшөөрөл” гэснийг “итгэмжлэн удирдах, санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох, кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж, мөн зүйлийн 18.3.18 дахь заалтын “зөвлөхөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн” гэснийг “зөвлөхийн” гэж, мөн зүйлийн 18.3.20 дахь заалтын “компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах” гэснийг “нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах” гэж, мөн зүйлийн 21.1.21 дэх заалтын “эрх” гэснийг “тусгай зөвшөөрөл” гэж, 22¹ дүгээр зүйлийн 22¹.1.3 дахь заалтын “соёлын өвийг” гэснийг “түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.10.6 дэх дэд заалтын “газрын тосны бүтээгдэхүүний” гэснийг “бүх төрлийн шатахууны” гэж, 25.1.10.6.2 дахь заалтын “хийн түлшний худалдаа” гэснийг “шатдаг хийн түлшний худалдаа” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.9 дэх заалтын “малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, үржлийн сайжруулагч мал импортлох, экспортлох” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.7-12.10-т заасан үйл ажиллагаа эрхлэх” гэж, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийн “лиценз” гэснийг “зөвшөөрөл” гэж, мөн зүйлийн 26.3.1 дэх заалтын “гүн хөлдөөсөн үр, хөврөл үр” гэснийг “үр, хөврөл” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтын “эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.8-13.14, 13.20-д заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход” гэж, 33 дугаар зүйлийн гарчгийг “Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр дүгнэлт олгоход хураах тэмдэгтийн хураамж” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “30.2.2-30.2.6 дахь заалт, 30.3-30.5 дахь хэсэг” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.1.2-17.1.6, 17.1.8-17.1.12, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, 18.1.5, 18.3.4, 18.3.5, 18.3.9, 18.3.10, 19 дүгээр зүйлийн 19.1.1, 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.38, 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтын “тусгай” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.3.19 дэх заалтын “банкнаас бусад этгээд” гэснийг, мөн зүйлийн 18.3.23 дахь заалтын “хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор” гэснийг, 22¹ дүгээр зүйлийн 22¹.1.7 дахь заалтын “кино бүтээх зорилгоор” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 5.1.12, 5.1.13, 5.1.17-5.1.19, 5.1.20, 5.1.22, 5.1.23, 5.1.25, 5.1.28, 5.1.33, 5.1.36 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2-18.1.4, 18.3.3, 18.3.13 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.1-21.1.7, 21.1.10, 21.1.11, 21.1.14, 21.1.18, 21.1.19-21.1.21,

21.1.23, 21.1.25, 21.1.29 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.1.2, 22.1.6, 22.1.8, 22.1.9 дэх заалт, 22¹ дүгээр зүйлийн 22¹.1.1, 22¹.1.2, 22¹.1.4 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1.3-26.1.5 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг бүхэлд нь, 35 дугаар зүйлийн 35.1.14, 35.1.19, 35.1.20 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.4.15 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ургамал хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.4, 13.5 дахь хэсэг нэмсүгэй:

“13.4. Ургамал хамгаалахад ашиглах бодис импортлох, борлуулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь доор дурдсан бичиг баримт бичгийг бүрдүүлэн ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

13.4.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйл ажиллагааны төрлийг тодорхой дурдсан байх/;

13.4.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

13.4.3. татварын өргүй болохыг нотлох баримт;

13.4.4. татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлд заасан цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байхыг нотлох баримт;

13.4.5. ургамал хамгаалахад ашиглах химийн гаралтай бодисын хувьд Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний тайлан;

13.4.6. ургамал хамгаалахад ашиглах химийн гаралтай бодисын хувьд тухайн химийн бодисын сав, баглаа боодлыг устгах, дахин боловсруулах үйлдвэртэй байгуулсан гэрээ.

13.5. Ургамал хамгаалахад ашиглах бодис импортлох, борлуулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлэн ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

2 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын, 10 дугаар зүйлийн 10.1.6, 10.1.7 дахь заалтын, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтын “мэргэжлийн” гэснийг “эрдэм шинжилгээний” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “мэргэжлийн байгууллагад” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Ургамал хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/28¹ дугаар зүйл:

28¹ дугаар зүйл. Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт

“28¹.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.27, 1.28-т заасан тусгай зөвшөөрлийг мөн хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу дуудлага худалдаа, эсхүл сонгон шалгаруулалтын журмаар олгоно.

2/21 дүгээр зүйлийн 21.5, 21.6, 21.7, 21.8 дахь хэсэг:

“21.5. Усны мэргэжлийн байгууллага нь дараах үүргийг гүйцэтгэнэ:

21.5.1. усны хайгуул, судалгаа явуулах эрх бүхий мэргэжлийн байгууллага нь төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуул судалгаа хийх, газрын доорх усны регионал судалгаа, зураглал хийх, усны сав газрын нөөцийн судалгаа хийх, усны нөөцийн зөвлөлөөр судалгааны тайланг хэлэлцүүлж, нөөцийг баталгаажуулах, хайгуул судалгааны тайланг улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх;

21.5.2. усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах эрх бүхий мэргэжлийн байгууллага нь энэ хуулийн 3.1.13-т заасан усны барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, тайланг улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх;

21.5.3. цооног өрөмдөх, тоноглох, сэргээн засварлах эрх бүхий мэргэжлийн байгууллага нь унд ахуйн болон үйлдвэрлэлийн ус хангамж, усны нөөцийн эрэл, хайгуул, газрын доорх усны хяналт шинжилгээ, усны түвшин бууруулах, шүүрүүлэх, тэсэлгээ хийх болон бусад зориулалтаар ашиглах цооног өрөмдөх, тоноглох, худгийн барилга барих, сэргээн засварлах, мэдээ тайланг улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх;

21.5.4. усны барилга байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх эрх бүхий мэргэжлийн байгууллага нь энэ хуулийн 3.1.13-т заасан усны барилга, байгууламжийг барих, сэргээн засварлах, шинэчлэх, тайланг улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх;

2.5.5.усны аудит хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага усны нөөцийн ашиглалт, усны нөөцийн төлбөр төлөлт, усны барилга байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх ажлын гүйцэтгэлд аудит хийх, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргах, тайланг улсын усны мэдээллийн санд хүлээлгэж өгөх.

21.6.Усны мэргэжлийн байгууллагын эрхийг шинээр авах, сунгуулахад дараах материалыг бүрдүүлнэ:

21.6.1.аж ахуйн нэгж, байгууллагын танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээний лавлагаа;

21.6.2.тухайн чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн хүний нөөцийн жагсаалт, нотариатаар баталгаажуулсан диплом, сертификатын хуулбар, ажлын туршлага;

21.6.3.мэргэжлийн хүний нөөцийг ажилд томилсон тушаал, хөдөлмөрийн гэрээ нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

21.6.4.техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт, гэрчилгээ, түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар болон техникийн бусад үзүүлэлт, фото зураг;

21.6.5.зураг төслийн эрх авах бол программ хангамжийн танилцуулга;

21.6.6.усны мэргэжлийн байгууллагын эрхээ сунгуулах бол дээрх баримт бичгүүдээс гадна эрх авсанаас хойш хийсэн ажлын тайланг оноор гаргана.

21.7.Усны мэргэшсэн хүний нөөцийн сургалтыг сонгон шалгаруулалт явуулж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, гидрологи, гидрогеологич гидротехникч инженерд мэргэшсэн зэрэг олгоно.

21.8.усны мэргэжлийн байгууллага зөвшөөрөлгүйгээр цооног өрөмдөх, худаг гаргах, суваг шуудуу татах нь мэргэжлийн байгууллагын эрхийг цуцлах үндэслэл болно.”

2 дугаар зүйл.Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “үндэслэн” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.14-т заасан” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “цооног өрөмдөх,” гэсний дараа “сэргээн засварлах,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Усны тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:

“5.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.2-т зүйлд заасан зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.”

2/21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг:

“21.3.Усны мэргэжлийн байгууллагын эрхийг дараах чиглэлийн дагуу олгоно:

- 21.3.1.усны хайгуул, судалгаа явуулах;
- 21.3.2.усны барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах;
- 21.3.3.цооног өрөмдөх, тоноглох, сэргээн засварлах;
- 21.3.4.усны барилга, байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх;
- 21.3.5.усны аудит хийх.

4 дүгээр зүйл. Усны тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.4.10 дахь заалтын “төсөлд” гэснийг “төсөл, усны мэргэжлийн байгууллагын олгох, сунгах, цуцлах тухай” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.8, 11.9, 11.10 дахь хэсэг:

“11.8. Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг нэг удаа 15 жилээр сунгана.

11.9. Төрийн захиргааны төв байгууллага нь паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох болон сунгах саналыг Зөвшөөрлийн тухай хуульд заасан магадлах ажиллагаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор Засгийн газарт хүргүүлнэ.

11.10. Засгийн газар энэ хуулийн 11.8-д заасан асуудлыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэр гаргана.”

2/12 дугаар зүйлийн 12.5, 12.6 дахь хэсэг:

“12.5. Энэ хуулийн 12.3-т заасан нөхцөл үүссэн бол төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 2-т заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдөрт багтаан Засгийн газарт хүргүүлнэ.

12.6. Засгийн газар энэ хуулийн 12.5-д заасан асуудлыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэр гаргана.”

2 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “паркийн удирдлагатай” гэсний өмнө “паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу түдгэлзүүлэх, сэргээх шийдвэр гаргах,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.4 дэх хэсгийн “7.1.2” гэснийг “8.1.6” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “түдгэлзүүлэх, сэргээх,” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/
хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

“10.4.Энэ хуулийн 10.1.9-т заасан зөвшөөрлийг Банкны тухай хуулийн 6.1.3-т заасан зөвшөөрлийг авсан банканд олгосонд тооцно.”

2/11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь хэсэг:

“11.5.Энэ хуулийн 11.4-д заасан баримт бичгийг бүрдүүлэх хугацаа Монголбанкнаас зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид мэдэгдсэнээс хойш 60 хүртэл хоног байна.

11.6.Монголбанк зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2.2.1-2.2.3-д заасан арга хэмжээг авна.”

3/15 дугаар зүйлийн 15.5, 15.6, 15.7 дахь хэсэг:

“15.5.Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтээ энэ хуулийн 15.1-д заасан хугацаа дуусгавар болохоос 180 хоногийн өмнө энэ хууль болон Монголбанкнаас тогтоосон баримт бичгийн хамт Монголбанканд ирүүлнэ.

15.6.Зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлт гаргагч нь энэ хууль болон Монголбанкнаас тогтоосон шаардлагыг хангасан тохиолдолд Монголбанк уг зөвшөөрлийг хугацаагүй олгоно.

15.7.Монголбанк зөвшөөрөл авах, зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлт гаргагч нь энэ хууль болон Монголбанкнаас тогтоосон шаардлагыг хангаагүй тохиолдолд зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзаж, шийдвэрийг үндэслэлийн хамт ажлын гурван өдрийн дотор хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

4/19 дүгээр зүйлийн 19.4, 19.5, 19.6, 19.7 дахь хэсэг:

“19.4.Энэ хуулийн 19.1, 19.2-т заасны дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчийн төлбөр тооцооны болон клирингийн систем дэх гүйлгээнд оператор хязгаарлалт тогтоож болно.

19.5.Зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 19.1-д заасан зөрчлийг арилгасныг Монголбанкнаас тогтоосон тохиолдолд Монголбанкны шийдвэрээр зөвшөөрлийг сэргээнэ.

19.6.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн эсхүл хүчингүй болгосон тохиолдолд Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйл ажиллагааг тухайн шийдвэр гарсан өдрөөс эхлэн зогсоож, хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу тэдгээрийн хохирлыг барагдуулах, мөнгөн хөрөнгийг буцаан олгох арга хэмжээг авна.

19.7.Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой гарсан зардлыг зөвшөөрөл эзэмшигч хариуцан төлнө.”

5/35 дугаар зүйлийн 35.4.5 дахь заалт:

“35.4.5.Монголбанкнаас тогтоосон бусад нөхцөл, шаардлагыг хангана.”

2 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “гаргах” гэсний дараа “, хүлээн авах” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “хэрэгсэл гаргах” гэсний дараа “, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “олгох” гэсний дараа “сунгах, татгалзах” гэж, 15.1 дэх хэсгийн “төлбөрийн хэрэгсэл гаргах” гэсний дараа “, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх” гэж, 15.2 дахь хэсгийн “авах” гэсний дараа “, зөвшөөрөл сунгуулах” гэж “олгох” гэсний дараа “, сунгах” гэж, 15.3 дахь хэсгийн “15.1” гэсний дараа “, 15.5” гэж, “олгох” гэсний дараа “, сунгах” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “үндэслэлээр” гэсний дараа “Монголбанкны шийдвэрт заасан хугацаагаар” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйл:

“13 дугаар зүйл.Төлбөрийн хэрэгсэл гаргах, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих шаардлага

13.1.Төлбөрийн хэрэгсэл гаргах, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих шаардлагыг Монголбанк тогтооно.”

2/21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг:

“21.1.Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь Монголбанкнаас тогтоосон нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд Монголбанкны зөвшөөрлөөр аутсорсингийн үйлчилгээ авна. Аутсорсонгийн үйлчилгээ авах зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа Монголбанкнаас тогтоосон баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ.”

4 дүгээр зүйл. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.12 дахь заалт, 11.3.12 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.10 дахь заалтын “шаардсан” гэснийг “тогтоосон” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.10 дахь заалтын “шаардлагатай гэж үзсэн” гэснийг “тогтоосон” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “батална.” гэснийг “тогтооно.” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “зөвшөөрлийг 4 жилийн хугацаатай” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “шаардагдах” гэснийг “Монголбанкнаас тогтоосон” гэж, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “этгээдээс” гэснийг “этгээд, зөвшөөрөл авах хүсэлт гаргагчаас” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалтын “хөрөнгө” гэсний өмнө “хамтын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “ажлын гурван өдөрт багтаан хянах ба” гэснийг “хянаж,” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “зөвшөөрлийг хугацаагүйгээр” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.7.Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсэгт заасан арга хэмжээг авахаас гадна тухайн хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг тухайн хадгаламж, зээлийн хоршоонд, мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “13.4, 13.5-д” гэснийг “13.4-д” гэж, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “гурав хүртэл жилийн хугацаатай” гэснийг “хугацаагүй” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “зөвхөн зээлийн болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээний” гэснийг “зээлийн үйл ажиллагааны” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1, 15.6, 15.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.21 дэх заалт:

“3.1.21. “үйлчилгээний хүртээмж” гэж чанар, стандартын шаардлага хангасан харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээний төрлийг.”

2/6 дугаар зүйлийн 6.1.18 дахь заалт:

“6.1.18. зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн Зохицуулах хорооны саналыг харгалзан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийн хувь, хэмжээг тогтоох;”

3/16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг:

“16.3. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.11-д заасан харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэхэд интернэт, транзит урсгалыг бөөнөөр нийлүүлэх, шуудангийн сүлжээ болон зааглах цэг хоорондын сүлжээний үйл ажиллагаа хамаарна.”

4/19¹ дүгээр зүйл:

“19¹ дүгээр зүйл. Мэдээллийн сүлжээ

19¹.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.3-т заасан мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд интернет протокол ашигласан харилцан холболтын болон өгөгдөл хадгалах дэд бүтэц, контент түгээх сүлжээ болон зааглах цэг хоорондын виртуал сүлжээний үйл ажиллагаа хамаарна.”

2 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалт:

“3.1.15. “зохицуулалт” гэж харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах, тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоохтой холбоотой журам батлах,

гэрээ байгуулах, хяналт тавих, хууль тогтоомжид заасан асуудлаар шийдвэр гаргахтай холбогдсон цогц үйл ажиллагааг;”

2/12 дугаар зүйл:

“12 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл

12.1.Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.3, 9.4, 9.10, 9.12-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаатай хуулийн этгээдэд олгох бөгөөд хугацааг анх олгосон хугацаагаар сунгана.

12.2.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад зөвшөөрөлтэй холбоотой харилцааг энэ хууль болон Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Шуудангийн тухай хуулиар зохицуулна.

12.3.Энэ хуулийн 12.1, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Шуудангийн тухай хуульд заасан зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанаас бусад харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг иргэн, хуулийн этгээд Зохицуулах хороонд бүртгүүлнэ.

12.4.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчид мөн зүйлийн 9.8, 9.13, 9.15-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй.”

3/13 дугаар зүйл:

“13 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

13.1.Хуулийн этгээд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргаж Зохицуулах хороонд ирүүлнэ:

13.1.1.санхүү-эдийн засаг, техникийн чадавх болон мэргэжлийн хүний нөөцийн талаарх тооцоо, мэдээлэл, тэдгээрийг хангасныг нотолсон баримт бичиг;

13.1.2.хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл /үйлчилгээний хамрах хүрээ, байршил, технологи, үйлчилгээний тарифын санал/, тэдгээрийг хангасныг нотолсон баримт бичиг;

13.1.3.харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр өөр төрлийн зөвшөөрөл эзэмшдэг тохиолдолд мэдээ, тайлан ирүүлж байсныг нотолсон баримт бичиг.”

4/14 дүгээр зүйл:

“14 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хугацааг сунгах, сунгахаас татгалзах, түдгэлзүүлэх, сэргээх

14.1.Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2, 5.3 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргах бөгөөд тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд нь түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

14.1.1.үйлчлэх нутаг дэвсгэр, үйлчилгээний хүртээмж, зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны төрөл;

14.1.2.холбооны шугам, сүлжээний техник, тоног төхөөрөмжийн технологийн үзүүлэлт;

14.1.3.Зохицуулах хороо, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг;

14.1.4.онц болон дайны байдал зарласан, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл үүссэн тохиолдолд хүлээх үүрэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

14.1.5.харилцан холболт хийх нөхцөл;

14.1.6.бусад.

14.2.Зохицуулах хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

14.2.1.өргөдөл гаргагчийн хүссэн давтамжийн зурвас байхгүй;

14.2.2.өргөдөл гаргагч нь харилцаа холбооны сүлжээг байгуулах, ашиглах, санхүү-эдийн засаг, техникийн болон мэргэжлийн боловсон хүчин, техникийн иж бүрдлээр хангагдаагүй;

14.2.3.нийтийн эрх ашиг, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гэж үзсэн;

14.2.4.зохицуулалтын чиглэлд нийцээгүй.

14.3.Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах журмаар олгоно. Сонгон шалгаруулалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

14.4.Сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг олон нийтэд ил тод мэдээлэх бөгөөд энэ хугацааг нэг удаа 14 хоногоор сунгаж болно.

14.5.Сонгон шалгаруулалтын үнэлгээнд дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

14.5.1.харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний үйлчлэх нутаг дэвсгэр, үйлчилгээний хүртээмж, зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны төрөл;

14.5.2.төрөөс баримтлах бодлого болон зохицуулалтын чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөлт болон түүнийг хэрэгжүүлснээр үүсэх үр дүн;

14.5.3.техник, технологийн сонголт, үзүүлэлт;

14.5.4.үйлчилгээ хүргэх хугацааны төлөвлөлт;

14.5.5.өрсөлдөөн, зах зээлд үзүүлэх нөлөө;

14.5.6.санхүүгийн төлөвлөлт, чадавх;

14.5.7.хүний нөөцийн чадавх;

14.5.8.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангах байдал.

14.6.Энэ хуулийн 14.5-д заасан нөхцөлийн дагуу үнэлгээ өгч, хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдэд тусгай зөвшөөрөл олгоно.

14.7.Энэ хуулийн 14.6-д заасны дагуу шалгарсан этгээд эрх бүхий этгээдээс шалгарсан тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээг байгуулаагүй тохиолдолд дараагийн хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдтэй гэрээ байгуулна.

14.8.Энэ хуулийн 14.3-т заасан сонгон шалгаруулалтаар 1 этгээд хүсэлт ирүүлсэн бол тухайн этгээд хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд шалгарсан тухай мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулж тусгай зөвшөөрлийг олгоно.

14.9.Дараах тохиолдолд сонгон шалгаруулалтыг дахин зарлана:

14.9.1.энэ хуулийн 14.4-т заасан хугацаанд хүсэлт ирүүлээгүй;

14.9.2.сонирхогч этгээдийн ирүүлсэн хүсэлт нь хуульд заасан шаардлага хангаагүй;

14.9.3.энэ хуулийн 14.8-д заасан хугацаанд гэрээ байгуулаагүй.

14.10.Энэ хуулийн 14.9.1-д заасны дагуу зарласан сонгон шалгаруулалтад сонирхогч этгээд хүсэлт ирүүлээгүй бол тухайн жилд дахин сонгон шалгаруулалт зарлахгүй.

14.11.Зохицуулах хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана:

14.11.1.Зохицуулах хорооны хяналт, шалгалт, мониторингийн дүгнэлтийн дагуу өгсөн хугацаат үүргийг биелүүлээгүй;

14.11.2.төрөөс баримтлах бодлого, зохицуулалтын чиглэлд нийцэхгүй нь тогтоогдсон.

14.12.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1-д зааснаас гадна дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

14.12.1.Зохицуулах хорооны хяналт, шалгалт, мониторингийн тайлангаар зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй нь тогтоогдсон;

14.12.2.тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;

14.12.3.тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээ, тайлан ирүүлээгүй, дутуу ирүүлсэн.

14.13.Зохицуулах хороо энэ хуулийн 14.12-т заасан үндэслэл, нөхцөл, шаардлага арилгасан гэж үзвэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.”

3 дугаар зүйл.Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалтын “радио телевиз” гэснийг “радио холбоо, өргөн нэвтрүүлэг” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.18 дахь заалтын дугаарыг “6.1.19” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “иргэн,” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “, иргэн” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:

“5.2.Энэ хуулийн 5.1-д заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.”

2/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн 9.1.9, 9.1.10, 9.1.11, 9.1.12, 9.1.13, 9.1.14, 9.1.15, 9.1.16 дахь заалт:

“9.1.9.зөвшөөрөл хүссэн бодисын тоо хэмжээ, улсын хилээр нэвтрүүлэх боомт;

9.1.10.хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний, хүний хувьд иргэний үнэмлэхийн хуулбар;

9.1.11.үйлдвэрлэгч эсвэл албан ёсны борлуулагчаас тухайн химийн бодисыг дагалдуулан өгсөн англи эсвэл орос хэл дээрх хор аюулын лавлах мэдээлэл, бусад улсын хэлээр бол түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулга;

9.1.12.Зөвхөн шинжилгээ, судалгааны зориулалтаар ашиглагдах Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад орсон стандарт уусмал, бодис болон Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад орсон химийн бодисын хувьд Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн Шинжээчдийн багийн дүгнэлт;

9.1.13.химийн хорт болон аюултай бодисыг экспортлох зөвшөөрөл авахыг хүссэн хүн, хуулийн этгээд нь тухайн бодисыг олон улсын хэмжээнд болон хоёр талын хооронд худалдаалж болох эрх зүйн үндэслэл, хортой, аюултай бүтээгдхүүнийг хил дамжуулан тээвэрлэх олон улсын конвенци, гэрээ, хэлэлцээрийн шаардлагыг хангасан тухай танилцуулга болон нийлүүлэгч, хүлээн авагч, тээвэрлэгч талуудын хооронд хийсэн гэрээ, хэлэлцээрийн эх хувь, түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулга;

9.1.14.Химийн хорт болон аюултай бодис импортлох зөвшөөрөл авахыг хүссэн хүн, хуулийн этгээд нь нийлүүлэгч талтай хийсэн гэрээ хэлэлцээрийн монгол,

англи, орос хэл дээрх эх хувь, бусад улсын хэлээр бол монгол хэл дээрх албан ёсны орчуулга;

9.1.15.Химийн хорт болон аюултай бодис хил дамжуулан тээвэрлэх зөвшөөрөл авахыг хүссэн хүн, хуулийн этгээд нь нийлүүлэгч, хүлээн авагч, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх асуудлыг хариуцсан этгээдийн хооронд хийсэн гэрээ хэлэлцээрийн эх хувь болон түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулга;

9.1.16.Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх зөвшөөрөл авахыг хүссэн хүн, хуулийн этгээд нь химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ бүхий байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, үйлдвэрлэл явуулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, улсын комиссын акт, дүгнэлтийн хуулбар, үйлдвэрлэх бодисын химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл.”

2 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.14-т заасан Тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

3 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” гэснийг, 6.1.2 дахь заалтын “тээвэрлэх,” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Генетик нөөцийн тухай,” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хууль” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хүлээн авч” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлд заасан журмын дагуу” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.1.Иргэн, аж ахуйн нэгж байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.20-д заасан олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын хавсралтад заасан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох, импортлох зөвшөөрөл болон далай тэнгисээс олборлон оруулах гэрчилгээ авах хүсэлтээ Удирдан зохицуулах зөвлөлд ирүүлнэ.”

3 дугаар зүйл.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Зөвшөөрөл, гэрчилгээ олгох журам болон” гэснийг “Зөвшөөрлийн баримт бичиг, түүнтэй адилтгах эрхийн бичгийн” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “Байгаль орчны” гэсний өмнө “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.5-д заасны дагуу” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хог хаягдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6, 37.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“37.6.Хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

37.8.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан журмын дагуу зөвшөөрлийг хүчингүй болгоно.”

3 дугаар зүйл. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.5-д заасан зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтын “энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх” гэснийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.22-т заасан” гэж, мөн зүйлийн 9.3.3 дахь заалтын “зөвшөөрөл олгох журмыг батлах” гэснийг “зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу олгох” гэж, 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсгийн “37.1.2-т” гэснийг “37.1.1-д” гэж, мөн зүйлийн 37.7 дахь хэсгийн “дахин” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 5-д заасны дагуу” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “зөвшөөрөл авах тухай өргөдөлд дараахь” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай 12¹ дугаар зүйл нэмсүгэй:

1/12¹ дугаар зүйл:

“12¹ дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл

12¹.1. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд дараах ажлын төрлөөр таван жилийн хугацаатай олгоно:

12¹.1.1. хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг;

12¹.1.2. бүс нутгийн хөгжлийн төсөл, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл;

12¹.2.3. хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл.

12¹.2. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл шинээр болон сунгуулахаар хүссэн хуулийн этгээд нь дараах ажлын төрлөөр доор дурдсан нөхцөл шаардлага, инженер, техникийн ажилтан /мэргэжилтэн/-ы ажлын туршлага, тавигдах шаардлагын хангасан байна:

Ажлын төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтан /мэргэжилтэн/	Инженер техникийн ажилтан /мэргэжилтэн/-ы ажлын туршлага, тавигдах шаардлага
Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Хот төлөвлөлтийн архитектор-2	Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй архитектор-1
	Ландшафтын архитектор-1 Хот төлөвлөлтийн эдийн засагч-1	Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй архитектор-1
	Экологич-1/гэрээт/ Ус хангамж, ариутгах татуургын инженер-1	Ус хангамж, ариутгах татуургын мэргэшсэн зэрэгтэй инженер-1

	<p>Цахилгааны инженер-1</p> <p>Холбоо, дохиоллын инженер-1</p> <p>Дулааны инженер-1</p> <p>Усны барилга байгууламжийн инженер-1/гэрээт/</p> <p>Зам, гүүрийн инженер-1 /гэрээт/</p> <p>Тээврийн инженер-1 /гэрээт/</p>	<p>Цахилгааны мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Холбоо, дохиоллын мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Дулааны мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Хот төлөвлөлтийн мэргэшсэн эдийн засагч-1 тус тус байна.</p> <p><i>Геодези, зураг зүй, газар зохион байгуулалт, инженер хайгуул, байгаль орчны үнэлгээ, дэд бүтцийн төлөвлөлтийн хэсгийг тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.</i></p>
<p>Бүс нутгийн хөгжлийн төсөл, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл</p>	<p>Хот төлөвлөлтийн архитектор-2</p> <p>Ландшафтын архитектор-1</p> <p>Хот төлөвлөлтийн эдийн засагч-2</p> <p>Бүс нутаг төлөвлөгч-1</p> <p>Архитектор-1</p> <p>Газар зохион байгуулагч-1</p> <p>Газарзүйч-1</p> <p>Экологич-1 /гэрээт/</p> <p>Ус хангамж, ариутгах татуургын инженер-1</p> <p>Цахилгааны инженер-1</p> <p>Холбоо, дохиоллын инженер-1</p> <p>Дулааны инженер-1</p>	<p>Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй архитектор-1</p> <p>Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй архитектор-1</p> <p>Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй эдийн засагч-1</p> <p>Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй эдийн засагч-1</p> <p>Ус хангамж, ариутгах татуургын мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Цахилгааны мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Холбоо, дохиоллын мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Дулааны мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p>

	<p>Усны барилга байгууламжийн инженер-1/гэрээт/</p> <p>Зам, гүүрийн инженер-1/гэрээт/</p> <p>Геодезийн инженер-1</p> <p>Тээврийн инженер-1/гэрээт/</p> <p>Логистикийн инженер-1 /гэрээт/</p> <p>Зургийн техникч-2</p>	<p>Усны барилга байгууламжийн мэргэшсэн зэрэгтэй инженер -1</p> <p>Газар зохион байгуулагч мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Геодезийн мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p><i>Геодезийн хэмжилт, зураглал, зураг зүй, инженер хайгуул, байгаль орчны үнэлгээ, дэд бүтцийн төлөвлөлтийн хэсгийг тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.</i></p>
<p>Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл</p>	<p>Хот төлөвлөлтийн архитектор-8</p> <p>Хот төлөвлөлтийн эдийн засагч-2</p> <p>Эдийн засагч-2</p> <p>Бүс нутаг төлөвлөгч-1</p> <p>Архитектор-1</p> <p>Газар зохион байгуулагч-2</p> <p>Газарзүйч-1</p> <p>Экологич-1</p> <p>Барилгын инженер-1</p> <p>Ус хангамж, ариутгах татуургын инженер-2</p> <p>Цахилгааны инженер-2</p> <p>Холбоо, дохиоллын инженер-2</p> <p>Дулааны инженер-2</p>	<p>Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй архитектор-2</p> <p>Мэргэшсэн зэрэгтэй архитектор-4</p> <p>Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй эдийн засагч-1</p> <p>Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй эдийн засагч-1</p> <p>Барилгын зөвлөх зэрэгтэй инженер-1</p> <p>Ус хангамж, ариутгах татуургын зөвлөх зэрэгтэй инженер-1</p> <p>Цахилгааны зөвлөх зэрэгтэй инженер-1</p> <p>Холбоо, дохиоллын зөвлөх зэрэгтэй инженер-1</p> <p>Дулааны зөвлөх зэрэгтэй инженер-1</p>

	Усны барилга байгууламжийн инженер- 1	Усны барилга байгууламжийн зөвлөх зэрэгтэй инженер-1
	Зам, гүүрийн инженер-1	Геодезийн зөвлөх зэрэгтэй инженер-1
	Тээврийн инженер-1	Инженер геологийн зөвлөх зэрэгтэй инженер-1
	Геодезийн инженер-1	
	Инженер- геологийн инженер-1	Зам, гүүр, тээврийн хөдөлгөөний зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй инженер тус бүр 1
	Мэдээллийн сангийн мэргэжилтэн-1	
	Хүн ам зүйч-1	<i>Геодезийн хэмжилт, зураглал, зураг зүй, инженер хайгуул, байгаль орчны үнэлгээний хэсгийг тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.</i>
	Зургийн техникч-4	

12¹.3.Дараах тохиолдолд хуулийн этгээдэд олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

12¹.3.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан нөхцөл байдал үүссэн;

12¹.3.2.тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан үүргээ хоёроос дээш удаа биелүүлээгүй;

12¹.3.3.захиалагчтай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн хот байгуулалтын баримт бичиг нь холбогдох норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангаагүйгээс захиалагчид хохирол учруулсан нь эрх бүхий этгээдийн дүгнэлтээр тогтоогдсон;

12¹.3.4.гүйцэтгэсэн ажлын мэдээ, тайланг тухайн жилдээ багтааж цахим системд ирүүлээгүй.

12¹.4.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл нь зөвхөн Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах ба энэхүү тусгай зөвшөөрөл нь гадаадын хуулийн этгээдэд хамаарахгүй.

12¹.5.Гадаадын хуулийн этгээд нь энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, хот байгуулалтын баримт бичиг боловсруулж болно.”

2 дугаар зүйл.Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.4.хуулийн этгээдэд энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түтгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

7.1.6.хот баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, баримт бичгийг хадгалах журам батлах;”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.1.3 дахь заалтын “болох” гэсний дараа “шийдвэр гаргаж, Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгүүлэх” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийг доор дурдснаар өөрчлөн найруулсугай:

“12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл, түүнд тавигдах шаардлага

12.1. Энэ зүйлд заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангасан хуулийн этгээдэд Зохицуулах зөвлөл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.9-3.22-т заасан ангилалаар хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх болон гэрчилгээ олгож, гэрээ байгуулна.

12.2. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлийн хүсэлтийг Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлага болон доор дурдсан тусгай шаардлагыг хангасан, мэргэжилийн үндсэн ажилтантай хуулийн этгээд гаргана:

12.2.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.9-д заасан бохир усны гаргалгааны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.1.а. ус хангамж, ариутгах татуургын /сантехникийн/ мэргэжлийн инженертэй, 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн цэвэр, бохир усны мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

12.2.1.б. сантехникийн засварчинтай байх;

12.2.1.в. холболтын болон байршлын зураг, технологийн ажиллагааны горим бүдүүвч, засвар үйлчилгээний график, дэвсгэр зураг, тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх;

12.2.2. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.10-д заасан бохир ус цуглуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.2.а.ус хангамж ариутгах татуургын /сантехникийн/ мэргэжлийн инженертэй, 300м³/хоног хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн цэвэр, бохир усны мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

12.2.2.б.сантехникийн засварчинтай байх;

12.2.2.в.холболтын болон байршлын зураг, технологийн ажиллагааны горим бүдүүвч, засвар үйлчилгээний график, дэвсгэр зураг, тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх;

12.2.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.11-д заасан бохир ус татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.3.а.ус хангамж, ариутгах татуургын /сантехникийн/ мэргэжлийн инженертэй, 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн цэвэр, бохир усны мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

12.2.3.б.сантехникийн засварчинтай байх;

12.2.3.в.холболтын болон байршлын зураг, технологийн ажиллагааны горим бүдүүвч, засвар үйлчилгээний график, дэвсгэр зураг, тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх;

12.2.4.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.12-д заасан бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний тухайд:

12.2.4.а."С" ангиллын жолоочтой байх;

12.2.4.б.бохир ус зөөврийн зориулалтын автомашинтай байх;

12.2.4.в.бохир ус хаях цэгийг эрх бүхий байгууллагаар тогтоолгосон байх;

12.2.4.г.эрүүл ахуйн шаардлага хангасан байх

12.2.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.13-д заасан бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.5.а.цэвэр, бохир усны чиглэлээр мэргэжил эзэмшсэн бакалавр инженер, хүрээлэн буй эсвэл байгаль орчны бакалавр, түүнээс дээш зэрэгтэй мэргэжилтэн, 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн цэвэр, бохир усны мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх, цэвэрлэх байгууламж нь ус шинжилгээний лабораторитой байх;

12.2.5.б.сантехник, тоног төхөөрөмжийн засварчин, гагнуурчин, цахилгаанчин, хэмжих хянах хэрэгслийн засварчин ажилчид тус бүр нэгээс доошгүй байхаас гадна ус шинжилгээний лабораторитай бол мэргэжлийн ажилтантай байх;

12.2.5.в.тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөл, бохир ус цэвэрлэгээний технологийн бүдүүвч, цэвэрлэгээний түвшин, гарах усны найрлага, лабораторийн шинжилгээний дүн, дүгнэлттэй байх;

12.2.5.г.шугам, сүлжээ болон байгууламжуудын байршлын зураг, ашиглалтад хүлээн авсан акт, ашиглалтын гэрээ /өөрийн эзэмшлийн тохиолдолд хамаарахгүй/, тоног төхөөрөмж нэг бүрийн техникийн тодорхойлолт, ашиглалтын заавартай байх;

12.2.5.д.цэвэрлэх байгууламжийн хүчин чадалд тохируулан үйлчлэх хүрээг тодорхойлж, баталгаажуулсан бүдүүвч зураг, тайлбарыг ирүүлэх. Энэ нь зөвхөн тухайн цэвэрлэх байгууламжид хамаарах бөгөөд цэвэрлэх байгууламжийн үйлчлэх хүрээг өөрчлөх, шинээр нэмэх тохиолдолд нөхцөл, шаардлагын хүсэлтийг дахин ирүүлж шийдвэрүүлнэ.

12.2.6.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.14-д заасан зөөврийн ус хангамжийн үйлчилгээний тухайд:

12.2.6.а.“С” ангиллын жолоочтой байх;

12.2.6.б.ус зөөврийн зориулалтын автомашинтай байх;

12.2.6.в.эрүүл ахуйн шаардлага хангасан байх;

12.2.6.г.ундны зориулалтаар зөөвөрлөх цэвэр ус нь ундны усны чанарын стандарын шаардлага хангасан байх.

12.2.7.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.15-д заасан орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.7.а.ус хангамж, ариутгах татуургын /сантехникийн/, дулаан хангамжийн мэргэжлийн инженер, ээлжийн диспетчер, 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн цэвэр, бохир усны мэргэжлийн ажилтан, ээлжийн диспетчер тус тус байх;

12.2.7.б.300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газраас бусад тохиолдолд 200 өрхийн дунд 1 сантехникийн засварчинтай байх;

12.2.7.в.гагнуурчин, цахилгаанчинтай байх;

12.2.7.г.шугам, сүлжээний схем, байршлын зураг, технологийн бүдүүвч, дэвсгэр зураг, ашиглалтад хүлээн авсан акт, гэрээ, техникийн тодорхойлолттой байх;

12.2.7.д.сард борлуулж буй усны хэмжээ нь үйл ажиллагааг хэвийн, алдагдалгүй явуулах нөхцлийг хангасан байх;

12.2.7.е.шинээр тусгай зөвшөөрөл авч буй байгууллагуудын хувьд айл өрхүүдийг 100% тоолууржуулсан байх;

12.2.7.ё.тусгай зөвшөөрөл сунгуулах аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд айл өрх, аж ахуйн нэгжүүдийг 80-аас доошгүй хувь тоолууржуулсан байх буюу тоолууржуулалт хийх график, төлөвлөгөөтэй байх;

12.2.7.ж.орон сууцны засвар үйлчилгээний талаар хэрэглэгчдийн гомдол санал хүлээн авах, шуурхай дуудлагын утас ажиллуулдаг байх;

12.2.7.з.засвар үйлчилгээ явуулахад хүндрэлгүй, үйлчилгээ үзүүлэх объект нь ойролцоо байрлалд, хамгийн бага зардлаар чанартай, шуурхай үйлчилгээ үзүүлэх нөхцлийг хангах;

12.2.7.и.хэрэглэгчдээс үйлчилгээнийхээ талаар санал, хүсэлтийн судалгааг авч, дүгнэлт гарган, холбогдох арга хэмжээг авч ажиллах журамтай байх;

12.2.7.й.өөрийн үйлчлэх хүрээнээс алслагдсан цэгт, мөн өөр дүүрэгт барилга байгууламж хариуцах тохиолдолд тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тухайн орчинд бүрдүүлж, бүрэн хангасан байх;

12.2.8.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.16-д заасан ус дамжуулах төвийн ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.8.а.ус хангамж, ариутгах татуурга /сантехникийн/, дулааны чиглэлийн мэргэжлийн инженер тус бүр нэгээс доошгүй байх;

12.2.8.б.сантехникийн засварчин, цахилгаанчин, гагнуурчинтай байх;

12.2.8.в.Байршлын зураг, технологийн ажиллагааны горим бүдүүвч, дэвсгэр зураг, техникийн тодорхойлолт, ашиглалтад хүлээн авсан акт зэргийг бүрдүүлсэн байх;

12.2.9.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.17-д заасан ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.9.а.300м³/хоногоос дээш хүчин чадалтай ус хангамжийн байгууламжийн хувьд усны шинжилгээний лаборатори, тухайн мэргэжлийн инженер, технологич, хүрээлэн буй эсвэл байгаль орчны бакалавр, түүнээс дээш зэрэгтэй мэргэжилтэн, засварчинтай байх, 300м³ /хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн цэвэр, бохир усны мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

12.2.9.б.халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийн засварчинтай байхаас гадна ус шинжилгээний лабораторитай бол мэргэжлийн ажилтантай байх;

12.2.9.в.тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөлтэй байх;

12.2.9.д.тухайн байгууллагын ашиглаж буй ус цэвэршүүлэх технологийн ажиллагааны горим, техник технологи нь шаардлага хангасан, лабораторийн шинжилгээний дүн, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй, усны чанарын стандартын шаардлага хангасан байх;

12.2.9.е.ус хангамжийн эх үүсвэрийн ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчид нийлүүлж буй усны дээжийг өдөр бүр авч, лабораторийн шинжилгээ хийх бөгөөд ундны усны холбогдох стандартад нийцсэн усаар хангаж байх;

12.2.9.ж.усан сангийн ариутгал халдваргүйжүүлэлтийг холбогдох стандартын дагуу хийх бөгөөд ариутгалын бодисын нөөцтэй байх;

12.2.9.з.хот, суурин газрын хүн амд ус хангамжийн эх үүсвэрээс унд, ахуйн зориулалтаар олборлон, дамжуулан түгээж буй ус нь ундны усны чанарын холбогдох стандартыг хангасан, халдваргүйжүүлсэн байх;

12.2.10.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.18-д заасан ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээний тухайд:

12.2.10.а.ус хангамж, ариутгах татуургын болон мэргэжлийн зөвлөх буюу мэргэшсэн инженертэй байх;

12.2.10.б.шаардлагатай тохиолдолд цахилгаан, хэмжих хянах хэрэгслийн мэргэжлийн инженер, химич, бактериологичтой байх;

12.2.10.в.сантехникийн засварчин, гагнуурчинтай байх;

12.2.10.г.засвар үйлчилгээний зориулалтын автомашин, автокран, эксковатор, зөөврийн гагнуурын аппарат, цэвэр, бохир ус шинжилгээний суурин болон зөөврийн лаборатори, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн нөөцтэй байх.

12.2.11.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.19-д заасан хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.11.а.цэвэр, бохир усны чиглэлээр мэргэжил эзэмшсэн бакалавр инженер, хэмжих хянах хэрэгслийн чиглэлээр бэлтгэгдсэн инженер, цахилгааны мэргэжлийн инженер, хүрээлэн буй эсвэл байгаль орчны бакалавр, түүнээс дээш зэрэгтэй мэргэжилтэнтэй байх, 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн цэвэр, бохир усны, цахилгааны мэргэжлийн ажилтан тус бүр нэгээс доошгүй байх;

12.2.11.б.сантехникийн засварчин, цахилгаанчин, хянах, хэмжих хэрэгслийн засварчин, гагнуурчин зэрэг мэргэжлийн ажилчидтай байх;

12.2.11.в.тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөлтэй байх;

12.2.11.г.ус хангамжийн эх үүсвэрийн харуул хамгаалалт нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн байх;

12.2.11.д.тоног төхөөрөмж, технологийн ажиллагааны горим бүдүүвч, холбогдох стандартуудыг бүрдүүлсэн байх;

12.2.12.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.20-д заасан хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.12.а.төвлөрсөн шугамын ус түгээх байрны хувьд сантехникийн засварчин, ус түгээгчтэй байх, хангагч байгууллагатай байгуулсан гэрээтэй байх;

12.2.12.б.гүний ус түгээх байрны хувьд ус түгээгчтэй байх, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт, ажлын байрны дүгнэлттэй байх;

12.2.12.в.зөөврийн ус түгээх байрны хувьд ус түгээгчтэй байх, хангагч байгууллагатай байгуулсан гэрээтэй байх;

12.2.13.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.21-д заасан цэвэр ус дамжуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний тухайд:

12.2.13.а.цэвэр, бохир усны чиглэлээр мэргэжил эзэмшсэн бакалавр инженертэй байх, 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн цэвэр, бохир усны мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

12.2.13.б.сантехникийн засварчин, гагнуурчинтай байх;

12.2.13.в.технологийн ажиллагааны горим бүдүүвч, дэвсгэр зураг, техникийн тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх.

12.2.14.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.22-д заасан цэвэр ус түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ тухайд:

12.2.14.а.цэвэр, бохир усны чиглэлээр мэргэжил эзэмшсэн бакалавр инженертэй байх, 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн цэвэр, бохир усны мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

12.2.14.б.сантехникийн засварчин, гагнуурчинтай байх;

12.2.14.в.технологийн ажиллагааны горим бүдүүвч, дэвсгэр зураг, техникийн тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх.

12.3.Энэ хуулийн 12.1-д заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.”

3 дугаар зүйл.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөрөнгийн үнэлгээний тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.3.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“45.4. Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсэгт заасан арга хэмжээг авна.”

2 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор” гэснийг, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “хүсэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор шийдвэр гаргана” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2, 5.3 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэрлэнэ” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “бие хамгаалагч” гэж” гэсний дараа, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “Хувийн хамгаалалтыг” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хууль болон” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсэг:

“6.4.Цагдаагийн төв байгууллага нь зөвшөөрөл хүссэн өргөдлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

6.5.Энэ зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэгт заасан бичиг баримт нь эрх бүхий байгууллагад байгаа, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системээс татан авах боломжтой бол иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.”

2/7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.4 дэх хэсэг:

“7.1.Цагдаагийн төв байгууллага хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан болон бие хамгаалагч гэмт хэрэгт холбогдсон бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэн өдрөөс эхлэн уг тогтоолыг хүчингүй болгох, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

7.2.Хуульд заасан түдгэлзүүлэх үндэслэл арилсан бол Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

7.4.Цагдаагийн төв байгууллага нь хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу хүчингүй болгоно.”

3/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:

“9.1.Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалах, хамгаалалтын хэрэгслийн зураг төсөл хийх, угсрах, ашиглах үйлчилгээ явуулах, гэмт халдлагаас хамгаалалт хийх асуудлаар үйлчлүүлэгчид хууль зүйн болон мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчлүүлэгчээс зохион байгуулж байгаа хурал бусад арга хэмжээг хамгаалалтад

авах, үзвэр, үйлчилгээний арга хэмжээний хамгаалалтын үйл ажиллагааг эрхлэх эрхтэй.”

3 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/” гэснийг “цагдаагийн төв байгууллага” гэж, мөн зүйлийн 6.2, 6.3 дахь хэсгийн “аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/-т” гэснийг “цагдаагийн төв байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Генетик нөөцийн тухай,” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хууль” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “Хувиргасан” гэсний өмнө “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.17-д заасан” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хувиргасан амьд организмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.5.Энэ хуулийн 6.1-д заасан зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлд заасан журмын дагуу Үндэсний хорооны дүгнэлтийг үндэслэн 30 хоногийн дотор шийдвэр гаргана.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний тухай хуульд доор дурдсан агуулгатай 5¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“5¹ дүгээр зүйл. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам

5¹.1. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг нэр төрлөөс нь хамааруулан дараах хугацаанд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд цахимаар хүргүүлнэ:

5¹.1.1. сүүний тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор;

5¹.1.2. малын махны тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны дотор;

5¹.1.3. гурил, тарианы үр, хүнсний улаанбуудай, ундны усны тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор.

5¹.2. Хүнсний хангамжийн тогтвортой, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх нэмэлт саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд оруулж болно.

5¹.3. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн хүнсийг экспортлох зөвшөөрөл олгохдоо зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 10 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлд нийлүүлэх, импортлох зөвшөөрлийг олгохдоо зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 50 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлээс худалдан авах шаардлагыг тавьж, хуулийн этгээдтэй энэ талаар гэрээ байгуулж болно.

5¹.4. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох үйл ажиллагааг нэг цонхны бодлогоор зохион байгуулахаар хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэсэн, эсхүл энэ хуулийн 5¹.22-т зааснаас бусад тохиолдолд стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.

5¹.5. Энэ хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.4-т заасан сонгон шалгаруулалтыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг зохион байгуулна.

5¹.6.Энэ хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.5-д заасан ажлын хэсэг стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын зар гаргах, урилга хүргэх, хариу илгээх, үр дүнг мэдээлэх ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна.

5¹.7.Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн хуулийн этгээд нь дараах баримт бичгийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ:

5¹.7.1.экспортлох, эсхүл импортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг заасан албан бичиг;

5¹.7.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

5¹.7.3.стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрийн байртай болохыг нотолсон холбогдох хяналтын байцаагчийн тодорхойлолт;

5¹.7.4.экспортлогч, импортлогч улсын үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;

5¹.7.5.шаардлагатай тохиолдолд импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн албаны эрх бүхий байгууллагын итгэмжлэл.

5¹.8.Энэ хуулийн 5¹.7-д заасан баримт бичгийг хүлээн авах эцсийн хугацааг цахим зар гаргасан өдрөөс эхлэн тооцож, ажлын 10 өдрөөр тогтооно.

5¹.9.Ажлын хэсэг хугацаа хоцорсон баримт бичгийг хүлээн авахгүй бөгөөд дутуу материалыг нөхөн бүрдүүлэхгүй. Хуулийн этгээдийн тамга, тэмдэггүй, гарын үсэггүй, огноо тодорхойгүй, шаардлага хангаагүй баримт бичиг ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасах ба энэ талаар хүсэлт гаргагчид ажлын 2 өдрийн дотор мэдэгдэнэ.

5¹.10.Ажлын хэсэг хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичигтэй холбоотой асуудлаар тайлбар болон энэ хуулийн 5¹.7-д зааснаас бусад баримтыг энэ хуулийн 5¹.13-т заасан хугацаанд багтаан тухайн хуулийн этгээдээс нэмэлтээр шаардаж болно.

5¹.11.Ажлын хэсэг стратегийн хүнсийг экспортлох, импортлох хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд үнэлгээ хийж, нэг хуулийн этгээдэд өгч болох тоо хэмжээний зөвшөөрлийн дээд хэмжээг тогтоож болно.

5¹.12.Ажлын хэсэг нь хуулийн этгээдийн хүсэлтэд дурдсан тоо хэмжээ болон энэ хуулийн 5¹.7, 5¹.10, 5¹.11-д заасан баримт бичгийг магадлан шалгасны үндсэн дээр уг хуулийн этгээдэд тухайн стратегийн хүнсийг экспортлох, эсхүл импортлох зөвшөөрөл олгох тоо хэмжээг тогтооно.

5¹.13.Ажлын хэсэг баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан сонгон шалгаруулалтыг явуулж, импортлох, эсхүл экспортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээ бүхий зөвшөөрөл олгох тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

5¹.14.Хуулийн этгээд нь энэ хуулийн 5¹.9-д заасан мэдэгдэл болон 5¹.13-т заасан тоо хэмжээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдөрт багтаан хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гомдол гаргаж болно.

5¹.15.Энэ хуулийн 5¹.14.-т заасан гомдлыг ажлын 3 өдөрт хянан шийдвэрлэнэ.

5¹.16.Хуулийн этгээдээс энэ хуулийн 5¹.15-т заасан хугацаанд гомдол ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн гомдлыг хянан үзээд үндэслэлгүй гэж үзвэл хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шалгарсан хуулийн этгээдэд ажлын 5 өдөрт багтаан зөвшөөрөл олгох шийдвэр гаргана.

5¹.17.Зөвшөөрлийн хугацаа нь энэ хуулийн 5¹.16-д заасан шийдвэр гарснаас хойш 12 сараас, энэ хуулийн 5¹.2-т заасан нэмэлт зөвшөөрлийн хугацаа нь 6 сараас хэтрэхгүй.

5¹.18.Хүн амын хүнсний хангамж, үнийн түвшинг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний хязгаар тогтоохгүй, тухайн жилийн мал төллөх болон ургац хураах цаг хугацаанд стратегийн хүнсийг экспортлохгүй, импортлохгүй байх зохицуулалтыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хийж болно.

5¹.19.Хуулийн этгээд Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд зааснаас гдна энэ хуулийн 5¹.17-д заасан хугацааны дотор стратегийн хүнсийг экспортлоогүй, импортлоогүй тохиолдолд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5¹.20.Энэ хуулийн 5¹.19-д заасны дагуу хүчингүй болгосон зөвшөөрөлд заасан тоо хэмжээнд ногдох стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийг дахин сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр олгоно.

5¹.21.Хуулийн этгээд зөвшөөрлийг бусдад дамжуулах, шилжүүлэх, худалдахыг хориглоно.

5¹.22.Дараах тохиолдолд стратегийн хүнсийг нэг удаагийн зөвшөөрлөөр экспортолж, импортолж болно.

5¹.22.1.зах зээлд шинээр нэвтрэх, бүтээгдэхүүний дээж хүргүүлэх, туршилтын ачилт хийх;

5¹.22.2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл энэ хуулийн 18.5.1-д заасан хугацаанд тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаар зөвлөмж гаргаагүй.

5¹.23.Стратегийн хүнсийг нэг удаагийн зөвшөөрлөөр экспортлох, импортлох хуулийн этгээд энэ хуулийн 5¹.71-5¹.7.5-д заасан баримт бичгийг бүрдүүлж хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5¹.24.Стратегийн хүнсийг нэг удаа экспортлох, импортлох зөвшөөрлийг энэ хуулийн 5¹.5-д заасны ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

2 дугаар зүйл. Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийн “Засгийн газраас баталсан” гэснийг “энэ хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.5 дахь хэсэг нэмсүгэй:

“13.5. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 6.4 дэх хэсгийн “дээш боловсролтой,” гэсний дараа “бага насны, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах, асрах, хүүхдийн эрүүл аюулгүй байдлыг хангах, зөв хооллох, бие бялдар, оюун ухааны хөгжлийг дэмжих” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 13.2, 13.3, 13.4 дэх хэсэг:

“13.2. Иргэн хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авах болон сунгуулах нөхцөл, шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргуулахаар баг, хорооны Засаг даргад хүсэлт гаргана.

13.3. Баг, хорооны Засаг дарга нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлага болон баримт бичгийн бүрдлийг хангасан эсэхийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу хянан, магадлан шалгах ажиллагааг хийнэ. Магадлан шалгах ажиллагааг дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан дүгнэлтийг баримт бичгийн хамт сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ. Сум, дүүргийн Засаг дарга зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг ажлын таван өдөрт багтаан гаргана.

13.4. Энэ хуулийн 13.3-т заасны дагуу баг, хорооны Засаг дарга дүгнэлт гаргахад орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.”

2/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:

“14.1. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

14.1.1. хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл;

14.1.2. иргэний бүртгэлийн мэдээлэл, үүсгэн байгуулагчийн өөрийн өмчлөлийн байрны лавлагаа, оршин суугаа хаягийн бүртгэлийн лавлагаа;

14.1.3.түрээсийн байр, гэрт үйл ажиллагаа явуулах бол түрээслэгчтэй байгуулсан гэрээ;

14.1.4.хүүхэд харагчийн боловсролын диплом, бүрэн дунд боловсролын гэрчилгээний мэдээлэл;

14.1.5.хүүхэд харагчийг бэлтгэх, чадавхжуулах сургалтад хамрагдсан тухай баримт;

14.1.6.халдварт болон сэтгэцийн өвчингүй болохыг тодорхойлсон эмнэлгийн байгууллагын дүгнэлт.”

4 дүгээр зүйл.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн Зургаадугаар бүлгийн болон 13 дугаар зүйлийн гарчгийн “олгох, түдгэлзүүлэх,” гэснийг “сунгах, түдгэлзүүлэх, сэргээх,” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хэмжил зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.3 дахь хэсэг нэмсүгэй:

“11.3.Энэ хуулийн 11.2-д заасан стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу батална.”

2 дугаар зүйл.Хэмжил зүйн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг:

“11.2.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэхэд тавих шаардлагыг стандартаар тогтооно.”

2/19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт:

“19.2.4.хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын болон хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга хийх ажилтны чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэхэд тавих шаардлагыг тогтоох стандартыг батлуулж, мөрдүүлэх;”

3 дугаар зүйл.Хэмжил зүйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цахим гарын үсгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг:

“23.3.Компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг шинээр бий болж байгаа компанид шилжүүлж болох бөгөөд шилжүүлэн авсан компани энэ хуулийн 20.1, 20.2, 20.3-т заасан эрх, үүргийг хүлээнэ.”

2/26 дугаар зүйлийн 26.7, 26.8 дахь хэсэг:

“26.7.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тусгай зөвшөөрөл олгохдоо тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулна.

26.8.Гэрээнд тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг тогтоохтой холбоотой харилцааг тусгана.”

3/31 дүгээр зүйлийн 31.1.11 дэх заалт:

“31.111.хуульд заасан бусад.”

2 дугаар зүйл.Цахим гарын үсгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/25 дугаар зүйл:

“25 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

25.1.Тусгай зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлж, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана:

- 25.1.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 25.1.2.гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журам;
- 25.1.3.харилцагч банкны мэдэгдэл;
- 25.1.4.баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт;

25.1.5.кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн тайлан;

25.1.6.олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллагын стандартын шаардлагыг хангасан талаарх тайлан;

25.1.7.өөр төрлийн зөвшөөрөл эзэмшдэг бол зөвшөөрлийн хуулбар.”

3 дугаар зүйл.Цахим гарын үсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “гэрчилгээжүүлэх байгууллага” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “21 өдрийн” гэснийг “17 өдрийн” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1.8 дахь заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигчийн” гэснийг “гэрчилгээжүүлэх байгууллагын” гэж, мөн зүйлийн 31.1.10 дахь заалтыг “тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувь, хэмжээг зах зээлийн багтаамж, хэрэглэгчийн тоонд үндэслэн тогтоох.” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Цахим гарын үсгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэх заалтад заасан “, эсхүл ноцтой” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалт:

“11.1.9.Энэ хуулийн 15.1-д заасан тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягт батлах.”

2/19 дүгээр зүйлийн 19.2¹ дахь хэсэг:

“19.2¹.Энэ хуулийн 15.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

19.2¹.1.олборлосон эсвэл олборлох ураны хүдэр, ураны хүдрийн баяжмал болон бусад дагалдах бүтээгдэхүүний тоо, хэмжээ, агуулгын талаарх мэдээлэл;

19.2¹.2.цөмийн бодис дахь элементийн агуулга, тоо хэмжээг тодорхойлсон лабораторийн дүн шинжилгээ;

19.2¹.3.олборлолт болон болон боловсруулалтын үйл ажиллагаанаас үүссэн эсвэл үүсэх хаягдлын талаарх мэдээлэл;

19.2¹.4.цөмийн бодис хадгалах байгууламжийн үндсэн мэдээлэл (ерөнхий зохион байгуулалт, газрын зураг, бүдүүвч зураг, байгууламжид нэвтрэх маршрут гэх мэт), эзэмшигчийн нэр, хяналтын асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тухайн байгууламжид гүйцэтгэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны төлөвлөгөө;

19.2¹.5.хяналтын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, эрх бүхий албан тушаалтны нэр болон холбоо барих мэдээлэл, баталгааны асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл, холбогдох дүрэм, журам;

19.2¹.6.цөмийн бодис, цөмийн материалын биет хамгаалалтыг хангах талаарх мэдээлэл;

19.2¹.7.цөмийн бодис, цөмийн материалын дотоод бүртгэлийн системийн мэдээлэл (мэдээллийн системийн аюулгүйн байдлыг хангах арга хэмжээ, аюулгүй байдлын зааварчилгаа ба түүний хуулбар);

19.2¹.8.материалын тэнцлийн талбай байршил болон цөмийн материалын тооллого, урсгалыг хянах хэмжилтийн гол цэг болон стратегийн цэгийн мэдээлэл;

19.2¹.9.цөмийн бодис, цөмийн материалын тоо хэмжээг тодорхойлох үнэлгээний арга болон тооцоо, хэмжилт хийх үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

19.2¹.10.бүртгэлтэй холбоотой биет тооллого явуулах үйл ажиллагаа болон давтамжийн талаарх мэдээлэл;

19.2¹.11.цөмийн материалын багцыг тодорхойлох техникийн үзүүлэлт;

19.2¹.12.цөмийн материалын урсгалын хяналтыг хэрэгжүүлэхэд ашиглах хязгаарлалтын болон ажиглалтын системийн талаарх мэдээлэл;

19.2¹.13.баталгаатай холбоотойгоор байгууламжид дотоодын болон олон улсын байцаагч нэвтрүүлэх журам.”

3/19 дүгээр зүйлийн 19.2² дахь хэсэг:

“19.2².Энэ хуулийн 15.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

19.2².1.олборлосон эсвэл олборлох ураны хүдэр, ураны хүдрийн баяжмал болон бусад дагалдах бүтээгдэхүүний тоо, хэмжээ, агуулгын талаарх мэдээлэл;

19.2².2.цөмийн бодис дахь элементийн агуулга, тоо хэмжээг тодорхойлсон лабораторийн дүн, шинжилгээ;

19.2².3.олборлолт болон болон боловсруулалтын үйл ажиллагаанаас үүссэн эсвэл үүсэх хаягдлын талаарх мэдээлэл;

19.2².4.ачуулах цөмийн бодис, цөмийн материалын нийт хэмжээ, түүнд хамаарах материалын агууламжийг изотопоор, химийн найрлагаар, физик хэлбэрээр илэрхийлсэн мэдээлэл;

19.2².5.тээвэрлэлтийн чингэлгийн төрөл (экспортлох тохиолдолд битүүмжлэх боломжийн техникийн мэдээлэл);

19.2².6.экспортлох тохиолдолд хүрэх газар, улс, импортлох тохиолдолд материалын сав баглааг задлах материалын тэнцлийн хэсэг болон байршлын талаарх мэдээлэл;

19.2².7.тээвэрлэлтийн төрөл, маршрутын талаарх мэдээлэл;

19.2².8.экспортлох тохиолдолд ачааг бэлтгэх газрын талаарх мэдээлэл;

19.2².9.тээвэрлэлтийн бүртгэлийн системийн талаарх мэдээлэл (экспортлох тохиолдолд цөмийн бодисыг тодорхойлох, тоо хэмжээ болон найрлагыг шалгах, импортлох тохиолдолд цөмийн бодис агуулсан ачааг буулгаж, задлан түүний хэмжээ болон найрлагыг магадлан шалгах үйл ажиллагаа).”

4/19 дүгээр зүйлийн 19.5.3 дахь заалт:

“19.5.3.шаардлагатай бол худалдах, худалдан авах гэрээний хуулбар.”

5/25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг:

“25.3.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой гомдлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйлийн 1-д заасан журмын дагуу гаргана.”

6/36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэг:

“36.3.Цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг энэ хуулийн 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад этгээд ашиглахыг хориглоно.”

2 дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт:

“15.1.4.цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлах.”

2/18 дугаар зүйлийн 18.9, 18.11 дэх хэсэг:

“18.9.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзээд тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг үйл ажиллагааны онцлогийг харгалзан дараах хугацаанд шийдвэрлэнэ:

18.9.1.энэ хуулийн 15.1, 15.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 6-12 сарын дотор;

18.9.2.энэ хуулийн 15.3.1, 15.3.2, 15.3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1-3 сарын дотор;

18.9.3.энэ хуулийн 15.3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг ажлын 3-14 өдрийн дотор.”

18.11.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага шаардлагатай бол холбогдох байгууллагаар өргөдөл гаргагчийн баримт бичгийн магадлан шалгах ажиллагааг хийлгэж болно.”

3/19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэг:

“19.6.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь өргөдлийг хүлээн аваад Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2-т заасны дагуу баримт бичгийн бүрдлийг шалгана.”

4/20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг:

“20.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу тэмдэгтийн хураамж төлнө.”

5/21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг:

“21.1.Энэ хуулийн 15.1.1, 15.1.3, 15.1.4, 15.2.1, 15.2.3, 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгоно.”

6/22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг:

“22.3.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 22.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянан, зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар сунгаж, энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.”

7/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

“23.1.Тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасны дагуу түдгэлзүүлж, сэргээнэ.”

8/26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг:

“26.1.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1-д заасан үндэслэлээр хүчингүй болгоно.”

3 дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 11¹ дүгээр зүйлийн гарчиг, 11^{1.1}, 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.3, 18 дугаар зүйлийн 18.8, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.6, 28.2.7, 28.2.8 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.4, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “цөмийн болон цацрагийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “Захиргааны хариуцлагын тухай хууль” гэснийг “Зөрчлийн тухай хууль” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “харьяалах хяналтын” гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бусад шаардлагатай” гэснийг “шаардлага хангасан” гэж, 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 19.8 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “цөмийн болон цацрагийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалтын дугаарыг “11.1.10” гэж, 22 дугаар зүйлийн 22.5.2 дахь заалтын дугаарыг “22.5.1” гэж, 22.5.3 дахь заалтын дугаарыг “22.5.2” гэж, 23 дугаар зүйлийн гарчгийг “Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.3, 18.4 дэх хэсгийн “хамгийн сайн” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.6.1, 19.6.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.5, 20.6 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.5.1, 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шуудангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/10¹ дугаар зүйл:

“10¹ дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

10¹.1. Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.13, 9.15-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд 5 жилийн хугацаатай олгож, хугацааг анх олгосон хугацаагаар сунгана.

10¹.2. Энэ хуулийн 10¹.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Харилцаа холбооны тухай хуулиар зохицуулна.

10¹.3. Шуудангийн сүлжээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны тухай хуулиар зохицуулна.

10¹.4. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохдоо тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах бөгөөд гэрээнд Харилцаа холбооны хуулийн 14.1-д зааснаас гадна шуудангийн үйлчилгээний зэрэглэлийг тусгана.”

2/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

“10.4. Илгээмжийг хүлээн авах, цуглуулах, тээвэрлэх, хаягт эзэнд хүргэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.13, 9.15-д заасан тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэхийг хориглоно.”

2 дугаар зүйл. Шуудангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19.2. Шуудангийн үйлчилгээг үйлчлүүлэгчид хүргэх хамрах хүрээгээр нь улс хоорондын болон дотоодын, үйл ажиллагаагаар нь нэмэлт болон үндсэн, хугацаагаар нь ердийн болон буухиа гэсэн зэрэглэл тогтооно.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/15¹ дугаар зүйл:

“15¹ дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох зөвшөөрөл олгох

“15¹.1.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох зөвшөөрөл хүсэгч нь дараах баримт бичгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлтийн хамт хүргүүлнэ:

15¹.1.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

15¹.1.2.малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөл, экспортлох тохиолдолд малын эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл;

15¹.1.3.гадаад улсын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэгч байгууллагатай байгуулсан худалдааны гэрээ, итгэмжлэл, эсхүл албан ёсны төлөөлөл болохыг нотлох баримт;

15¹.1.4.эмийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

15¹.1.5.эм, эмийн түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын сертификат, тохирлын гэрчилгээ;

15¹.1.6.импортын зөвшөөрлийн хувьд экспортлогч орны эмийн цувралын чанарын баталгаажилт;

15¹.1.7.эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн олон улсын болон тухайн орны чанар баталгаажилтын болон гарал үүслийн гэрчилгээ, хэрэглэх заавар үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчийн /GMP, ISO/ олон улсын чанар стандартын шаардлага хангасан гэрчилгээ;

15¹.1.8.эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, хэлбэр, тун, тоо хэмжээ /баглаа боодол/, үйлдвэрлэгчийн нэр, хилээр нэвтрүүлэх хугацаа, нэвтрүүлэх хилийн боомтын талаархи мэдээлэл;

15¹.1.9.эм, биобэлдмэл импортлох үед ачаа, тээврийн баримтын гаальд бүртгэгдсэн эх хувь (AWB), баглаа, боодлын дэлгэрэнгүй бүртгэл, нэхэмжлэлийн хуулбар, үйлдвэрлэгчээс олгосон сертификат.

15¹.2.Мал, амьтны тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох зөвшөөрөл хүсэгч нь дараах баримт бичгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлтийн хамт хүргүүлнэ:

15¹.2.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

15¹.2.2.үйлдвэрлэгч болон албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;

15¹.2.3.импортлох, экспортлох мал, амьтны тэжээлийн нэмэлтийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

15¹.2.4.үйлдвэрлэгчийн олон улсын чанарын стандартын шаардлага хангасан гэрчилгээ;

15¹.2.5.мал, амьтны тэжээлийн нэмэлтийн найрлага, гарал үүсэл, чанарын гэрчилгээ;

15¹.2.6.шошгоны загвар, хэрэглэх заавар, шаардлагатай тохиолдолд хэрэглэх зааврын монгол хэл дээрх орчуулга;

15¹.2.7.тухайн тэжээлийн нэмэлтийн хүчинтэй хугацааны 3/4 нь өнгөрөөгүй болохыг нотлох баримт.

15¹.3.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан журмыг баримтлан хугацаанд нь шийдвэрлэнэ.

15¹.4.Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийг ашиглан улсын хилээр эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаажилт, тохирлын гэрчилгээгүй, хуурамч баримт бичиг бүрдүүлэн эм нэвтрүүлсэн, эмийн үйлдвэр, эм хангамжийн гэрээт байгууллагаас бусад газраас авсан, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, эм, эмнэлгийн хэрэгсэл нэвтрүүлэхийг оролдсон тохиолдолд импортын зөвшөөрлийг хүчингүй болгоно.

15¹.5.Малын эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн экспортлох болон импортлох зөвшөөрөл нь олгосноос хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.”

2/6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:

“6.4.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий улсын байцаагчтай байх ба хяналт шалгалт хийх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

3/15 дугаар зүйлийн 15.11 дэх хэсэг:

“15.11.Энэ хуулийн 14.1, 14.2, 15.9 дэх хэсгийг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд импортын лицензийг хүчингүй болгоно.”

2 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “үйлдвэрлэгч” гэсний дараа “зөвшөөрөл эзэмшигч” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйл:

“7 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл

“7.1.Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

7.2.Малын эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрлийг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

7.3.Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурыг тусгай зөвшөөрлийн дагуу нийлүүлж байгаа эсэхэд эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

7.4.Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар олгоно.

7.5.Малын эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл хүсэгч доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

7.5.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйл ажиллагааны төрлийг тодорхой дурдсан байх/;

7.5.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

7.5.3.татварын өргүй болохыг нотлох баримт;

7.5.4.татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлд заасан цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байхыг нотлох баримт.

7.6.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 7.5-д зааснаас гадна энэ хуулийн 12.1-д заасан үндсэн шаардлагыг хангасан нотлох баримт ирүүлнэ.

7.7.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгслийн импортлох тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 7.5-д зааснаас гадна үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчийн олон улсын чанар стандартын шаардлага хангасан гадаадын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэгч байгууллагатай байгуулсан худалдааны гэрээ, итгэмжлэл, эсхүл албан ёсны төлөөлөл болохыг нотлох баримтыг ирүүлнэ.

7.8.Энэ хуульд заасан зөвшөөрөлтэй холбогдсон бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2/15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг:

“15.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлоход эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны

байгууллагаас зөвшөөрөл авна. Мал, амьтны тэжээлийн нэмэлт, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлоход мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.”

4 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 дахь хэсгийн “лиценз” гэснийг “зөвшөөрөл” гэж, мөн зүйлийн 15.3 дахь хэсэг, 15.9.4 дэх заалтын “лицензийн” гэснийг “зөвшөөрлийн” гэж, мөн зүйлийн 15.4 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, мөн зүйлийн 15.5 дахь хэсгийн “болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэснийг “асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/25 дугаар зүйлийн 25.20, 25.21, 25.22 дахь хэсэг:

“25.20.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд зааснаас гадна доор дурдсан үндэслэлээр эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүчингүй болгоно:

25.20.1.энэ хуулийн 26.3-т заасан;

25.20.2.шүүхийн шийдвэрийн дагуу;

25.20.3.зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд багц цаг биелүүлээгүй;

25.20.4.зөвшөөрлийн шалгалтад ороогүй, эсхүл тэнцээгүй;

25.20.5.хуульд заасан үндэслэлээс бусад шалтгаанаар хоёр жилээс дээш хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлээгүй;

25.20.6.улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн гэрээний үүргээ биелүүлээгүй;

25.20.7.хуульд заасан үүргээ биелүүлээгүй.

25.21.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд зааснаас гадна доор дурдсан үндэслэлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд олгосон зөвшөөрлийг энэ хуулийн 25.20-д заасан эрх бүхий этгээд хүчингүй болгоно:

25.21.1.байгууллагын болон гадаадын эмнэлгийн мэргэжилтний санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалсан;

25.21.2.байгууллага болон гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн талаар эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;

25.21.3.гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил болон мэргэжлийн алдаа гаргасан нь холбогдох байгууллагаар тогтоогдсон.

25.22.Энэ хуулийн 25.20.6-д заасан гэрээний үүргээ биелүүлсэн тохиолдолд эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг сэргээж болно.”

2/41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг:

“41.3.Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг бүртгэх үйл ажиллагаатай холбоотой хэрэгцээний үнэлгээ хийх, мэргэжлийн үйл ажиллагааны төслийг үнэлэх болон хэрэгцээний тодорхойлолт гаргах шинжээч сонгон шалгаруулах, томилох, шинжээчийн ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хэрэгцээний тодорхойлолт олгохтой холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг, шинжээчид олгох зардлын жишгийг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2 дахь заалтын “эм, эмнэлгийн хэрэгсэл” гэсний өмнө “Хүний” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийн “120” гэснийг “ажлын 10” гэж, 19.14.6 дахь заалтын “нэг жилийн” гэснийг “зургаан сарын” гэж, 19.15 дахь хэсгийн “10 хоногийн” гэснийг “ажлын хоёр өдрийн” гэж, 19.24 дэх хэсгийн “байгууллагад шийдвэр гарснаас хойш ажлын таван” гэснийг “байгууллага болон татварын албанд шийдвэр гарснаас хойш ажлын хоёр” гэж, 25 дугаар зүйлийн 25.3.1 дэх заалтын “үндсэн мэргэшлийн сургалтын” гэснийг “гурван жилийн” гэж, 25.17 дахь хэсгийн “бүртгэлийн хувийн” гэснийг “зөвшөөрлийн дахин давтагдашгүй дугаартай” гэж, 41 дүгээр зүйлийн гарчгийг “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх, худалдах” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/19 дүгээр зүйлийн 19.11, 19.19 дэх хэсэг:

“19.11.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 19.10-т заасан хүсэлт гаргагчийн баримт бичгийг хүлээн авч, өргөдлийг хянан үзэх орон тооны бус шинжээчийн баг томилон ажиллуулах ба баримт бичигт тавигдах шаардлагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.19.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг сунгах, зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах, магадлан шалгах хугацааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5-д заасныг баримтална.”

2/25 дугаар зүйлийн 25.6, 25.9, 25.15 дахь хэсэг:

“25.6.Гадаад улсад анагаах ухааны боловсрол олгох сургууль төгссөн Монгол Улсын иргэн, эсхүл Монгол Улсад анагаах ухааны боловсрол олгох сургууль төгссөн гадаадын иргэн Монгол Улсад резидент эмчийн сургалтад хамрагдах тохиолдолд энэ хуулийн 25.3-т заасны дагуу мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авна.

25.9.Энэ хуулийн 25.8-д заасан гадаадын иргэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр жил хүртэлх хугацаагаар доор дурдсан нөхцөлөөр хялбаршуулсан журмаар олгоно:

25.15.Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох журам, бүрдүүлэх баримт бичиг, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар, холбогдох маягтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, холбогдох зардлын жишгийг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

3/41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг:

“41.1.Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг бүртгэх үйл ажиллагаа, худалдах зөвшөөрлийг эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхэлнэ.”

5 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 120 хоногийн дотор”, 19.20.1 дэх заалтын “хуулийн хүчинтэй” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.20.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 12.1.13 дахь заалт, 12.7 дахь хэсэг:

“12.1.13. Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх;

12.7. Тусгай зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглоно.”

2/20¹ дүгээр зүйл:

“20¹ дүгээр зүйл. Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл

20¹.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1-14.22 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 21.1-д заасан шаардлага хангасан хуулийн этгээдэд эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

3/21 дүгээр зүйлийн 21.9 дэх хэсэг:

“21.9. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1-14.22 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг сонирхогч хуулийн этгээд цахим системээр ирүүлнэ.”

2 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “түдгэлзүүлэх,” гэсний дараа “сэргээх,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.4, 21.5 дахь хэсэг:

“21.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1-14.22 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөл авахад стандартаар тогтоосон үйл ажиллагааны төрөл, суурь үзүүлэлтийг баримтална.

21.2.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.23-14.34 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрөл авахад эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана.

21.4.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авах, тусгай зөвшөөрөл олгох эсэхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

21.5.Энэ хуулийн 21.4-т заасан хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол өргөдөл гаргаагүйд тооцно.”

2/22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг:

“22.3.Тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмын дагуу сунгана.”

3/24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсэг:

“24.1.Тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасан үндэслэл, журмын дагуу түдгэлзүүлж, сэргээнэ.

24.3.Тусгай зөвшөөрөл олгогч нь тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2, 6.3 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй болгоно.”

4 дүгээр зүйл.Эрчим хүчний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, 24.3.1, 24.3.2, 24.3.3, 24.3.4, 24.3.5, 24.3.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Гаалийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын хилээр тарифын бус бусад хязгаарлалттай нэвтрүүлэх бүлэг барааны жагсаалт”-ын 7, 9 дүгээрт “Гаргах” гэсний дараа “оруулах” гэж нэмсүгэй.

2.Мөн хавсралтын 7 дугаарт “Үржлийн мал” гэснийг “Мал” гэж, 9 дүгээрт “Мал, амьтны үр хөврөл, бичил биетний өсгөвөр” гэснийг “Мал, амьтны үр, хөврөл, үржүүлгийн бусад бүтээгдэхүүн” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Энэ тогтоолыг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

